

MONGOLIAN ECONOMY

2015 оны 10 сар, № 18 (097)

www.mongolianeconomy.mn

Үндсэн хуулийн дээр юу байдаг вэ

Монголын нэргүй баатрууд

Сэтгэлгээний хоцрогдол

БА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Хүний эрх ба эдийн засгийн эрх чөлөө



Дэлхийн эдийн засгийн замын зураг

бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

The Economist Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн
“THE WORLD IN 2016” жилийн
дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай
зөвшөөрөл эзэмшигч **“Mongolian Economy”**
сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж
байна.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477

www.marketing@mongolianeconomy.mn

www.info@mongolianeconomy.mn



ҮЗЭЛ БОДОЛ

- Welfare state гэсэн ойлголтын тухайд
- Амьдралаа даатгана гэнэ үү?
- Баялаг бүтээгчид татварын золиос болох ёстой юу
- Данзангийн Доллар
- “Засгийн газар” хэмээх компани
- Эдийн засгийн эрх чөлөө нь хүний эрхээ хэрэгжүүлэх гол нөхцөл
- Хоёр нийгэм дамнасан ойлголтуудын зөрүүг шинжихүй
- Эдийн засгаа аваръя
- Сэтгэлгээний хоцрогдол ба эдийн засгийн эрх чөлөө



ҮЗЭЛ БОДОЛ

- Эрх чөлөөний тухай хэдэн үгс
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Үндсэн хууль ба эдийн засгийн эрх чөлөө
- Яагаад татвар төлөх ёстой вэ?
- Өмчлөх эрх ба үндсэн хуулийн хамгаалалт
- Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох хэрэгцээ, шаардлага
- Монголын нэргүй баатрууд
- Нийгмийн эрүүл мэндийн даатгал уу, халамжийн эрүүл мэндийн даатгал уу?
- Төрийн өмчөөс иргэд хожихгүй байна
- Монголын төрийн оролцоо хэрээс хэтэрлээ
- Үндсэн хуулийн цэцийн дээр юу байдаг вэ
- Хүний эрх, эрх чөлөө өчигдөр ба өнөөдөр

ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



НИЙГМЭЭ ИЛҮҮ НЭЭЛТТЭЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ WWW.MONGOLFORUM.MN-Д НЭГДЭЖ
БҮГДЭЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЖ ЭХЭЛЬЕ

МАНАЙ ОНЛАЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАВУУ ТАЛ НЬ:

- Нээлттэй болон хаалттай хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой
- Текст болон тэмдэгтийн хязгааргүй
- Өөрийн фэйсбүүк, твиттер, и-мэйл хаягаар бүртгүүлснээр хэлэлцүүлэг үүсгэх, хэлэлцүүлэгтээ зочин урьж оролцуулах боломжтой
- Хэлэлцүүлгийн параграф бүр дээр санал, сэтгэгдэл бичих, бичсэн санал сэтгэгдэлд хариу бичих
- Хэдэн ч оролцогч нэгэн зэрэг санал сэтгэгдлээ бичиж хэлэлцэх боломжтой
- Хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй тайланг үзэх боломжтой

МАНАЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАРИМТАЛДАГ ЗАРЧИМ

- Хэлэлцүүлэгт зохисгүй үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох зэрэг хууль бус үйлдэл хийхийг хориглоно
- Хуулийн хүрээнд соёлтой мэтгэлцэх, хэлэлцэхийг гол зарчмаа болгодог.



ЗАЛУУ СУДЛААЧ
ИРЭЭДҮЙН МАНЛАЙЛАГЧ САН

Өмнөх үг

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1-д “ Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалт бий. Гэтэл сүүлийн жилүүдэд Монгол Улсын төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа бизнесийн болон бизнесийн бус бүхий л салбарт хөндлөнгөөс оролцох нь ихсэх хандлагатай болсон нь Танд ч гэсэн мэдрэгдсэн биз ээ.

Иймээс Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн үүрэг, оролцооны зохицуулалтыг иргэдэд сануулах, цаашлаад ардчилсан улс орнуудад төрийн үүрэг оролцоо нь ямар байдаг талаарх дэлхий нийтийн жишиг хандлагын талаархи мэдээллийг нийтэд хүргэх цаг нь нэгэнт болсон байна. Энэ ажлыг эхлүүлэх, хийх нь бидний нийгмийн өмнө хүлээсэн үүрэг гэж үзэн манай “Залуу судлаач-Ирээдүйн манлайлагч” сангаас интернэт /facebook, Twitter/- ийн орчинд **www.mongolforum.mn** цахим хуудсаар төрийн үүрэг, оролцооны талаарх анхны онлайн хэлэлцүүлгийг 2013 оны зургадугаар сард эхлүүлсэн юм.

Үүнээс хойш нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудаар 10 гаруй онлайн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Бид хэлэлцүүлгийн явцад Үндсэн хуулийн үзэл баримтлалд суурилсан нийтлэл, шог зураг, Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалт, дэлхийн нэрт эрдэмтэн судлаачдын хэлсэн онч үгс зэрэг онолын болон хуулийн мэдлэг олгох контентуудыг бүтээж, олон нийтэд түгээсэн.

Цаашид олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг хийх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Ийнхүү эдийн засгийн эрх чөлөөний талаар цахим ертөнцөд өрнөсөн нийтлэл, шог зургуудаа уншигч танд толилуулж байна.

“ЗАЛУУ СУДЛААЧ –ИРЭЭДҮЙН МАНЛАЙЛАГЧ”САН

Дэлхийн алдартай сэтгүүлд сурталчилгаа байршуулах ховорхон боломж

MONGOLIAN
ECONOMY

Дэлхий
2016

Дэлхий нийтийн ирээдүйн таамаг
The Economist Таны ирэх
жилийн хөтөч

Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

The Economist сэтгүүлийн **The World in-2016** жилийн дугаарыг Монгол дахь
албан ёсны тусгай зөвшөөрөл эзэмшигч **Mongolian Economy** сэтгүүл
монгол хэлээр эрхлэн гаргах гэж байна. 2016.01 сард танд хүрнэ

Утас 94092904, 94092905, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn

МӨНГӨӨ ТАРААВАЛ



МӨНГӨӨ ХУРААВАЛ



Шог зургийг А.Амарсайхан

Welfare state ойлголтын тухайд

Г.Агар-Эрдэнэ /Хуульч/

Англи хэлнээ “Welfare state”, Герман хэлнээ “Sozialstaat” гэсэн нэршил байдаг. Үүнийг халамжийн төр, ивээлт төр, халамжит төр гэх мэтээр орчуулан хэрэглэх нь бий. Тэгвэл энэ нь чухам ямар утга агуулгатай ойлголт болохыг цухас авч үзье.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтоор бол энэ нь иргэдийнхээ сайн сайхан амьдрах эдийн засаг, нийгмийн баталгааг ижил тэгш боломжийн үндсэн дээр бүрдүүлэн ажиллаж буй төр юм. Орчин үед Скандинавын хойгийн улс орнууд гэгддэг Исланд, Норвеги,

Швед, Финланд, Дани зэрэг нь дээрх ойлголтод хамаарах бодлогыг бүрэн утгаар нь хэрэгжүүлж буй улсуудын сайн туршлага болж байна. Эдгээр улс төрийн сан хөмрөгийг эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд болон хувь хүнд шууд чиглэсэн үйлчилгээнд зарцуулдаг. Энэ

нь мэдээж татвар төлөгчдийн мөнгө. Иймэрхүү халамжийн бодлоготой улсуудыг өөрөөр “холимог эдийн засаг бүхий улсууд” ч гэж нэрлэх нь бий. Ардчилал, хүний эрхийн өлгий болсон Америкаас эхлээд төвлөрсөн эдийн засгийн тод жишээ болсон Куба улс ч ийм эдийн засагтай орнуудын тоонд багтдаг. Төр бодлогоороо баян, ядуугийн хоорондын зааг ялгааг багасгахын тулд ийм арга хэмжээ авдаг бөгөөд холимог эдийн засгийг бүрдүүлж буй гол хөрөнгө нь баян чинээлэг хэсгийнхний орлогын албан татвар байдаг.

Төрийн халамжийн бодлого нь ялгаатай хэрэгжиж буй улсуудын гурван загварыг Данийн социологич Госта Эспинг Андерсен тодорхойлсон байдаг. Эхнийх нь социал-демократ бодлого, удаах нь христиан-демократ бодлого болон либерал бодлого бүхий улсууд болно. Социал-демократ бодлого бүхий улсууд иргэний харьяалалд суурилсан халамж, үйлчилгээг үзүүлдэг. Жишээ нь, Бруней, Катар, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улс зөвхөн иргэддээ чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлж, харин гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ үйлчилгээ хаалттай байдаг. Энэ бүлэгт мөн Скандинавын хойгийн орнууд ордог.

Тэгвэл христийн-демократ улсууд нь төвлөрлийг сааруулах зарчим буюу нийгмийн даатгалын тогтолцоогоороо дамжуулан халамжийн бодлогоо хэрэгжүүлдэг. Энд Австри, Бельги, Франц, ХБНГУ тэргүүтэй Европын хэд хэдэн улсыг нэрлэж болно. Австриар жишээ авахад төр нь чөлөөт нийгмийн тогтолцоог авч явахад хамгийн гол

үүрэг бүхий ажил үйлчилгээ эрхэлж буй хүмүүсийн нийгмийн хамгаалалд бодлогоо төвлөрүүлж, өвчлөл, осол гэмтэл, ажилгүйдэл, тэтгэвэр зэрэгт нь анхаарлаа хандуулдаг.

Харин либерал бодлого бүхий улсууд нь чөлөөт зах зээлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхдээ халамжийг ядуурлыг бууруулах, иргэдийнхээ суурь хэрэгцээг хангахад чиглүүлдэг ажээ. Энэ ангилалд Австрали, Япон, АНУ, Канад зэрэг орныг багтааж болно.

Гэвч төрийн халамжийн бодлого нь хэрхэн хэрэгжиж байгаагаас хамаарч энэ нь ардчилсан, коммунист, дарангуйлагч эсвэл фашист төрийн хэлбэрийг тодорхойлоход хүргэдэг.

Хуучин цагт буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байхад төрийн халамжийн бодлого хэт хийрхэлд автаж, төр хайр хишгээ тарааж буй мэтээр иргэдээ сэнхрүүлж, төрийг дээдлэн шүтэх үзэл газар авч байлаа. Ийм тогтолцоонд татвар төлөгчдийн мөнгө иргэдийн хүсээгүй зүйлд зарцуулагдаж, иргэд нь ирээдүйд илүү сайн сайхан ажил хөдөлмөр эрхлэх урам зориггүй болж, хувь хүний хөгжил зогсонги байдалд ордог.

Гэтэл зүй нь төр халамжийн бодлогоо хувь хүний эрхэмсэг оршихуйг дээдлэн хүндэтгэх явдалд л чиглүүлэх ёстой гэж орчин үеийн судлаачид үздэг. Хувь хүн өөрийн үнэ цэнэ, эрхэмсэг оршихуйгаа мэдрэх тэрхүү боломжийг төрийн халамжийн бодлого бүрдүүлэх ёстой бөгөөд эдгээрийн тод жишээ бол Скандинавын орнуудын боловсролын тогтолцоо юм. Эдгээр улсад бага, дунд, дээд боловсрол үнэ төлбөргүй бөгөөд

үүний дараа бие даан амьдрах, өөрөө өөртөө эзэн байх асуудлыг тухайн хувь хүнд бүрнээ даатган хариуцуулах ухамсрыг төлөвшүүлэхэд төрийн халамжийн бодлого нь чиглэдэг. Үүнийг мөн “нуугдмал халамжийн бодлого” гэж нэрлэх нь ч бий.

Учир нь төр чөлөөт эдийн засгийн тогтолцоонд хуруугаа дүрэхгүйгээр, эдийн засагт дарамт учруулахгүй секторыг сонгож бодлогоо хэрэгжүүлж чадвал сайнаар үнэлэгдэнэ гэсэн үг. Үндсэндээ зөв газраа, зөв цагт, зөв хүндээ халамжийн бодлогыг чиглүүлж чаддаг улсууд “Welfare state” ангилалд багтана гэсэн үг.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл “Welfare state” гэдгийг нийгмийн халамжийн тогтолцоог бүх нийтийн сайн сайхан байдлыг хангахад чиглүүлдэг улс гэж ойлгож болно. Монголын төр хавтгайрсан халамжийн оновчгүй бодлого хэрэгжүүлэхгүй байхад сайтар анхаарч, ирээдүй хойч үе, иргэнийхээ сайн сайхан амьдралыг бүрдүүлэхэд чиглэсэн зөв бодлогыг бий болгоход анхаарч ажиллах цаг болжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах тухай заалт бий. Энэ заалт болон дээрх ойлголт хоёрыг зөв ойлгон хэрэглэж бодлогоо хэрэгжүүлж хэвшвээс хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг хөгжүүлэх тухай Үндсэн хуулийн эрхэм зорилго биелэх учиртай юм. ■

Амьдралаа даатгана гэнэ үү?

Д.Жаргалсайхан /Уул уурхайн эдийн засагч/

Даатгалыг муу ёролсон, хэрэггүй гэж үздэг ойлголтууд хуучирч даатгалын ач тусыг нийгмээрээ ойлгодог, бас ч үгүй хэрэглэдэг болж байна. Бидний, монголчуудын сонгож авсан нийгмийн тогтолцоонд даатгалгүйгээр ямар ч хүн

сайн сайхан амьдралын тухай санасны гарз. Ийнхүү даатгал бидний өдөр тутмын амьдралд нэвтрэхийн хэрээр та бид даатгалын тухай ойлголтоо сайжруулах бодит шаардлагатай нүүр тулж байна.

Таваар мөнгөний харилцаа хүн

төрөлхтөний амьдралд нэвтэрснээс эхлээд л даатгалын хэрэгцээ бий болж, улмаар ийм үйлчилгээ нэвтэрч байсныг Хятад, Египетийн түүхийн эх сурвалжуудаас мэдэж болно. Зах зээлийн харилцаа хөгжсөн улсуудад даатгалын үйлчилгээ мөн л сайн хөгжиж

нийгэмд гүйцэтгэдэг үүрэг нь даатгагдсан иргэдэд хүрдэг үйлчилгээнээс халин, улмаар тухайн нийгмийн өмнө тулгарч байгаа олон асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэл нь болсон байх юм.

Олон улсад даатгалыг ерөнхийд нь life insurance болон non-life insurance буюу амьдралын даатгал, амьдралын бус даатгал гэж ангилдаг. Амьдралын даатгалыг мөн урт хугацааны даатгал гэдгээр нь ч тусад нь ангилж болно. Ийнхүү тусдаа ангилах шаардлага нь амьдралын болон амьдралын бус даатгалын үйлчилгээний ялгавартай мөн чанараас үүдэн гарч байгаа хэрэг. Амьдралын бус даатгалыг general буюу ердийн даатгал гэдгээр нь манайхан илүү сайн мэднэ.

Та бидний сайн мэддэг “Wikipedia” хэмээх нэвтэрхий тольд дурьдсанаас үзэхэд 84 төрлийн даатгал байдаг. Энэ нь улс төрийн, хариуцлагын, эд хөрөнгийн, далайн тээврийн, газар хөдлөлтийн, аюул ослын, нислэгийн, эрүүл мэндийн, тээврийн хэрэгслийн, зээлийн, гэмт хэргийн гээд л их олон төрөлд ангилагддаг гэсэн үг. Тэгэхдээ төрөл бүрийг нь задлаад үзвэл дотроо мөн олон ангилна. Тухайлбал, эд хөрөнгийн даатгал гэхэд л дотроо хүний эдэлж хэрэглэдэг эд хөрөнгийн төрөл бүрээр, тодруулбал малын, орон сууцны, цахилгаан барааны, тээврийн хэрэгслийн гэх мэтээр дотроо хуваагдана.

Амьдралын даатгал нь ердийн даатгалаас юугаараа ялгаатай вэ ?

Юуны өмнө амьдралын даатгал нь хүний биеийг бүрдүүлдэг эд эрхтэний үйл ажиллагаанд цаг хугацаа болон гаднын бусад хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн бий болдог өөрчлөлтүүдээс улбаалан бий болдог тохиолдлуудад үйлчилдэг даатгал.

Лавшруулан үзвэл хүний насжилт, өвчлөл, гэнэтийн ослоос үүдэн бий болсон тохиолдлууд хамаарна. Жишээ нь, өвчний улмаас тухайн даатгуулагчийн бие эрхтэнд гэмтэл учирч эмчилгээ хийлгэсэн бол даатгалаас эмчилгээнийхээ зардлыг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн гаргуулна. Өөр нэг жишээ бол хүний нас ахисаар бие мах бодь нь хөгширч, улмаар хөдөлмөрлөх чадваргүй болж бидний хэлж заншсанаар тэтгэвэртээ гарах үед амьжиргааны зардлаа тэтгэврийн хэлбэрээр даатгалын байгууллагаас

авна.

Тэгвэл ердийн даатгал нь хүний бие мах бодиос тусдаа, хамааралгүй даатгалын тохиолдлуудад үйлчилдэг. Тухайлбал, газар хөдлөлтийн улмаас орон сууц, байранд гэмтэл, хохирол үүссэн бол тухайн гэмтэл хохирлыг үнэлээд нөхөн олговрыг даатгалын байгууллагаас гаргуулан авна. Цаг агаарын ноцтой, хүнд нөхцөл байдлын улмаас мал сүрэг үхэж, үрэгдвэл даатгалын байгууллага нь холбогдох нөхөн төлбөрийг төлнө.

Амьдралын даатгал, ердийн даатгалын бас нэг том ялгаа нь амьдралын даатгалын тохиолдол нь тухайн хүний хүсэл эрмэлзлээс үл хамааран амьдралд хэзээ нэгэн цагт заавал бий болдог бол ердийн даатгалын тохиолдол нь хэзээ ч бий болохгүй байх магадлал бийд оршино. Жишээ нь, хүн хөгширнө, өвчинд нэрвэгдэнэ бас үхнэ. Үхдэггүй, өвчилдөггүй, хөгширдөггүй амьдралыг хүн төрөлхтөн бий болгож амжаагүй л явна. Ийм л ялгаатай учраас хүн төрөлхтөн өдий болтол даатгалыг амьдралын даатгал, амьдралын бус даатгал гэж ангилаад хүнийг нь амьдралын даатгалд, эд баялгийг нь ердийн даатгалд хамруулдаг болсон юм.

Энэ ялгаа нь эцэстээ даатгуулагчийн авч байгаа үйлчилгээний мөн чанар, түүний төлбөрийн хэмжээний ялгаагаар илэрнэ. Жишээ нь, хүн аливаа эрсдэлд орж амь насаа эсвэл хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдлын давтамж, магадлал нь өмч хөрөнгө гал түймэр, газар хөдлөлтөд өртөж үнэ цэнээ алдах эсвэл мал сүрэг байгалийн гамшигт өртөж үхэж үрэгдэх тохиолдлоос ялгаатай байдаг. Иймд хүн амь нас, хөдөлмөрийн чадвар алдах тохиолдлыг ердийн даатгалд даатгуулахыг өвдөж шаналсан хүнийг мал эмнэлэгт эмчилж байгаатай зүйрлүүлж болох юм.

Өөр нэг жишээ бол манай нийгмийн даатгал. Нийгмийн даатгалын үйлчилгээг бүхэлд нь авч үзвэл энэ нь төр иргэдийг амьдралын даатгалд бүхэлд нь нэгдсэн журмаар хамруулж байгаа үйлчилгээ юм.

Амьдралын даатгал нь даатгуулсан иргэдэд ашигтайгаас гадна нийгэмд өөр олон хэлбэрээр үр өгөөжөө өгнө. Тухайлбал, амьдралын даатгалын нөөц сангуудыг орон сууцны урт хугацааны зээлийн эсвэл дэд бүтцийг барьж байгуулах ажлыг санхүүжүүлэх эх

үүсвэрт ашиглана.

Мөн Засгийн газрын урт, богино хугацааны үнэт цаасыг худалдан авахад эх үүсвэр болгодог аж. Өөрөөр хэлбэл, амьдралын даатгал нь нийгэмд нэгэнт бий болгосон орлогыг хэрэглээнд бус хуримтлал болгон нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой, хамгийн гол нь оролцогч бүх талуудад ашигтай санхүүгийн хэрэгсэл юм. Манай улсын хувьд иргэд болон төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг баталгаажуулахад чиглэгдсэн олон санал санаачлагуудыг улс төрийн намуудын зүгээс санаачилсан байдаг. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийн нийгмийн хамгааллын баталгааг бий болгосон.

Ажил, үүргээ биелүүлж яваад амь насаа алдах, хөдөлмөрийн чадваргүй болох, эрүүл мэндээрээ хохирох гэх мэтийн тохиолдлууд гарвал төрөөс тэрхүү албан хаагчид мөнгөн олговор олгохоор хуульчилсан байна. Энэ төрлийн нийгмийн хамгаалалтуудыг тодорхой санхүүгийн хэрэгслийг ашиглан хэрэгжүүлдэггүйн улмаас төсвийн орлогоос хэт хамааралтай, жигд хүрч чаддаггүй, хүртээмж муутай төдийгүй төлөвлөлтийн болон бусад хүндрэл гарч байгаа.

Тэгвэл амьдралын даатгалын хэлбэрт шилжүүлснээр дээрх хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлээд зогсохгүй нэгэнт бий болсон хуримтлалыг эдийн засгийн бусад салбарт оруулах боломжтой болох юм.

Өөр нэг жишээ бол хүүхдийн мөнгө. Сонгуульд аль болох олон санал сонгогчдоос авах гэсэн улс төрийн намуудын эрмэлзлээс үүдэлтэй энэ халамжийн хэлбэр нь сүүлийн үед шүүмжлэлд маш ихээр өртөж буй. Улсын төсөвт маш их дарамт учруулдаг, хавтгайрсан халамж, инфляци хөөрөгддөг, иргэдийг залхуу болгодог, хүүхдэд өөрт нь наалдац муутай зэрэг олон сөрөг үр дагавар гарсаар байгаа. Тэгвэл төр хүүхдүүдийг эцэг эхтэй нь хоршиж Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд хамруулбал дараах давуу байдлууд үүсэхээр байна.

Үүнд:

-Төсвийн зардал буурна

-Хүүхдийн ирээдүйн сурч боловсрох эрх баталгаатай болно

-Хөрөнгийн зах зээл дээр төлбөрийн чадвар сайтай үндэсний хөрөнгө оруулагч бий болно.

-Орон сууцны урт хугацааны боломжийн хүүтэй зээлийн эсвэл дэд бүтцийг барьж байгуулах санхүүгийн эх үүсвэр нэмэгдэнэ

Ажил олгогчид хүний нөөцтэй холбоотой олон хүнд асуудлыг амьдралын даатгалыг ашиглан оновчтой шийдвэрлэдэг аж. Тухайлбал, ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах нь аль ч ажил олгогчийн хувьд бизнесээ тогтвортой, амжилттай байлгах үндсэн

нөхцөл байдаг. Өнөөдөр Монголд ажил олгогчид ажилтандаа машин, орон байр авч өгөх, гадаад дотоодод аялуулах, бонус олгох, бараа бүтээгдэхүүнээ хямдралтай үнээр худалдах зэрэг аргыг өргөн хэрэглэж байна.

Тэдгээр нь хүртээмж муутай, өндөр өртөгтэй, хамгийн гол нь ажилтан ажил олгогч хоёрын сонирхлыг урт хугацаанд хослуулж чаддаггүй сул талтай. Ийм ч учраас сүүлийн үед ажил олгогчид байгууллагадаа тэтгэврийн сан үүсгэх санаачлага их гаргадаг болжээ. Гэтэл энэ нь ерөнхийдөө хамтарч хуримтлал

үүсгэх зөв хандлага боловч бас нэг том сул талтай.

Үүсгэсэн хуримтлалын менежментийг хэн хийх, хэн хариуцлага хүлээх, ямар хариуцлага хүлээх вэ ? гэдэг асуултууд хариултгүй байгаад дээрх хандлагын сул тал байгаа юм. Тэгвэл ажил олгогч ажилтан хоёр хоршиж ажилтнаа эсвэл ажилтны гэр бүлийн гишүүнийг хуримтлалын даатгалд даатгуулж хуримтлал үүсгэвэл дээрх асуудлуудыг оновчтой шийдвэрлэж ажилтан тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх боломжтой. ■



Баялаг бүтээгчид татварын золиос болох ёстой юу

Ё.ЭНХБАЯР (Философич)

Татвар ард түмний сайн сайхны төлөө бүхнийг хийнэ гэсэн төрийн амлалтын хариуд төлж буй үйлчилгээний хөлс юм.

Ард түмэн оршихуйн үндэс бол төр засаг, төр оршихуйн үндэс бол татвар билээ. Аливаа төр иргэдийн татвараар

амьдарсаар ирсэн бөгөөд тэрхүү хураасан татвараараа иргэддээ буцааж хэрэгтэй зүйл хийсэн эсэхээрээ л сайн, муу гэж үнэлэгдэн түүхэнд бичигддэг ажээ. Түүхэнд хураасан татвараараа ард түмэндээ хэрэгтэй зүйлсийг бүтээж, хүн амаа өсгөж, газар нутгаа тэлж, зам тээвэр, харилцаа холбоогоо

хөгжүүлж, хот тосгон байгуулж, техник технологийг бүтээж, ард түмнээ “хөл хөсөр, гар газар” сэтгэл амгалан амьдруулсан ухаантай төр ч байна, хэрэгтэй хэрэггүй дайн байлдаанд үрж, газар нутгаа алдаж, хот тосгоноо устгуулан шатаалгаж, ард түмний амь насыг аюулд оруулсан ухаан мулгуу, цагийн эрхшээлээр доройтон буурсаар ард түмэнтэйгээ мөхсөн ядмаг төр ч бас байна. Тиймээс хураасан татварыг хэрхэн, юунд зарцуулж буй нь төрийг тодорхойлох нэгэн арга мөн билээ.

Татварыг баялаг бүтээгчид өөрийн бүтээсэн баялгаасаа тодорхой хувийг өөрийн хийж чадахгүй сайн үйлийн төлөө төрдөө өгдөг, төр нь ч “нийтэд тустай юм хийнэ” хэмээн амалж татвар авч, өөрөө түүнийхээ өчүүхэн хэсгээр нь амьдраад, бусдыг нь нийтийн сайн сайхны төлөө зохистой зарцуулах онцгой эрх авдаг учиртай билээ. Төр, ард түмэн хоёрын хамгийн чухал тохиролцоо энэ юм. Иймээс энэхүү нийтлэлээр татвар төлөхгүй тухай биш харин татварыг хэрхэн тэгш шударгаар хураах, хэрхэн зохистой зарцуулах тухай өгүүлэх юм. Миний төлсөн татвараар муу юм хийгээд байхыг ард түмэн “сонгууль” хэмээх хэлцлээр байгуулсан төрд бид зөвшөөрөх ёстой юу? гэсэн асуултад хариу олох гэж нэгэн эрэл хийлээ.

Төр Монголын баялаг бүтээгчдийн татвараар амьдардаг хувалз байх ёсгүй

Амьд биетийг шимэгчлэн цусыг нь сорж амьдардаг, улмаар нөгөө амьтнаа үхэлд хүргэдэг нэгэн төрөл паразетийг хувалз гэдэг. Хувалзны гол онцлог нь өөрөө томроод л байдаг, нөгөө амьтан нь турж жижигэрч, эцэст нь үхдэг.

Монгол Улс 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу тэнцвэржүүлсэн орлогоор 2014 онд 6.8 их наяд төгрөгийн орлого олох гэнэ. Үүний 6.2 их наяд нь нь татварын орлого, үлдэх 637 сая төгрөг нь татварын бус орлогоос бүрдэхээр төсөвлөсөн байна. Гэтэл 2014 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 353.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 21.3 хувиар буюу 95.7 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого татварын орлогоор 85.0 хувь, татварын бус орлогоор 15.0 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна. Ерөнхийдөө татварын орлого асар ихээр тасарч, улсын төсвийн алдагдал нэмэгдэж төсөв бүхэлдээ хүндрэх төлөв ийнхүү эхний улирлаасаа ажиглагдаж эхэллээ. Ачааг нь төр биш баялаг бүтээгчид л үүрнэ. Одоо баялаг бүтээгчид руу улам ихээр дайрч л таарна. Өөр тэжээгч байхгүй юм чинь, төрд.

Монгол Улсын төсвийн орлого 2010 онд 3.1 их наяд, 2011 онд 3.3 их наяд, 2012 онд 5.8 их наяд, 2013 онд долоон их наяд болон өсчээ. Орлого өсөхийн хэрээр төсвийн зарлага өсөөд явж таараа. Ингэж сүүлийн дөрвөн жилийн дотор улсын төсөв хоёр дахин томорсон байна. Бидний амьдрал, бидний амьдран буй орчин хоёр дахин сайжирсан уу гээд та өөрөөсөө асуу. Төгрөгийн худалдан авах чадвар хэд дахин суларч, импортоос улам их хамааралтай болсон, төрийн хүнд суртал, чирэгдэл улам нэмэгдсэн, амьдран суудаг орчин улам муудсан (шороо тоос, утаа бүр л нэмэгдсэн), нийслэлд бараг алхах газаргүй болсон, хамгийн гол нь танаас авдаг төрийн татварын нэр төрөл л нэмэгдсэн байх вий. (Хамгийн сүүлд нийслэлийн авто машинтай хүн бүхэн муу зам дээр явсныхаа төлөө төрийн торгууль ч гэмээр авто зам ашигласны татвар төлдөг болсныг хүн бүхэн мэдэж байгаа. Ингэснээр нийтийн тээврээр явдаг

иргэдээс автомашинтайг нь ялган татвар оногдуулсан билээ). Ийм төр ухаантай төр үү? Нөгөө цомхон ухаалаг төр хаачсан бэ? Бид ухаантай төрийн төлөө биш хувалз төрийн төлөө яваад байгаа биш үү. Төр нь улам томроод татвар нь улам нэмэгдээд ард түмэн улам ядуураад байдаг.

Монголын төрийн албан хаагчдын тоо 2014 онд 169448 болж. Энэ тоо 2013 онд 162769, 2012 онд 161612, 2011 онд 155679, 2010 онд 148223 байжээ. Сүүлийн дөрвөн жилийн дотор төрийн албан хаагчдын буюу татвараар “тэжээлгэгчдийн” тоо 12.6 хувиар өссөн байна. Бидэнд үзүүлдэг төрийн үйлчилгээний чанар, хүртээмж 12.6 хувь өссөн болов уу. Ингэж шууд утгаар нь харьцуулж асууж болохгүй ч бодох л асуудал.

Уг нь төрийн үрдэг мөнгө, албан тушаалтны тоо ихсэх биш багасаж, техник, технологи ашиглаж, хүний хүчин зүйлийн оролцоог багасгаж байж хэмнэсэн, хуримтлуулсан мөнгөөрөө зам харилцаа, дэд бүтэц, гудамж талбайгаа засаж сайжруулах, шинээр барих гэх мэт ард түмэнд хэрэгтэй зүйлдээ хөрөнгө оруулмаар санагдах юм. Монголын төр олсныхоо хэрээр зардаг тооцоо муутай, юм үзээгүй ядруухан хүнтэй адилхан санагдаад болдоггүй. Их олвол их зараад, бага олвол багасгачихдаг, хурааж хуримтлуулж, өөдөлж томорч чаддаггүй нэгнийгээ бид “арчаагүй нэгэн” гэж нүд үзүүрлэдэгсэн.

“Татвар төлж байж л төр засаг байна” гэдгийг ойлгочихсон ард түмэн татвар төлөхгүйн төлөө биш харин төлсөн татварыг төр гэдэг хувалз хуу сорчихоод өөрсдөд нь хэрэгтэй зүйл хийхгүй байхыг л хүсэхгүй байгаа. Төр томорч биш жижгэрч төсөв мөнгөө хэмнэж, улам ухаалаг болж байж бидний татвараар хураалгасан мөнгийг нийгэмд зүй зохистой хуваарилах ёстой. Төр хувалз шиг биш харилцан тохиролцсон, харилцан биедээ ашиг тустай буюу ходоодны ашигтай бактери шиг ажиллах ёстой биш үү.

Монголын татварын тогтолцоо торгуулийн системээр явж байна

Төр ямар баялаг бүтээдэг вэ? Бүтээдэг юм бас байна аа. Улсын мэдэлд байдаг барилга байгууламж, гудамж талбай, дэд бүтэц зэргийг хийж бүтээдэг үү гэвэл бүтээдэг. Гэхдээ гардан хийдэг нь нөгөөх л хувийн хэвшил, төлдөг мөнгө нь татварын мөнгө л байдаг. Тэгэхээр эцсийн дүндээ төр баялаг бүтээдэггүй, хуваарилдаг тул баялгийг хувийн хэвшил бүтээдэг нь туйлын үнэн. Бидний хэрэглэж буй байшин барилга, машин техник, цахилгаан хэрэгсэл, компьютер, гар утас, хоол хүнс гээд бараг бүгдийг л хувийн компаниуд хийдэг биш үү. Төрийн малчин, ногоочин, барилгачин гэж алга л байна. Харин төрийн албаны дүрэмт хувцас өмссөн эсхүл албаны хувцас, зангиа зүүсэн дарга, цэрэг л байна. Тэд иргэдийн төлөө биш иргэд өөрсдийнх нь төлөө байгаа гээд итгэчихсэн байдаг. Ажлын хувцас өмсдөг төрийн албан хаагч ер нь цөөн. Тэд татварын мөнгийг үрдэг л хүмүүс юм шүү. Хэдий эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн байгууллага улсынх байдаг ч хамгийн муу менежменттэй нь төрийнх, хамгийн мундаг нь хувийнх байдаг. Жишээ нь, хамгийн сайн сургалттай дунд сургууль хувийн дунд сургуулиуд л байна.

Бүх зүйлийг хувийн хэвшил бүтээдэг тул тэдгээрээс тэгш, шударга татвар авах ёстой. Яавал шударга, тэгш татварын тогтолцоо байх вэ гэсэн эрэл хүний нийгэмд өнөөдөр ч үргэлжилсээр байгаа. Төгс шийдлээ олоогүй л байна. Гэсэн ч өндөр хөгжилтэй орнуудад татварыг харьцангуй тэгш,

шударгаар оногдуулж бас татвараа авч чаддаг тогтолцоотой билээ.

Монголд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд л татвар төлдөг. Төлөхдөө асуудалтай төлдөг. Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр улсын хэмжээгээр 72.9 мянган аж ахуйн нэгж байна. Тэдгээрийн 50 хувь нь үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү үйл ажиллагаа явуулдаг компаниудын бараг 90 хувь нь жижиг, дунд үйл ажиллагаатай компаниуд гэсэн статистик бий. Эдгээрийн ихэнх нь татвараас зайлсхийдэг, үнэн зөв мэдүүлдэггүй, санхүүгийн хоёр тайлантай байдаг нь нууц биш болчихсон. Татвараа шударгаар, үнэн зөв төлвөл тухайн аж ахуйн нэгж бараг л ашиггүй ажилладаг эсвэл илүү ашигтай ажиллах гэсэн “шуналтай” нь холбоотой. Нууж байгаа гэдгийг нь ч татварынхан мэддэг юм билээ. Нуусных нь зоргоор төр мэдээгүй царай гарган өгсөн тайланг нь авч татварыг нь хурааж байна гэдэг нэг л сэжигтэй. Тэр бол авлига гэдэг нь тодорхой. Ийм л гинжин хэлхээгээр татварын тогтолцоо өнөөдөр хамгийн муу тогтолцоо байсаар байна. Том, жижиг гэж ялгахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол бүгдээс нь тэгшээр татвараа хурааж чаддаг, тэднийхээ араас татварынхан нь явж чаддаг, аж ахуйн нэгжүүд бултаж зугтдаггүй байх бүх нөхцөлийг хуулийн хүрээнд бүрдүүлж чадсан төр хамгийн хүчирхэг бас хамгийн баян төр байхсан. Одоо бол “татвараа шударгаар төлснийх нь хохь, нуусных нь зол болдог” тогтолцоо яваад байна. Тиймээс бүгд л аргалж чаргалах, нуух хаах, авлигадаж хулгайлахаа л бодож байна. Гадуур явж татвараа хураадаг байцаагч нар хэр олон бол. Өрөөндөө суугаад, дуудаад л ном журмаараа яваа нэгнийг нь дарамтлаад суугаа харагддаг.

Төр муу болохоор л татварын байгууллагууд нь муу байгаа хэрэг. Муу ноёны сайн албат байхаар үнэхээр сайн, шударга албат мөн бол ноёно солиод төрийн албан хаагчаа болиод хувийн сектор руу явна шүү дээ. Амьдрал дээр ийм зүйл болохгүй байгаа нь тогтолцоо ямар байгааг харуулна. Хувийн хэвшлээс төр рүү шилжих хүсэл их байхаас төрөөс хувийн хэвшил рүү шилжих хүсэл нийгэмд бараг л алга байна. Зовж, зүдэрч хувийн хэвшилд байснаас төрд бэлэн зэлэн байх нь ашигтай болоод л тэр бизээ.

Төр торгуулийн систем шиг ийм татварын тогтолцоотой яваад байвал хэт томорсон, үрэлгэн бодлогогүй дээрээ авах ёстой татвараа ч хурааж авч чадахгүй эцэст нь хоногийн хоолоо яая даа гэж яваа жирийн нэг автомашинтай иргэн рүү дайрна, зогсооно, татвараа төл гэж дарамтлана.

Татварын орлогоо бүрдүүлэх хамгийн том гарц

Ном журмаараа яваа нэг нь улам торгуулдаг татварын тогтолцооноос бултдаг, зугтдаг бизнес эрхлэгч, хувиараа орлого ологчийг олж татвараа авдаг тогтолцоотой болмоор байна. Энэ нь далд эдийн засагтай татварын тогтолцоогоор дамжуулан тэмцэхийн хамт татварын орлогоо бүрдүүлэх нэгэн арга зам.

ОУВС-гаас гаргасан судалгаагаар Монгол Улс орлогынхоо 67 хувийг авч чаддаг, далд эдийн засаг нь 33 хувьтай байгаа гэнэ. Бодит байдал дээрээ үүнээс ч их байгаа гэж харднам. Ерөнхийдөө Монголын төр уул уурхайгаас ихээхэн хамааралтай бөгөөд уул уурхайгаас татвар авах нь зүй ч татварынхаа ихэнхийг үүгээр бүрдүүлж буйгаас л улсын төсвийн донсолгоо бий болж байгаа. Үүний оронд төрд бүртгэлгүй хэдэн зуун мянган жижиг, дунд бизнесээ эрхлэгчдээсээ татвараа хурааж



“Монголд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд л татвар төлдөг. Төлөхдөө асуудалтай төлдөг. Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр улсын хэмжээгээр 72.9 мянган аж ахуйн нэгж байна. Тэдгээрийн 50 хувь нь үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү үйл ажиллагаа явуулдаг компаниудын бараг 90 хувь нь жижиг, дунд үйл ажиллагаатай компаниуд гэсэн статистик бий. Эдгээрийн ихэнх нь татвараас зайлсхийдэг, үнэн зөв мэдүүлдэггүй, санхүүгийн хоёр тайлантай байдаг нь нууц биш болчихсон. Татвараа шударгаар, үнэн зөв төлвөл тухайн аж ахуйн нэгж бараг л ашиггүй ажилладаг эсвэл илүү ашигтай ажиллах гэсэн “шуналтай” нь холбоотой”

чаддаг болмоор байна. Хувиараа бизнес хийдэг, орлого олж буй хүн бүрийг бүртгэдэг, татвараа авдаг, эргээд харж үздэг, хөнгөлдөг, урамшуулдаг, хөнгөлттэй зээлээр тэтгэдэг болмоор байна.

Хаа сайгүй “хувиараа” гэдэг тодотголтой хэдэн зуун мянган бизнес эрхлэгч байна. Өдөр бүр телевиз, зарын сонингоор дамжин зарагдаж буй орон сууц, гэр байшин, хашаа, газар, машин техник, түүхий эд, хоол хүнс гээд тооцвол маш их хөрөнгийн асуудал, маш их нуугдмал татвар хураах нөөц бололцоо харагдаж байна. Ийм бүртгэлгүй бизнес хийж буй хүмүүс бол хэзээ ч татвар төлж үзээгүй, компани байгуулдаггүй, байгуулвал болохгүй гэж мэддэг хүмүүс. Би лав хар захуудын тэр олон наймаачин, дэлгүүрийн түрээслэгчид, түүхий эдийн, модны, нүүрсний, махны гэх мэт ченжүүдийг, бас мал мах, түүхий эдээ зарж борлуулж буй малчдыг татвар төлж байна гэж сонсоогүй. Хамгийн ойр жишээ нь гэрийн хажуу дахь хүнсний дэлгүүрээсээ талх авахад үнийн дүнгийн 10 хувь нь улсын татварт очдог гэж би лав итгэдэггүй. Учир нь ихэнх дэлгүүрт бэлнээр мөнгөө төлдөг, ямар ч кассын машингүй, баримтгүй наймаа л явж байдаг. “Орлогыг нь тухай бүр тодорхойлох бололцоогүй иргэдийн татвар” гэдэг билүү, хуулийн хэллэг

нь. Орлогыг нь тодорхойлох бололцоогүй биш тодорхойлж чаддаг тийм тогтолцоог, ард иргэд юугаа ч нууж болдоггүй тийм тогтолцоотой болох тухай энд яриад байгаа юм шүү.

Бүртгэлгүй, баримтгүй, бэлэн мөнгөний ямар ч наймаа, арилжаа эцсийн эцэст далд эдийн засагт орж төрийн хүчгүй байдалд нөлөөлдөг нь илэрхий зүйл. Яагаад бүх дэлгүүр, захын наймаачид, ченжүүдэд, хувийн бизнес хийдэг хүмүүст “cash bill”-тэй болох шаардлага тавьж болохгүй гэж. Яагаад заавал аж ахуйн нэгж биш юмаа гэхэд бүртгэлтэй хувийн бизнес эрхлэгч болгож болохгүй гэж. Хууль эрх зүйн зохицуулалтыг нь хийж болох л эд.

Орлого олсон хүн бүрээс биш гэхэд ядаж талаас нь татвараа хураагаад байвал баялаг бүтээж, ном журмаараа яваа шударга нэгнээ татвараар дарамтлахгүй, улмаар өсөж өндийж, “томроход” нь дэмжиж тусалж, улс орондоо том бүтээн байгуулалт хийлгүүлж болохгүй гэж. Өмнөд Солонгосын эдийн засгийг “Samsung”, “Hyundai”, LG, “Kia”, “Daewoo” авч явдаг гэдэг шүүдээ.

Хувийн хэвшил л улс орныг хөгжүүлдэг билээ. Тэднийг татвараа төлвөл улам шийтгэдэг биш харин дэмждэг тогтолцоотой болох хэрэгтэй. ■



Данзангийн Доллар

А.Билгүүн /Эдийн засагч/

Солийн Данзан хэмээх эрхэмийн тухайд, сайнаар ч, саараар ч түүхэн тэмдэглэлүүдэд ихээхэн дурьджээ. Сонирхоод үзвэл яах аргагүй Монголын тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэж явсан нэгэн бололтой. Ямартай ч тэр хүн цаг үеэсээ түрүүлээд хөгжчихсэн нэгэн байж. Монголын хөгжлийг арай өөрөөр төсөөлсөн нь коммунистуудад таалагдаагүй бололтой.

Данзанг 1924 онд “Намын үзэл суртлыг гээж, гадаадын худалдаачидтай хуйвалдан намын эсрэг үйл ажиллагаа явуулсан эсэргүү” гэсэн шалтгаанаар цаазлан хороосон. Данзан ердөө л чөлөөт зах зээлийн эдийн засгийг төвлөрсөн төлөвлөгөөнөөс илүү гэдгийг ухаарсан гүйлгээ ухаантай нэгэн. Тэрээр тусгаар Монгол Улсын анхны мөнгөн тэмдэгт болох монгол долларыг 1921 онд Сангийн сайд байхдаа эргэлтэд оруулсан байдаг. Даравч дардаг, булавч бултайсан “Данзангийн доллар” тэртээ 1990 онд ардчилсан хувьсгалын салхинаар хийсэн ирснээр 70 жилийн турш “зүүдний хөлгөөр аялсан” монголчуудаа “сэрээж” бодит байдалтай танилцуулсан. Тухайн үедээ “сайхан зүүднээс сэрсэн” зарим нэгэн маань бодит байдалтай эвлэрээгүй, өнөөдөр ч нийгмийн зарим хэсэг маань “сэрсэндээ” харамсч “зүүдээ” санагалзсаар.

Коммунизмын замналаар явсан 70 жилд нийгмийн салбарт олсон ололтуудыг үгүйсгэж болохгүй боловч эдийн засгийн баялгийг монголчууд бүтээж чадсан уу? “Ах нар” биднийг орхиод гарсан 1990 оноос хойш манай эдийн засаг гурван жил

дараалан дунджаар -7.3 хувиар унаж 1989-91 оны хооронд гадаад экспорт хоёр дахин багассан байдаг. Социалист орнуудын Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл хэмээх байгууллага манай гадаад худалдааг тодорхойлж, ямар ч өндөр үнээр хамаагүй импортын бараа “шахаж”, хариуд нь хямдаар баялгаа экспортлохыг биднээс шаарддаг байв. Бүр болохгүй бол хүчээр “их өр” үүсгээд асуудлаа хойшлуулсныг нь бид төлсөн. Мэдээж тэгж өрөнд унагахдаа сайхан үгтэй уриа лоозон, утга нь ойлгогдохгүй гадаад үгсээр өвөг дээдсийг маань “хөөрхөн молигодохоо” ч дарангуйлагчид мартаагүй. Данзан мэтийн “дайснууд” хувийн өмчийг хамгаалж чөлөөт зах зээл хэмээх байгалийн хүчинд итгэсэн. Харин “манай тал” төр бүхнийг өмчлөөд, Кремльд суусан өвгөчүүд тав, таван жилээр нь төлөвлөсөн. Үнэндээ бол 70 жилийн өрсөлдөөний дараа бид ямар түвшинд, харин “дайснууд” ямархуу түвшинд хөгжсөнийг бид 1990 онд ойлгосон.

Төр хэдий мэргэн байвч ганцхан хүнээр төгсгөл болдог бол чөлөөт зах зээл хэдий харалган байвч ганцхан алдаагаа үүрд засдаг нь нотлогдсон үнэн. Хуучин нийгэмд л өөрийнхөө амьжиргааг бодсон нэгнээ нийгмийн дайсан гэж зарладаг байсан. Үнэндээ хүний өөрийнхөө амьжиргааны төлөө, сайхан амьдрах хүсэл тэмүүлэл бол хязгааргүй хүчтэй, бүр дэлхийг чичрүүлж байсан ЗХУ-аас ч илүү хүчтэй байж “зөөлөн нь хатуугаа идэхийг” бид гэрчилсэн.

Энэхүү хүчийг л Адам Смит “үл үзэгдэгч гар” хэмээн


нэрийдэж эдийн засгийн онолын суут бүтээлээ туурвисан. Тэрхүү “үл үзэгдэгч гар” л биднийг картан талханд “алалцдаг”, 25 сая толгой малтай байсан үеэс маань нэг хүн дунджаар 1.13 гар утас хэрэглэдэг, 40 сая малтай, моргейжийн зээлээр байр, машинаа авчихаж чаддаг өнөөгийн нийгэмтэй ердөө 23-хан жилийн дотор золгуулжээ. Цаашид Монголыг нэг хүнд оногдох эдийн засгийн баялгаараа дэлхийд тэргүүлэгч улс болно гэдэгтэй олон эдийн засагч санал нийлдэг.

Овоо ингээд хөгжих нь үү гэтэл дахиад л нөгөө төр авна, хураана, хориглоно гэсээр “стратегийн” хэмээх нууцлагдмал

үгээр халхавч хийн хувийн хөрөнгийг “хувьсгалын” болгож байгаа нь “зүүдний хөлгийг маань” бэлдээд байгаа мэт хардлага төрүүлэх юм.

Уул уурхайн салбар л гэхэд, Тавантолгой, Эрдэнэтэд зуурсан “бантангийнхаа” учрыг олоогүй төр маань дахин стратегийн ордуудаар хооллож, мөн Хүүхдийн парк, Нарантуул захыг мэдэлдээ авна гэнэ үү?

Уг нь 70 жилийн турш зүүдэлсэн зүүднээсээ суралцсан л баймаар. Дахин сэрэх боломжгүйгээр унтах вий гэхээс залуу үе эмээж байна. ■



Шог зургийг А.Амарсайхан

“Засгийн газар” хэмээх компани

Ц.Болормаа /Сэтгүүлч/

Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит компаниудын дунд уул уурхайн аж ахуйн нэгжүүд толгой цохиж явна. Өнгөрсөн оны байдлаар “Багануур” 5.8, “Шивээ-Овоо” 4.2 тэрбум, “Эрдэнэс МГЛ” компани 688.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тооцоо гарчээ. Төр сайн менежер биш гэх үг бий.

Нөгөөтэйгүүр, эрсдэл өндөр гэгддэг уул уурхайн салбарт төр хувь эзэмшиж татвар төлөгчдийн мөнгийг зарцуулах нь хэр зөв юм бэ?

Казиногийн рулет дээр хожих магадлал 1:38. Рулетийн 38 тооны аль нэг дээр мөнгөө тавьдаг учраас хожих магадлал ийм харьцаатай гэсэн үг.

Тэгвэл орд нээх магадлал 1:1000 байдаг гэж НҮБ нэгэн тайландаа дурьдсан байх юм. Иймээс ч гаднын орнууд эрсдэлтэй энэ салбарт татвар төлөгчдийн мөнгийг оруулдаггүй юм байна. Өмнө нь улс орнууд ашигт малтмалын салбартаа хөрөнгө оруулдаг байсан ч одоо бол “бүх юмаа өөрсдөө хийнэ” гэдэг

“Канад улсад
гэхэд татварын
байтугай
Томоохон
даатгалын
компанийн
мөнгийг уул
урхайн
салбарт маш
болгоомжтойгоор
эргэлдүүлдэг.
Түүнээс бус
татварын мөнгөө
уул уурхайн
салбартаа
ашигладаг зах
зээлийн эдийн
засагтай орон нэг
ч байхгүй.”

БНХАУ хүртэл гаднынхныг баялгаараа даллах болов. Ер нь баян АНУ ч ашигт малтмалын салбартаа зөвхөн хувийн хэвшлийнхний хөрөнгийг зарцуулдаг жишиг бий. Дэлхийн зах зээлд тавааруудын үнэ тодорхой хугацааны мөчлөгтэй өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын үнэ 10 орчим жил өндөр байгаад буурдаг. Тавааруудын ханш өндөр байхад ашиг олох нь сайхан. Гэвч уруудсан үед нь алдагдал, дампуурал хаалга тогшино. Товчхондоо, уул уурхайн салбар унах, босох эсэхэд тавааруудын үнэ ханш хамгийн чухал. Бас уул уурхайд нэг ажлын байр бий болгох нь хөнгөн үйлдвэрийнхээс даруй 5-10 дахин их зардал шаарддаг гэсэн тооцоо бий. Гэтэл манай Засгийн газар татвараар цуглуулсан мөнгийг стратегийн орд хэмээн өмчилсөн уурхайг эзэмшигч компаниудад зарцуулах нь оновчгүй байлтай.

“Ломбард”-нд буй ордууд

Монгол Улс “Оюутолгой”-гоо 250, “Эрдэнэс Тавантолгой”-гоо 350, “Эрдэнэт” үйлдвэрээ 200 сая ам.доллараар барьцаалаад өр тавьчихсан байгаа. Төр хувь эзэмшихээр алдагдал хүлээдгийн жишээ энэ. Монголчуудыг хэдэн үеэр нь тэжээх зургаан тэрбум тонн нүүрсний нөөцтэй “Эрдэнэс Тавантолгой”-г “Аль эрт дампуурчихсан” гэдгийг Ерөнхий сайд өөрөө мэдэгдсэн. Иргэн бүрт эзэмшүүлсэн 1072 ширхэг хувьцаа хэзээ “амилж”, “Эрдэнэс Тавантолгой”-н IPO хийх эсэх нь тодорхойгүй байдалд байгаа. БНХАУ-ын “Chalco” компанид нүүрсээ хямд нийлүүлэх гэрээг төр хийж, урьдчилгааг нь улс төрийн амлалтдаа зарцуулчихсан байгаа. Одоо хятадуудад нүүрсээ маш хямдаар нийлүүлж буйн хариуцлагыг хэн ч хүлээгээгүй.

“Оюутолгой” төслийг хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцож, гэрээг үзэглэснээс хойш манай талаас өөрчлөлт оруулна гэж хэдэнтээ сүрдүүлж, элдэв шаардлага тавьж сууна. Ийнхүү бид дэлхийд гайхагдах ордуудынхаа үүцийг нээж чадалгүй өрөнд тавиад сууж байгааг юу гэж ойлгох вэ. Налайхыг хүрээ барьж ухаж байгаа шигээ том ордуудаа ашиглана гэж бодож байгаа юм биш биз. “Оюутолгой”-н үнэ цэнийн 80 хувийг агуулж байгаа далд уурхайг өөрсдөө ашиглах боломж үнэндээ үгүй. Одоохондоо цөөхөн монголчууд гаднын технологигүйгээр, ердөө өрөм тавиад

баялгаа олборлочихож чадахгүй. Манай талаас “Оюутолгой” төсөлтэй холбоотой асуудал тавьж, хэлэлцээр эхлүүлээд нэгдсэн шийдэлд хүрч чадалгүй долоон сарын хугацаа өнгөрчихөөд байна. Энэ хугацаанд “Rio Tinto” санхүүжилтээ зогсоогоогүй ч далд уурхайн бүтээн байгуулалтын бүх ажлаа аргагүйн эрхэнд хойш тавьсан гэдгээ учирлаад байгаа. Монголын хуулийн дагуу ажиллаж, хүлээсэн үүргээ биелүүлэхийг хөрөнгө оруулагчдаас шаардах нь зүйн хэрэг. Гэхдээ асуудалд бодитой хандахгүй, улстөржүүлж ирсэн бидэнд буруу бий.

“Оюутолгой”-н санхүүжилт яагаад хэтэрсэн тухай Монголын Засгийн газраас ам асууж байгаа. Манайх тус ордын 34 хувийг эзэмшээгүй бол зардлаа хэтрүүлэх эсэх нь бидэнд хамаагүй байх байлаа. Уг нь татвар, хураамжаараа дамжуулаад ашгаа хүртээд явах нь зүйтэй байсан тухай эдийн засагчид ярьдаг. Уг ордоос энэ онд 300 мянган тонн зэсийн баяжмал экспортолж нэг тэрбум орчим ам.доллар олох боломжтой гээд саваа бэлдчихсэн суугаа, бид. “Эрдэнэс Тавантолгой”, “Оюутолгой”-гоо хэрхэн ашиглахаас монголчуудын хувь заяа, амьдрал шалтгаална гэдгийг санах учиртай. Уул уурхайдаа оруулах мөнгө байхгүй атлаа хөрөнгө оруулагчдыг үргээж буй алдаагаа бид эргэн харах цаг болжээ.

Оюутолгойн ордын хайгуулд 508.7 тэрбум төгрөг зарцуулсан гэдэг. Үүнээс өмнө тэнд ямар баялаг байгааг мэдэхгүй, тэмээгээ унаад дээгүүр нь явдаг байлаа, монголчууд. Ийм их хэмжээний зардлыг бид гаргаж чадахгүй, гаргалаа ч орд илрүүлж чадахгүй бол хамаг мөнгөө газарт булснаас өөрцгүй. Гэтэл хэн нэгэн, Ли эсвэл Фрийдланд орд илрүүлчихээр манай Засгийн газар хувь эзэмшинэ гэдэг. Хайгуулын ажилгүйгээр уул уурхай хөгжих боломжгүй. Ер нь энэ салбарт орлогынхоо талыг нь оруулчихаад ашиггүй ажиллалаа гээд “уйлахааргүй” компаниуд л хүч үздэг гэсэн. Монголын хувьд том ордын анхан шатны хайгуул, нарийвчилсан хайгуул, уурхай барих, олборлох өндөр эрсдэлийг даах компани байхгүй гэж болно. Хөрөнгө нь байгаад түүнийгээ оруулсан ч “Талбайг нь улсын нөөцөд авна. Улсын нөөцөд байлгах хугацаа нь дууссан юм уу, нөөцөөс гаргах байгууллагын шийдвэрийн дараа тусгай зөвшөөрлийг сонгон

шалгаруулалтад дахин олгоно” гэсэн утгыг Ашигт малтмалын шинэчилсэн хуулийн төсөлд тусгасан нь тэднийг “хавчсан” хэрэг бус уу. Товчхондоо, хүний хөдөлмөр, хөрөнгөө зарцуулж олсон талбайг сонгон шалгаруулалт явуулах нэрийдлээр өөр хэн нэгэнд өгөхөөр тусгасан нь шударга бус зохицуулалт юм. Бас тусгай зөвшөөрөл цуцлах үндэслэл одоогийнхоос 10 гаруйгаар нэмэгдэх гээд аж ахуйн нэгжүүдийг “дээрэлхсэн” сөрөг заалт ч цөөнгүй бий.

Монгол Улс нүүрсний олон уурхайнхаа хөрсийг хуулахгүй, буруу технологиор ашиглаж ирсэн. Шивээ-Овоогийн ордыг түшиглэн 4500 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, дотоодын хэрэгцээгээ хангаад, бүр БНХАУ-ын хойд хэсэгт нийлүүлнэ гэсэн “мөрөөдөл” нь биелээгүй. Төрийн өмчийнх байсан Шарын голын уурхайг 2003 онд хувийн хөрөнгө оруулагчдад шилжүүлсэн нь зөв байсныг үйл ажиллагаа нь ахицтай яваагаас нь харж болно. Тус компани нь хувьцаат компаниуд дундаа засаглал сайтай, үйл ажиллагаа нь нээлттэй гэгддэг төдийгүй JORC стандартаар нарийвчилсан судалгаа хийснээр 370 сая тонн нөөцтэй нь тогтоогдсон. Уг нөөцдөө тулгуурлан 2011 онд нэмэлт хувьцаа гарган, 18 тэрбум төгрөгийн хөрөнгө босгож чаджээ. “Шарын гол”-ын хувьцааны дийлэнхийг АНУ-ын “Firebird management” хөрөнгө оруулалтын сан эзэмшдэг юм байна. Ашиггүй ажиллаж байсан аж ахуйн нэгжийг хувийн хэвшлийнхэн өөд татаж чадсаны жишээ энэ.

Үндсэн хуульдаа захирагддаггүй төр

Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг компаниуд 20 орчим төрлийн татвар, хураамж төлдөг. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг компаниуд ашиг олсон ч, эс олсон ч, бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй байсан ч төлөх заалттай. Үүнээс гадна жишиг үнийг хэт өндөр тогтоочихдог. Энэ сард гэхэд МАК компанийн гаргаж байгаа тонн нүүрсний татвар тооцох үнэ 75, “Energy Resource”-ийнхийг 96 ам.доллар гээд тогтоочихсон байна. “Хар алт”-ны үнэ дэлхийн зах зээлд буурчихаад байгаа энэ үед дотоодын аж ахуйн нэгжүүд ийм ханшаар бүтээгдэхүүнээ борлуулж чадах нь эргэлзээтэй. “Ийм үнээр арилж” гэдэг нь зах зээлийн хуулийг зөрчсөн,

компаниудад “хутга тулгаж” байгаагаас өөрцгүй. “Energy Resources” хэвийн үйл ажиллагаа явуулж байхдаа хүнсний, ложистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын 300 орчим компаниас ханган нийлүүлэлт авдаг байсан. Уул уурхайн компаниудын ажиллагаа доголдоод ирэх үед төмөр замын ачаа эргэлт ч бас буурна. Том төслүүдэд шаардагдах барилгын материалыг төмөр замаар тээвэрлэн авчирдаг учраас тэр юм.

Хөрөнгөө оруулчихсан хойно нь стратегийн орд гэж нэрлэж, “дээрэмдчихээд” үйл ажиллагаанд нь оролцоно. Төр эзэмшилдээ оролцоо нь нэмэгдэж, халаа сэлгээ хийж, шахааны томилгоо хийх эрхтэй болох нь тодорхой. Стратегийн ордын шалгуур гээд байгаа нь бас тодорхойгүй. Тухайлбал, жилд Монгол Улсын ДНБ-ий таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой гэсэн шалгуур бий. Ирэх онд ДНБ-ий хэмжээ өсчихвөл стратегийн ордын жагсаалтаас хасах гэх мэтээр дор бүр нь засах юм уу гэдэг нь ойлгомжгүй. Бас бус нутгийнхаа үйлдвэрлэлд нөлөөлөхүйц байна гэж заасан байгаа. Олборлолт хийж буй уурхайнуудын дийлэнх нь бус нутгийнхаа үйлдвэрлэлд нөлөөлж байгаа тул бүгдийг нь стратегийн ордод багтаах юм уу, бүү мэд. Ингэж туйлширч байхынхаа оронд томоохон цөөн ордуудаа стратегийн гэж тодотгоод, татварыг нь бусдаас нь арай илүүгээр авч, хувийн хэвшлийнхнээ дэмжиж, тавих ёстой шалгуураа бүгдийг нь тавиад, татвараа аваад сууж байсан нь зөв биш үү. Дашрамд сануулахад, манайхаас бусад оронд стратегийн орд гэж байдаггүй аж. Харин олон улсад стратегийн түүхий эд хэмээх нэр томъёог ашигладаг бөгөөд тэдгээрийг олборлож буй аж ахуйн нэгжид илүү өндөр хяналт тавьдаг гэнэ. Стратегийн түүхий эд гэдэг нь уран, ниобий гэх мэт техник технологи, зэвсэглэл, барилгын материал зэргийг хийхэд зайлшгүй шаардагдах түүхий эдийг хэлж байгаа хэрэг.

Үндсэн хуульд төр батлан хамгаалах, нийгмийг хэв журамтай байлгах, нийгмийн халамжид анхаарах үүрэгтэй гэж заасан. Гэтэл төр энэ үүргээ л сайн биелүүлэх ёстой болохоос иргэдийнхээ бий болгосон баялгийг өөрийн эзэмшилд авах гэж улайрах ёсгүй. Төр бизнест бодлого шийдвэр, хууль

тогтоомжоор оролцдог. Түүнээс бус Засгийн газар иргэдтэйгээ өрсөлддөггүй. Одоо бол төр “Засгийн газар” гэдэг компани байгуулчихаад Ерөнхий сайд нь бизнесмэн шиг болчихоод хувийнхантайгаа өрсөлдөөд байгаа хэрэг. Уг нь төр нь төр, хувийн өмчийг тэнцүү хэмжээнд хуулиар хамгаалах ёстой гэж заасан байдаг.


“Оюутолгой”-н хайгуулын ажилд 500 гаруй тэрбум төгрөг зарцуулж, өндөр эрсдэл гаргахад нь Монгол Улс 34 хувийг нь гаргаагүй. Уг нь 34 хувиар хөрөнгөө оруулж, 34 хувиар ашгаа хүртэн, 34 хувиар эрсдэлээ үүрэх учиртай.

Бас хөрөнгө оруулагч талын зүгээс менежментийн эрсдэлийг даая гэхэд нь бид 34 хувиар оролцсон юм чинь “гэрээгээ үзүүл” гэх мэтээр оролцоно гэж зүтгэсээр компанийн үйл ажиллагааг зогсоох байдалд хүргээд байгаа. Заавал энэ мэтээр эрсдэл хүлээж байхын оронд татвар хураамжаа аваад, авчирсан ноухауг нь нутагшуулах, хүмүүсээ ажилтай, мэргэжилтэй болгох ажлыг хийх ёстой. Тэгээд ч уурхайд оруулах хөрөнгө Монголд алга. Баян АНУ энэ салбартаа дандаа хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг ашиглаж ирсэн байх юм. Дэлхийн хөгжилтэй орнуудад байгалийн баялгийг төрийн өмч бус нийтийн өмч хэмээн үздэгийг санахад илүүдэхгүй болов уу.

Канад улсад гэхэд татварын байтугай томоохон даатгалын компанийн мөнгийг уул уурхайн салбарт маш болгоомжтойгоор эргэлдүүлдэг. Түүнээс бус татварын мөнгөө уул уурхайн салбартаа ашигладаг зах зээлийн эдийн засагтай орон нэг ч байхгүй. Эдийн засгийн 20, төсвийн орлогын 40, экспортын орлогын 90 хувийг бүрдүүлж буй энэ салбараа ашиглахгүйгээр бид мөнгөтэй болохгүй.

Гаднын улс орнуудад төрөө томруулахгүй гэж анхаардаг байхад, манайх хувийн бизнес рүү оролцон улам данхайсаар байна. Татвар төлөгчдийн мөнгийг эрсдэлтэй салбарт оруулах эрх төрд vгvй. ■





Эдийн засгийн эрх чөлөө нь хүний эрхээ хэрэгжүүлэх гол нөхцөл мөн

Р.Мөнхзүл

Хүн өөрийгөө ХҮН гэж хэлэх, хэлүүлэх, өөрийгөө эзэмших эрх хоёр сая жилийн өмнөөс бус ердөө 200 гаруй жилийн өмнөөс яригдсан юм. Байгалиар бараг шалдан шахуу амьдарч, байгалийн сүр хүч, шороон шуурга, үер ус, бороо, салхи, далай, амьтдаас бидний хувь заяа бүрэн хамаардаг байлаа. Иймдээ ч эртний Грекийн домогт байгалийн сүр хүч, үзэгдэл бүрийг ямар нэг бурханы дүрээр орлуулан хэрэглэж тэдгээр бурхадын үг, үйлдлийг байгалийн хууль, зарлиг, хувь заяаг тодорхойлогч, намайг эзэрхэгч

хэмээн үзнэ. Тухайлбал, Посейдон-далай тэнгисийн бурхан Зевс, Айдын ах, бэлэгдэл нь далайн хөөс, далайн морь, дельфин бас гурван шүдэт сэрээ. Зевс-бурхадын хаан, Олимп уулыг захирагч, Тэнгэр болон аянганы бурхан, бэлэгдэл нь аянга цахилгаан, бүргэд, бух, царс мод. Арес-дайны бурхан Афины дүү, Зевсийн хүү, бэлэгдэл нь нохой, бодон гахай, элээ шувуу гэх мэт.

Хүнийг эзэрхэгч дараагийн эзэн бол Хаан байлаа. Хүний хувь заяаг хаан зурна. Хүн хааны зарлиг, үгийг үг дуугүй биелүүлэгч, өөрийн эзэн хэмээн ойлгоно. Ямартаа л Франц дахь XIV Луй түүхэнд алдаршсан /L`etat, c` est moi, "Би бол

Төр" гэх үгээ хэлж байхав.

Харин "Хүн"-ий сүүлчийн гэх эзэн нь Августины төлөөлөл бүхий дундад зуун, бурхан шашин байв. Бурханы санаа бодол, сургаалийг дамжуулагч, хөрсөн дээр буулгагч, жирийн иргэнтэй холбогч нь лам, сүм хийд, шашны үзэл сургааль. Тэдний үгийг бурханы үг хэмээн ойлгож хүн өөрийн зам мөр, хувь заяа, болох болохгүй, ёс суртахуун, хайр дурлал, өмч хөрөнгө бүхий л зүйлийг бурхан мэднэ хэмээн гүнээ итгэнэ.

Хүнийг эзэрхэгч, эзэмшигч эдгээр нийгэмд хувь хүний өмчлөх эрх, өөрийгөө эзэрхэх эрхийн тухай ярих нь бүү хэл системтэй ойлголт ч байсангүй. Бүхий л

өмч, “эдийн засаг” ердөө эзэрхэгчдийн гарт төвлөрч жирийн иргэн түүнийг аривуулагчийн л үүрэг гүйцэтгэнэ.

Гэтэл шинжлэх ухааны эрин үе эхэлж хүн өөрийн хүчээр, өөрийн оюун ухаанаараа өөрийгөө эзэрхийлэн хүссэн зүйлдээ хүрч болдог юм байна гэсэн үзэл, хандлага бий болж, улмаар хувьсгал гарч хэмжээгүй эрхт хаад, лам, шашны эрхийг хязгаарлав. Бидний нэршлээр байгалийн шинжлэх ухааны дэвшилтэй зэрэгцэн нийгмийн шинжлэх ухааны онол, үзэл хандлага, тэр дундаа хувь хүний эрх, эрх чөлөөний философи бий болов.

Хүн төрөхөөсөө л амьд явах, амьдрах, өмчтэй байх гэсэн жам ёсны эрхтэй, эдгээр эрхтэй хамт төрдөг, түүнийг төр хамгаалдаг гэдгийг Жон Локк анх удаа хүлээн зөвшөөрөв. Хүн өмчтэй байснаар, түүнийгээ өөрийн тааваар чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулдаг товчхондоо, эдийн засгийн эрх чөлөөтэй болсноор сайн боловсрол эзэмшдэг, сайн эмнэлгийн үйлчилгээ авдаг, сайн хувцас өмсдөг, сайн хоол иддэг, эрх чөлөөгөө хамгаалдаг, улс төрийн зөв сонголт хийдэг, амьд явах, амьдрах эрхээ баталгаажуулдаг, эцэст нь өөрөө өөрийгөө эзэрхэж өөрийнх амжилт, алдаа зөвхөн өөрийнх нь байж, хүн гэсэн жинхэнэ эрхэм чанараа мэдэрч чаддаг юм байна гэдгийг ойлгов.

Харамсалтай нь, эдийн засгийн эрх чөлөөнд мөнхийн дайсагнагч байх ба тэр нь төр. Төр ямагт эдийн засгийн эрх чөлөөнд халдаж, түүнд өөрийн ноёрхол, эзэрхийллийг тогтоохыг хүснэ. Учир нь нэг талаас иргэн эдийн засгийн эрх чөлөөтэй, өмчтэй байснаар төрийн хүртэх баялагаас хугаслах, төрд илүү их хяналт тавих, эрх мэдлээ өргөжүүлэхэд саад тотгор болно, нөгөө талаас иргэд илүү чинээлэг байх нь төр эрх мэдлээ хэтрүүлэхэд хамгийн том садаа болдог оршино. Бидний хамгийн ойрын жишээ, 1960 оны Үндсэн хуулиар иргэн хувийн өмчтэй байхыг хориглож, улмаар малыг төрийн мэдэлд шилжүүлэв. Малын тоо толгойг даруй 50 саяд хүргэх төлөвлөгөө боловсруулан нэгдэл байгууллаа. Гэвч төлөвлөгөө биелсэнгүй. Учир нь хүний эдийн засгийн эрх чөлөөг хаан боогдуулсан тул хүн хүний малыг / Нэгдэл буюу Улсын өмчийн малыг/ хүний сэтгэлээр л маллах аж.

Харин улс орон чөлөөт эдийн засагт шилжсэн ердөө хорь гаруйхан

жилд мал сүргийн тоо, толгой 45 саяд хүрэв. Энэ бол эдийн засгийн эрх чөлөөг нээж, хүн өөрийн оюун ухаан, хүч хөдөлмөрөөр, өөрийнхөө төлөө ажиллаж, түүний үр шимийг хүртэх эрхтэй болсноор малчны тухайд гэхэд гаднаа салхин сэнс, нарны толь, жийп машин, мотоцикл “сойж”, охин хүүхдээ их дээд сургуульд сурган, гэрээсээ дэлхийн кино, мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авч, хот руу утсаар ярьж махны ханшаа мэдэн, гадаадад суугаа хүүхдүүдтэйгээ интернэтээр холбогдох боломжийг малчин өөрөө бий болгох боломжтойг харуулсан юм. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэнд улсын эдийн засгийн 90 орчим хувь нь ЗХУ-аас хамаарч байсан бол эдүгээ 80 гаруй хувийг хувийн хэвшил нуруун дээрээ үүрч явна. Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь нүүрсний ордыг эдийг засгийн эргэлтэд оруулахаар төр, хувийн хэвшлийн хоёр компани зэрэг үйл ажиллагаагаа эхлүүлэв. Өнөөдрийн байдлаар хувийн компани монгол инженерүүдийн ур ухаанаар бүтсэн хатуу хучилттай зам барьж байгуулан, сургууль, цэцэрлэг, залуусын орон сууцны хороолол, ажилчдын ая тухтай нөхцлийг бүрэн хангасан байхад төрийн компанийн уурхайн орчин хэдэн монгол гэрээсээ салаагүй, удирдлагууд нь улсын мөнгө идсэн шалтгаанаар шалгагдаж байх жишээтэй.

Орчин цагт эдийн засгийн эрх чөлөө баталгаажиж, хангагдсанаар иргэн өөрийгөө эзэрхэн, өөрийн хувь заяа, зургийг өөрөө бүтээж зурах боломж нээгдэхийн дээр улс орны тусгаар тогтнолын гол хөшүүрэг, “зэвсэг” болжээ. Эдийн засгийн эрх чөлөөгүй, хөрөнгө санхүүгийн чадавх, хүчин чадал сул улс орон дотоод болон гадны аюулыг сөрж үл чадна.

Улс орнууд Дэлхийн I,II дайн лугаа адил асуудлыг зэвсгийн хүчээр бус харин эдийн засгийн хориг арга хэмжээ, бодлого, их хэмжээний зээл, тусламжаар тухайн улс оронд давуу байдал тогтоох хандлагатай боллоо.

Хүн эдийн засгийн эрх чөлөөтэй байж, түүнийгээ хамгаалснаар нэгд ХҮН гэсэн эрхэм чанараа авч үлдэхийн дээр, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдлаа урт хугацаандаа хамгаалах “зэвсэг” мөн болохыг ойлгох учиртай. ■

“Эдийн засгийн эрх чөлөөнд мөнхийн дайсагнагч байх ба тэр нь төр. Төр ямагт эдийн засгийн эрх чөлөөнд халдаж, түүнд өөрийн ноёрхол, эзэрхийллийг тогтоохыг хүснэ.”

Хоёр нийгэм дамнасан ойлголтуудын зөрүүг шинжихүй

Д.Жаргалсайхан /Уул уурхайн эдийн засагч/

1 990 ээд оны эхэн үеийн ардчилсан хөдөлгөөний их давалгааг эргэн санацгаая. Өмнө нь үзэн ядаж байсан тэр л нийгэм рүүгээ шилжин орох гэж ёстой л хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж байж өнөөгийн энэ нийгмийн тогтолцоог сонгож тэрхүү сонголтоо Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Одоо бодоход их л яарч байж дээ. Буруу зүйл хийчихсэн гэж бодоод харамсаж энэ үгийг амнаасаа унагаж байна гэж та бүү бодоорой. Гайхалтай түргэн, шийдэмгий, бас тайван шилжилтийг хийснийг маань дэлхий даяараа магтдаг.

Түүнээс хойш 20 гаруй жил өнгөрчээ. Одоо л нэг амьсгаагаа чөлөөтэй авч өнгөрсөн он, жилүүдэд нийгмийн сэтгэл зүйд гарсан өөрчлөлтүүдийг эргэцүүлэх цаг нь болсон юм биш үү?

Миний бие 50 насыг даваад байна. Одоо бодоход миний үеийнхэн их сонин хувь заяатай хүмүүс юм. Учир нь амьдралынхаа эхний хагасыг социализмийг байгуулахад зориулан өнгөрөөж, одоо капитализмийг байгуулалцаад л... Анзаараад байхад монгол хэл маань өөрөө бидний түүхэн замнал, алдаа оноонуудыг шингээсэн толь мэт санагдлаа. Ялангуяа, хоёр эсрэг нийгэм дамнан амьдарсан манай үеийнхэнд илүү анзаарагдсан байх. Ингээд өнгөрсөн хэдэн жилд хийсэн ажиглалт, түүнд тулгуурласан дүгнэлтүүдээсээ хуваалцъя.

“Капиталистууд хүний хөдөлмөрийг сорон мөлжиж баяждаг” хэмээх Марксын сургаалийг миний үеийнхэн сайн санацгааж байгаа. Чухамхүү энэ л энгийн юм шиг хэрнээ маш харгис үзэл дээр бүхэл бүтэн “төрийн машин” бий болж хүн өөрийнхөө төлөө бус төрийн төлөө ажилладаг нийгмийг үүсгэсэн. Хүн өөрөө өөрийгөө удирдан залж болдоггүй, зөвхөн намаар, төрөөр удирдуулах

ёстой гэж сурталдаж байснаас “Малаа яаж маллахаа Маркс-аар заалгахгүй ээ” хэмээх хэллэг гарсан биз ээ.

Капитал гэдэг үгийг жинхэнэ утгаар нь ойлгодог хүн манайд өнөөдөр хэр олон байгаа бол? Хуучин нийгэмд бол энэ үгийн дор хөрөнгө, түүнээсээ илүү мөнгө хэмээн шууд ойлгуулсаар ирсэн.

“Зах зээлийн эдийн засаг гэдэг маань “хэн ч аливаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг итгэлцлийн үндсэн дээр солилцож болдог, өөрийн зохицуулалттай тогтолцоо “ хэмээх ойлголт гарч ирж байна. Ийм л тогтолцоонд шилжин орох шатандаа бид замнаж байгаа. Зах зээлийн эдийн засаг нь биднээс үл хамаарах өөрийн зохицуулалттай, засаглалтай юм шүү гэдгийг манай улс төрчид сайн ойлгоосой.”

Орчин үед бол хүн юу судалж, юунд итгэх нь хувийн эрх чөлөө учир би энэхүү эрх чөлөөгөө эдэлж дээрх үгний талаар хайлаа. Судлаад байвал энэ үг нь дан ганц хөрөнгө мөнгө биш юм. Энэ бол тодорхой баялгийг бүтээхэд шаардагдах нөөц боломж юм гэнэ. Энэ нь машин,

тоног төхөөрөмж, аливаа давуу талууд, мөнгө, цаг хугацаа, мэдлэг, туршлага, тэр ч бүү хэл зүс царай хүртэл капиталд тооцогддог юм байна. Капиталтай хүн бүр мөлжигч, шулаачин гэж бидэнд ойлгуулж байсан байгаа юм даа.

Эдийн засаг гэдэг нэр томъёо их өргөн хэрэглэгддэг болж эдийн засагчдын үгээр улстөрчид бие биенээ “намнадаг” болсон цаг. Харин эдийн засаг гэдэг хэллэг хэдийд Монгол хэлэнд орж ирсэн, хэн оруулж ирсэн юм бол гэдгийг тэр бүр анзаардаггүй юм байна. Англи хэлний “economy”, орос хэлний “экономика” гэдэг үгнээс Монгол хэл рүү буулгахдаа эдийн засаг гэж өөрөөр хэлбэл, эд, зүйлсийн засаглал гэж ойлгогдохоор байгаа юм. Тэгэхээр зах зээлийн эдийн засаг гэдэг нь зах (Нарантуул зах л хамгийн түрүүнд санаанд бууна даа), зээлийн (Банкууд л хамгийн түрүүнд санаанд чинь бууж байгаа биз) эд зүйлсийн засаглал болж таарч байна. Ямар ч байсан өөрөө өөрийгөө засаад, залаад байдаг гэсэн утга агуулагдаад байгаа нь нөгөө алдарт Адам Смитийн үл үзэгдэх гарын зохицуулалттай юм уу гэлтэй. Ямар ч байсан эдийн засаг гэдэг хэллэг нь олон улсад хэрэглэгддэг утгандаа нийцсэн тун догь хэллэгийг тухайн үед оноожээ.

Зээл гэдэг үгийн гарал үүслийг хайж жаахан манаргалаа. Гэтэл энэ нь Англи хэлэнд бол “credit” харин Оросоор мөн кредит гэдэг үгс рүү ороод явчихлаа. Бүр лавшруулан судалбал Латин хэлний “credo” буюу итгэл гэдэг үгнээс гаралтай юм байна. Бодоод байхад эргүүлж авна гэдэгтээ итгэсний үүднээс л эд хөрөнгөө зээллүүлнэ биз дээ? Тэгэхээр зээл гэдэг маань итгэл гэсэн ойлголттой шууд холбоотой болж таарлаа.

Зах гэдэг үгийн гарлыг мөн л Англи хэлний “market”, Орос хэлний рынок гэдэг үгсээр дамжуулан хайваас хэн ч аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ,

мэдээлэл солилцдог талбарыг хамааруулан ойлгодог юм байна. Манайд л зах гэхээр “Нарантуул” гэж ойлгогддог болохоос өндөр хөгжсөн орнуудад хөрөнгийн биржээ хүртэл зах гэж нэрлэх юм билээ.

Дүгнэлт

За тэгэхээр зах зээлийн эдийн засаг гэдэг маань “хэн ч аливаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг итгэлцлийн үндсэн дээр солилцож болдог, өөрийн зохицуулалттай тогтолцоо “ хэмээх ойлголт гарч ирж байна. Ийм л тогтолцоонд шилжин орох шатандаа бид замнаж байгаа. Зах зээлийн эдийн засаг нь биднээс үл хамаарах өөрийн зохицуулалттай, засаглалтай юм шүү гэдгийг манай улс төрчид сайн ойлгоосой.

Эдийн засгийн өсөлт гэж юу гэдэг байна аа?

Хүн болгон л өөр өөрийн ойлголттой, ялангуяа, улстөрчид өөрийнхөөрөө яаж ч тайлбарлаж болдог тун ч энгийн ойлголтуудтай юм байна билээ. Онолын хувьд тухайн нийгмийн гишүүдийн хязгааргүй хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний өсөлтийг хэлдэг. Харин дээрх дүгнэлтээр хүрсэн ойлголтод суурилан үзвээс юуны өмнө хэн ч аливаа бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, худалдах, худалдан авах эрх чөлөөтэй байх явдал нь зах зээлийн эдийн засгийн тулгуур нөхцөл болж байна. Дараа нь итгэлцлийг бий болгох асуудлийг шийдчихвэл нөгөө эдийн засаг гэдэг чинь өөрөө өөрийгөө зохицуулаад өсөөд торниод явчих юм биш үү.

Ард түмний амьдралыг сайжруулна гэдэг үгс манай улстөрчдийн амнаас цаг тутам унадаг болжээ. Мөн л энэ үгний утга, гарал үүслийг хайж үзлээ. Цэвэл гуайн толь бичигт дурьдсанаар бол “ард” гэдэг нь хуучирсан харц олон, хөдөлмөрчин олон, иргэн гэсэн ойлголтуудыг хамруулсан байх юм. Ямар ч байсан өмч хөрөнгөөр нь эсвэл нийгмийн давхаргаар нь ангилсан юм уу даа. Тэгэхээр манай улстөрчид хуучирсан харц олныхоо, хөдөлмөрчин олноо эсвэл зүгээр л иргэдийнхээ эрх ашгийн тухай яриад байна уу? Тэгвэл бусад улс үндэстэн яаж ойлгодог юм бол. Англиар бол people, Оросоор народ гэх юм. Энэ үгээр нь хайгаад “Wikipedia” цахим хуудсаар айлчиллаа. Орос хэл, англи хэл дээр ч тэр энэ нь хэл, шашин, газар нутаг зэрэг нийтлэг хэв шинжээрээ

холбогдсон бүлэг хүмүүсийг хэлдэг юм байна. Харин манайд морь мал мэт ажиллаж хөдөлмөрлөдөг мөртлөө ядуу

“Компани гэхээр л баячууд, панзчид гэж ойлгуулж байсан үе саяхан. Харин энэ үг өөрөө Латин хэлний “cum panis” буюу талх хувааж идэх гэсэн үгнээс гаралтай. Олон хүний хоолоо олж, бас хувааж идэх хэрэгсэл болсон энэхүү компани гэдэг үг Монголд яасан их нүд үзүүрлэгдэж байна аа!”



хоосон байдаг хүмүүсийг ард түмэн гэж нэрлээд, харин бас л ижилхэн морь мал мэт ажиллаад хөрөнгөжсөн нэгнүүд нь бол ард түмэн биш юм шиг ойлгогдоод байгаа нь сонин. Өөрөөр хэлбэл, өнөөгийн төрийн түшээд “бид зөвхөн ядуучуудыгаа л төлөөлнө” гээд байгаа юм шиг.

За тэгвэл хөдөлмөр гэж юу гэдэг байгааг бас хайж үзье. Дахиад Цэвэл гуайн толиос шагайж үзвэл хөдөлмөр гэж ажлыг хэлнэ гэсэн байх юм. Тэгээд дотор нь оюуны, биеийн гэж ангилна гэсэн байна. Үүнийг харьцуулахын тулд мөн л дахиад “Wikipedia”-д морилов. Англиар бол “labour”, Оросоор бол “труд” гэдэг үгсийн тайлбарыг харцгаая. Олон янзын ойлголтууд байгаа боловч ерөнхий санаа

нь “нийгэм эсвэл нийгмийн гишүүдийн хэрэгцээг хангах зорилготой хийгдэж буй хүний ухамсартай үйл ажиллагааг хөдөлмөр гэнэ” гэсэн байна. Үүнээс нэг үг бусдаасаа чухал санагдсан нь “хэрэгцээ”. Бодоод байхад хүний хэрэгцээ маш их юм аа. Амьсгалах, идэх, өмсөхөөс эхлээд инээх, хайрлах хүртэл. Энэ бүх хэрэгцээгээ хүн дангаараа гүйцэлдүүлж чаддаггүйн учир нийгмээрээ оршин тогтнож харин хөдөлмөр нь нийгмийн гишүүдийн “холбоос” болдог юм байна.

Хачирхалтай нь Орос, Монгол хоёрт хөдөлмөрийн баатар гэж цол байх, гол шалгуур нь төрд хэр сайн зүтгэсэнээр нь шалгаруулах, хэрвээ АНУ хөдөлмөрийн баатар гэдэг цолтой байсан бол нөгөө Билл Гейтс, Марк Зукерберг нар авах байх л даа. Тэгэхээр хуучин нийгэмд төр гэдэг “цаддаггүй мангаст” л үнэнчээр боолчлогдон удаан зүтгэвэл баатар цолоор шагнаад нэг “төмөр” энгэрээс нь зүүж өгнө, харин зах зээлийн нийгэмд тэр баатрыг зах зээл өөрөө нэг насандаа барахааргүй их хөрөнгөөр шагнадаг бололтой.

Компани гэхээр л баячууд, панзчид гэж ойлгуулж байсан үе саяхан. Харин энэ үг өөрөө Латин хэлний “cum panis” буюу талх хувааж идэх гэсэн үгнээс гаралтай. Олон хүний хоолоо олж, бас хувааж идэх хэрэгсэл болсон энэхүү компани гэдэг үг Монголд яасан их нүд үзүүрлэгдэж байна аа!

Бизнесмэн гэдэг үгийг хараад том жийп унасан хурган даргыг төсөөлдөг хүн олон. Харин тэр бизнес гэдэг үг англи хэлний “busy” буюу завгүй гэсэн үгнээс гаралтай бөгөөд бизнесмэн гэдэг нь ердөө л “завгүй хүн” гэсэн үг. Бүр “монголчилбол” хөдөлмөрчин гэж ойлгохоос өөр арга байхгүй. Тэгэхээр нөгөө барууны империалистуудад хүртэл хөдөлмөрчид байсан л байгаа биз дээ?

Ингээд харахад бидний хоёр нийгэм дамжсан ойлголтуудын зөрүүнээс өнөөгийн зөрчлүүд, үл ойлголцлууд эхтэй байгаа биз? Манай улстөрчдийн дунд ч энэхүү буруу ойлголтуудаа сайн ялгаж салгахгүй “нөхдүүд” зөндөө л байгаа. Үнэндээ энэ ялгааг ойлгодоггүй улс төр хийдэг “нөхдөд” бүх бурууг тохоход хэцүү. Яагаад гэвэл коммунистууд тэдний тархийг нь хэдэн үеэр нь угаачихсан юм чинь. Бид нийгмээрээ л энэхүү зөрүүтэй ойлголтуудыг “нэг тийш болгож” байж цаашлахгүй бол болохгүй нь ээ. ■

Эдийн засгийн эрх чөлөөг хангах замаар эдийн засгаа аваръя

Д.Жаргалсайхан /Уул уурхайн эдийн засагч/

Монголд өнөөдөр улс төрийн эрх чөлөө байна. Ийм эрх чөлөөгүйгээр бид хөгжил дэвшлийн тухай ярих нь битгий хэл мөрөөдөх ч аргагүй биз ээ. Улс төрийн эрх чөлөө нь нийгэм дэх бугшмал эдээ бээрийг ил гаргах, нийгмийн анхаарлыг түүн рүү хандуулах, эдээ бээрээсээ салах арга замаа тодорхойлох цорын ганц шалгарсан арга юм уу даа. Үүнээс өөр сайн аргыг хүн төрөлхтөн олж чадаагүй л байна. Улс төрийн эрх чөлөөгөөр Монголчууд бид дутаагүй ээ.

Харин өөр нэг эрх чөлөө дутагдаад байгаа мэт санагдах юм. Энэ бол эдийн засгийн эрх чөлөө. Энэ бас ямар юмныхаа эрх чөлөөг яриад байнаа гэх хүмүүс гарах л байх. Тэгвэл энэ бол иргэн та бид ахуй амьдралаа өөд нь татаад явах гэж өдөр тутам хийж байгаа үйл ажиллагаагаа чөлөөтэй, саадгүй явуулах эрх чөлөөг хэлээд байгаа хэрэг. Өнөөдөр чухам энэ эрх чөлөөг эрх баригчид сүүлийн хэдэн жилийн популист бодлогоороо санаатай болон санаандгүй боон хаагдуулаад байгаагаас эдийн засгийн хүндрэл хямрал гараад байгаа бус уу. Хэрвээ тийм бол эдийн засгийн хүндрэлээс гарах арга замыг чухам эндээс эрэлтэй.

Улс төрийн эрх чөлөөний индексээрээ манай улс дэлхийд дээгүүр орж байна. Та бүхэн Freedom house хэмээх байгууллагаас жил бүр гаргадаг Улс төрийн эрх чөлөөний индексийн судалгаагаар. Түүнд Монгол Улс маань Австрали, Европ, Хойд болон Өмнөд Америкийн орнуудтай мөр зэрэгцэн жинхэнэ эрх чөлөөтэй орнуудын нэгэнд зүй есоор тооцогдож байна. Энэ бол та бидний бахархал, бас ирээдүйн хөгжил дэвшлийн баталгаа юм. Иргэдэд ийм эрх чөлөө эдлүүлэхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг.

Тэгвэл Үндсэн хуулиар баталгаажсан мөртлөө хэрэгжихгүй байгаа эрх чөлөөний тухай заалтууд бас байна. Магадгүй би энд хэрэгжүүлэхгүй байгаа гэдэг үгийг хэрэглэх нь оновчтой байж магадгүй. Энэ бол иргэд шударгаар хөдөлмөрлөж өмч хөрөнгөтэй болох, түүнийгээ ашиглах, захиран зарцуулах, өмчлөх эрхүүд юм. Сүүлийн жилүүдэд иргэдийн шударгаар хөдөлмөрлөж бий болгосон өмч, эд хөрөнгө, баялаг руу төрд шургалсан этгээдүүд, бас популистууд эрээ цээргүй халдаж, улмаар иргэдээ сөхрүүлж байна. Үүнд бас гадаадын хөрөнгө оруулагчид өртөж байгааг энд дурьдах нь зүйтэй. Тэр халдлагуудыг үйлдэхдээ дараахи сэдлүүдийг шалтаглан халдлага хууль есны болгож байна. Үүнд :

а/ Нийгмийн халамжийг хэрэгжүүлэх шаардлага. Иргэд халамж хүртэх эрхтэй. Тийм заалт Монгол улсын Үндсэн хуулинд, бусад зайлшгүй байвал зохих нийгмийн халамжийн тухай хуулиудад бий. Гэтэл түүн дээр нь нэмээд иргэд халамжлуулахдаа дуртай байдгийг улс төрчид овжиноор ашиглаж өөрсдийнхөө биш харин бусдын баялгийг, түүний дотор баялаг бүтээгчдийн бий болгосон баялгаас хүүдийн



мөнгө, оюутны мөнгө гэх зэргээр ямар ч үр ашиггүйгээр тараадаг болсон. Тэгээд нөгөөхөө болих гэхээр амташсан нэг хэсэг нь өлсөж үхэхээрээ айлгана. Ингээд үхлийн гоцлоо үүсч, гоцлоо улам чангарна.

б/ Нийгэмд төрийн үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй. Тэгвэл төрийн албанд очиж иргэдэдээ үйлчлэх гэж байгаа нэг хэсэг маань өөр өөрийнхөө ажил үүргийн онцлог дээр дөрөөлөн татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг төсвөөс аль болох ахиухан хүртэх боломжуудыг цалин хөлс, нийгмийн хамгаалал хэлбэрээр гаргаж бүр түүнийгээ хууль болгон батлуулж амжина. Тэдний маань нийгмийн хамгаалал нь нөгөө баялаг бүтээдэг иргэдийнхээсээ давж талийлаа. Өндөр цалин хөлс авдаг болчихвол түшмэлүүд авилга авахаа болиод ажлаа сайн хийдэг болно гэж ярьсаар лоббидсоор байгаад батлуулаад авна. Ямар сайндаа ажлаасаа мултарсан түшмэлүүдэд өгөх мөнгө хэмжээгээрээ хүүхдийн нэртэй тараадаг мөнгөтэй дүүж очиж байхав дээ.

в/ Нийгэмд дэг журам хэрэгтэй. Ийм дүгнэлттэй хэн ч маргахгүй байх. Тийм ч учраас шүүх, цагдаа, прокурорын байгууллагууд байдаг. Тэгвэл дэг журам сахиулах нэрээр нөгөө хөдөлмөрлөдөг, баялаг бүтээдэг иргэдийнхээ өмч хөрөнгө рүү эрээ цээргүй халдаж байна. Дэг журам зөрчсөн иргэдийнхээ хөрөнгө мөнгийг "улсын" болгоно, хураана гэх.

г/ Байгаль орчноо хамгаална. Монгол хүн бүрийн сэтгэлийн үзүүрт эх нутаг, газар, шороогоо хамгаалах, хайрлах үзэл бий. Гэтэл сүүлийн үед чухам энэхүү үзлийг нь ашиглаж нийгэмд нэр хүнд олохыг хүсэгчид их олшров. Зарим нь бүр байгаль орчноо хамгаалах нэрийн дор хөдөлмөрч, баялаг бүтээгч иргэдийн эд хөрөнгө, баялаг руу халдаж, Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг хөсөрдүүлэв. Тэр ч битгий хэл иргэд нь популистуудын бай болж хохирч байхад эрхийг нь хамгаалах үүрэгтэй түшмэлүүд популистуудтай зөрчилдөхөөс төвөгшөөн мэдээгүй дүр эсгэн сууна. Харин нөгөө популистууд нь буу шийдэм барьж өөрсдийнх нь тухалдаг ордон руу ойртоход л нэг юм аюулыг ойлгож даварсан популистуудад төрийн нударга үзүүлмэр аядав.

д/Иргэдийн эрх ашгийг хамгаална. Ийм үүрэгтэйгээр бас ийм амлалттайгаар улстөрчид төрийн эрхэнд гардаг. Хүн төрөлхтөний нийтлэг жам нь тэр. Монголд ч ялгаагүй. Ийм зайлшгүй шаардлагын улмаас тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтын тогтолцоонууд үүсэж гарч байгаа л даа. Тэр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа шударга түшмэлүүд байгааг ч үгүйсгэхгүй. Гагцхүү нөгөө бидний гайхуулдаг “сэргэлэн” зангаараа нэг хэсэг түшмэлүүд тусгай зөвшөөрөл, шалгалтыг хөдөлмөрч, баялаг бүтээгч иргэдийн өмч хөрөнгө руу халдах хэрэгсэл болгон ашиглах хандлага сүүлийн үед их болж, улмаар иргэдийн бий болгосон баялгаас хумслах боллоо. Нөгөө авилгал гэдгийн бордоо нь энэ.

Ингээд харах юм бол эдийн засгийн өсөлт нь зөвхөн төрийн гурван өндөрлөгөөс аль эсвэл хөрөнгө оруулагчид, баялаг бүтээгчдээс хамааралтай биш харин ч жирийн цагдаа, шүүгч, байцаагч, тендерчин нараас их хамааралтай болчихсон байгаа биз?! Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн комисс бол бүр ч их хамаатай. Яагаад гэхээр тэдгээр бүтцүүд Монголын төрийн машин иргэдийнхээ эрхэнд халдахгүй байх хяналтыг хэрэгжүүлэх үүргийг Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн юм.

Эдийн засгийн эрх чөлөөний асуудал олон улсын шийдвэр гаргачдын анхаарлын төвд байдаг юм байна. Тухайлбал эдийн засгийн эрх чөлөөний түвшинг илтгэх индексийг боловсруулан гаргаж улс орнуудыг эрэмбэлжээ. Канад улсад төвтэй Фрэйзерийн институтээс энэхүү индексийг жил болгон шинэчлэн гаргаж олон нийтэд ил тод мэдээлдэг бөгөөд 2014 оны судалгаагаар Монгол Улс судалгаанд хамрагдсан нийт 152 орноос 77-р байранд орж, бараг эдийн засгийн эрх чөлөөгүй орнуудын ангилалд багтсан байх юм. Тэгвэл Хэйритеиж фаундэйшн гэдэг байгууллагаас гаргасан судалгаагаар 2014 онд Монгол Улс нийт 178 орноос 97-д жагсаж эдийн засгийн багахан эрх чөлөөтэй орноор тодорсон байна.

Дээрхи судалгаа хийдэг байгууллагуудын аргачлал нь аль ч орны нөхцөлд хэрэглэж болохоор боловсруулагдсан, бас олон орнуудын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд дээр суурилж олон жил дараалан хийсэн болохоор алдаа мадаг гарах магадлал бага байна гэдэг үндэслэлээр Фрэйзерийн институтээс гаргадаг судалгаан дээр үндэслэн Монголын эдийн засгийн өнөөгийн хүндрэлүүд үүсэж бий болсон шалтгааныг олж тодорхойлох, улмаас илааршуулах жорыг олчих санаатай харьцуулалт, дүгнэлт хийж үзлээ.

Фрэйзерийн институтээс хийсэн судалгаанд эдийн засгийн эрх чөлөөний индексийг тодорхойлохдоо дараахи таван бүлэгт

хуваасан 24 үзүүлэлтүүдийг ашигласан байна.

- Засгийн газрын хэмжээ
- Хууль, өмчлөх эрх
- Мөнгө ба түүний нийлүүлэлт
- Худалдааны эрх чөлөө
- Зохицуулалт гэж ангилжээ. Тэгээд бүлэг бүрээ дараахи байдлаар үзүүлэлтүүдэд хуваажээ. Үүнд :
- Засгийн газрын хэмжээ :
- Засгийн газрын зардал / төсвийн зардал /
- Төсвөөс санхүүжүүлдэг татаасууд / үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зардал гэх мэт /
- Төрийн өмчийн компаниуд ба тэдгээрийн хөрөнгө оруулалт
- Орлогын албан татварын дээд хэмжээ
- Хууль, өмчлөх эрх
- Бие даасан хараат бус шүүх
- Шүүхийн өмнө тэгш байх зарчмын хэрэгжилт
- Өмчлөх эрхийн хамгаалалт
- Хүүлийн хэрэгжилт болон улс төрдэх цэргийнхний орох оролцоо
- Хууль зүйн тогтолцооны нэгдмэл байдал
- Гэрээ, тохиролцоог заавал хэрэгжүүлдэг байдал
- Өмч хөрөнгөө зарж борлуулахад тавигддаг хязгаарлалтууд
- Цагдаагийн байгууллагын найдвартай ажиллагаа
- Гэмт хэрэгтнүүдээс учруулах дарамт
- Мөнгө ба түүний нийлүүлэлт
- Нийт мөнгөний өсөлт, нийлүүлэлт
- Инфляцийн стандарт хэлбэлзэл
- Сүүлийн жилүүдийн инфляцийн түвшин
- Гадаад валютын данс эзэмших эрх
- Худалдааны эрх чөлөө
- Гадаад худалдаанд ноогдуулдаг татварын тариф, түүний хэлбэлзэл
- Тарифын бус хязгаарлалтууд, импорт, экспортын үйл ажиллагааны зохицуулалтуудыг хэрэгжүүлэх өртөг
- Валютын хар зах дээрхи ханш
- Бизнесийн шаардлагаар хөрөнгө, мөнгө, ажиллах хүч шилжүүлэх, нүүлгэх, оруулах, гаргах боломж
- Бизнесийн зохицуулалт
- Зээлийн зах зээлийн зохицуулалт / банкны өмчлөл, хувийн секторын зээл олголт, зээлийн хүүнд тавих хяналтгэх мэт /
- Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт / ажилд авах ба ажлаас халахад дагаж мөрдөх журмууд, хөдөлмөрийн хамгийн бага хөлс, үйлдвэрчиний эвлэл мэтийн нэгдсэн шугамаар хэлэлцээр хийдэг байдал, ажлын цагийн хэмжээ, ажлаас халахад төлдөг төлбөр, цэргийн заавал хаах алба гэх мэт /
- Бизнесийн зохицуулалт / хүнд суртал, бизнес эхлүүлэхэд учирдаг хүндрэлүүд, гар цайлгах мэтийн нэмэлт зардлууд, /

Дээрхи байгууллагуудын хийсэн судалгаагаар эдийн засгийн өсөлт, хүн амын насжилт, нэг хүнд ноогдох ДНБ зэрэг үзүүлэлтүүд нь эдийн засгийн эрх чөлөөний индекстэй шууд хамааралтай, өөрөөр хэлбэл хаана эдийн засгийн эрх чөлөөтэй байна вэ тэнд эдийн засаг өсдөг, хүн ам нь урт насалдаг, нэг хүнд ноогдох ДНБ нь өндөр байдаг ажээ.

Тэгвэл Монгол оронд одоо нүүрлээд байгаа эдийн засгийн хүндрэлийг эдийн засгийн эрх чөлөөг хангах замаар шийдвэрлэж болох бус уу ? Тэрхүү эрх чөлөөг боогдуулж

байгаа хаалтуудыг, халдлагуудыг үгүй болгохоос ажлаа эхэлмээр байна. Ингээд эдийн засгийн эрх чөлөөний индексийг бүрдүүлэхэд харгалзан тооцдог хүчин зүйл тус бүрээр нь хэрхэн асуудлыг шийдвэрлэж болохоор байгааг авч үзье.

Засгийн газрын хэмжээ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгч иргэдийн нөр их хөдөлмөр, тааламжтай гадаад орчин зэргээс үүдэн бий болсон төсвийн нөөц боломж, орлого бий болсныг мөнхөд тийм байх мэтээр манай улстөрчид сэтгэж, улмаар нийгмийн бүх гишүүдэд таалагдах хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөж, бас дээр нь социалист төрөө санагалзаж хэвийн хэмжээтэй байсан төрийн машиныг өнгөрсөн хэдэн жилд маш том болгож амжсан. Төрийн машины томролтын жилийн дундаж өсөлтийг авч үзвэл манай улсын эдийн засгийн жилийн дундаж өсөлтөөс хэд дахин давж гарсан байх юм. Нэгэнт л ийм том болгочихсон төрийн бүтцүүд нь өөрийнхөө оршин тогтнож байгааг зөвтгөхийн тулд эхлээд цалин, хөлс, байр, орон сууц, тэтгэвэр, тэтгэмж нэхэж эхэлдэг юм байна. Тэгээд нөгөө татвар төлөгч, баялаг бүтээгч иргэдийн хөдөлмөр, хөрөнгө оруулагчдийн мөнгөөр бүрддэг төсвийн хөрөнгөөс аль болох их хүртэхийн тулд лобби хийнэ. Тэгээд зогсохгүй өөрөө даахгүй амлалтууд гаргаж түүнийгээ татвар төлөгчдийн мөнгөөр гүйцэлдүүлнэ гээд нийгмийн халамж, байгаль орчин, дэг журам, үндэсний аюулгүй байдал гэх мэтчилэн нийгмийн нийтлэг хэрэгцээ, шаардлагаар халхавчилан хууль гаргуулчихна. Гаргуулчихна ч гэж дээ өөрсдөө гаргачихна. Үүний үр дүнд нийгэм нь том толгойтой няраа хүүхэдтэй адил толгойгоо даахгүй болж дандаа хэвтээ байдалд орчихлоо.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд улсын төсөв 45 гаруй хувийг эзэлж байна, бууруулах шаардлагатай гэж гадаад, дотоодын судалгааны байгууллагууд дүгнээд байгаа нь нэгийг хэлээд байгаа бус уу. Ингээд нөгөө толгой нь бусад эрхтэндээ саад болж, эрх чөлөөг нь боомилж байгаа нь тэр. Тэгвэл одоо нөгөө толгойг нь жижигрүүлж биенд нь таарсан хэмжээнд аваачья. Өөр нэг арга бий. Биеийг нь томруулж толгойг нь хэвээр үлдээх. Харамсалтай нь том толгой нь биеийнхээ бусад эд эрхтэнг хав хүлчихсэн байгаа болохоор энэ арга явцгүй. Нэг орос зүйр үг байдаг даа. Оросоор бол “дурная голова ногам не дает покоя” буюу тэнэг толгой хөлийг амраадаггүй гэсэн утгатай. Ийм л байдалд Монгол Улс маань орчихоод байна. Том төрөөс татгалзаж ухаантай бас жижиг төр лүү шилжье.

Хууль, өмчлөх эрх. Юуны өмнө иргэдийг шүүхэд итгэдэг болгох нь эдийн засгийн эрх чөлөөг эдлүүлэхийн баталгаа болох юм. Иргэд хөдөлмөрлөж олсон орлого өмчөө өөрийнхөөрөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа хэн нэг түшмэлээс, популистаас, гэмт хэрэгтнээс айх айдасгүй байлгах нь төрийн үүрэг. Төр нь энэ үүргээ биелүүлэхгүй байгаагаас иргэдийн айдас нь тэдний хөдөлмөрлөх, баялаг бүтээх эрх чөлөөг нь боомилоод байгаа хэрэг. Гэтэл иргэдийн өмч, хөрөнгө рүү рүү нь халдаж байгаа Засгийн газар, төрийн түшмэл, популист, гэмт хэрэгтэн ер нь хэнбугай ч байсан өнөөдөр цээрлэл хүлээж байна уу? Үгүй гэж хэлбэл нэг үнэн бодит байдлаас нэг их хол зөрөхгүй байх.

Хууль гаргах, хэрэгжүүлэхдээ юуны өмнө иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийг, түүний дотор иргэд шударгаар хөдөлмөрлөж эд хөрөнгө олж авах, хэнээс ч айлтгүй түүнийгээ эзэмших, захиран зарцуулах эрхийг нь хангах, баталгаажуулах

чиглэлээр дорвитой алхам хийж чадвал иргэдийн эдийн засгийн эрх чөлөө хангагдаж түүнийгээ дагаад цаашид эдийн засгийн өсөлт хангагдана. Алдаа мэдгээс ангид нэг ч хүн энэ хорвоо, ертөнцөд байдаггүй. Тэгвэл манай хуулийн хэрэгжилтийг хангадаг түшмэлүүд чухам тэр алдаан дээр нь дөрөөлөөд тэр иргэн, баялаг бүтээгчийн өмч, хөрөнгө тэр битгий хэл гэр бүлийн гишүүдийнх нь эрх рүү халдаж байхад хэн шударга хөдөлмөрлөх юм бэ? Жишээ нь, Их цаг зарцуулалгүйгээр интернэтийн тоолуур ашиглаад тоолж үзэхэд Захиргааны хариуцлагын тухай хуулинд хураана гэдэг үг таван удаа, хурааж гэдэг үг 12 удаа орсон байх юм. Энэ болгон нь уг хуулийг хэрэгжүүлдэг эрхтэн, дархтанууд иргэдийн өмч хөрөнгө рүү халдах үйл ажиллагааг хууль есны болгож, өөгшүүлээд байгаа юм. Болдогсон бол Монголын бүх хуулиас өмч хөрөнгө хураана, улсын орлого болгоно гэдэг заалтуудыг бүгдийг нь үгүй хийх юмсан.

Мөнгө ба түүний нийлүүлэлт. Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтэд шууд нөлөөлдөг өөр нэг хүчин зүйл бол мөнгө, түүний нийлүүлэлт, тогтвортой байдал. Энэхүү бүлэг үзүүлэлтээр Монгол улсын зэрэглэл ихээхэн доогуур байгааг гадаад, дотоодын судалгааны аль аль нь анхааруулаад байгаа. Эдийн засгийн өсөлтөөр хангагдаагүй аливаа цаасан мөнгө нь хөдөлмөрлөж үнэ цэнийг бий болгодог иргэдэд бол бүр аюултай. Мөнгө нэртэй хэвлэсэн цаас нь иргэн хүний зарцуулсан хөдөлмөр, цаг хугацаа, хүчин зүтгэлийг нь үнэгүйдүүлдэгт л хамаг гол учир байгаа бөгөөд үүний улмаас хөдөлмөрлөж байж бий болгосон бараа, ажил үйлчилгээгээ тухайн иргэн нь үнэ цэнэ нь тогтворгүй, байнга савлаж байдаг валютаар арилжихаас эмээж тогтвортой валют эсвэл өөр бараагаар солилцох эрмэлзэлтэй болдог. Ингээд ажил хөдөлмөр эрхлэх, бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх эрх чөлөө нь хумигдаж байгаа нь тэр. За тэгвэл мөнгөний нийлүүлэлтийн асуудлыг эдийн засгийн өсөлттэйгөө нягт уялдуулах, нөгөө талаар мөнгөний нийлүүлэлтийн бодлого нь шударгаар хөдөлмөрлөж, бүтээн байгуулж, баялаг бүтээж байгаа иргэдийн эрхийг хэрхэн хангаж байгаад хатуу хяналт тавихгүй бол болохгүй нь.

Гадаад худалдаа, харилцааны эрх чөлөө. Энэ эрх чөлөөний бүлэг үзүүлэлтээр сүүлийн жилүүдэд Монгол Улсын эрэмбэл удаа дараа доошилж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт яагаад буураад байгаагийн учир шалтгааныг илэрхийлж байгаа болов уу. Энэ нь Оюутолгой, Тавантолгойн томоохон төслүүд төдийгүй бусад жижиг, дунд төслүүд дээр алхам тутам илэрч байна. Лиценз цэгцлэх нэрээр хүний хайгуул хийсэн талбайг булаах, хөрөнгө оруулагчдийн өмнөөс Монгол улсад томилогдон ирж ажиллаж байгаа гадаадын иргэдийг элдэв шалтгаан, шалтгаар саатуулах, баривчлах, дарамтлах зэргээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагч иргэдийн эрх чөлөөг хяхан боогдуулж, улмаар эд хөрөнгө өмчлөх эрхэнд нь халдаж байгаа нь нууц биш. Монгол төрийн байж болох бүх л салаа мөчир, цэрэг даргаар ярилцаж, хэлэлцэж, эцсийн шатны шийдвэр гаргах бүх шат дамжлагаараа оруулан зөвшөөрч Монгол Улсыг төлөөлөн хийсэн гэрээгээ хүндэтгэхгүй, түүнийгээ биелүүлэхгүй байгаа нь гадна, дотны бүх ажил хэрэгч хүмүүс, хөрөнгө оруулагчдийн дунд маш их болгоомжлол бас айдас үүсгэж байгаагаас хөрөнгө оруулалт буурч байна. Ийнхүү гадаад эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөө өдөр ирэх

тутам хумигдаж байгааг нэн даруй зогсоож, цаашид эрх чөлөөг хангах арга хэмжээг авахгүй бол эдийн засгийн өсөлтийг бий болгож чадахгүй төдийгүй харин ч эдийн засгийн хаагдмал, түгжигдмэл улсуудын араас орох нь гарцаагүй байна.

Бизнесийн зохицуулалт. Нийгэмд дэг журам сахиулах, халамжийг хэрэгжүүлэх, нийгмийн гишүүдийг хамгаалах шаардлага, хэрэгцээгээр бамбай, халхавч хийж түүгээр хөдөлмөрч, баялаг бүтээгч иргэдийг популист хууль, тогтоол, тендер, тусгай зөвшөөрөл, шалгалтаар ил далдаар дарамтлах хандлага сүүлийн жилүүдэд улам эрчимжиж, энэ нь иргэдийн эдийн засгийн эрх чөлөөг боогдуулж, улмаар эдийн засгийн өсөлтийг бууруулж байна. Мэдээж хэрэг тусгай зөвшөөрөл, төрийн хяналт шалгалт, бас тэр тендер гэдэг юм нь байдгаараа байж л таарах байх. Гагцхүү эдгээр тусгай зөвшөөрөл болон хяналт шалгалтын үүргийн хэрэгжилтийг ил тод, олон нийтийн хяналтын доор явуулдаг болчихвол, зарим үүрэг функцийг

хувийн хэвшилд шилжүүлчихвэл, бизнесийн зохицуулалттай холбоотой үүсэж байгаа авилгал, хээл хахуул, үл итгэлцэл, бухимдал алга болох төдийгүй эдийн засаг маань өөдлөх нь лавтай.

Ийнхүү эдийн засгийн эрх чөлөөг сайн хангаж өгвөл Монгол Улсын иргэн бүр төсвөөс амьжиргаагаа залгуулдаг биш харин ч иргэн бүр баялаг бүтээгч болж төсөвт орлого оруулдаг болох нь дамжиггүй. Төрийн албыг сонирхогчдын тоо ч эрс цөөрнө биз ээ.

Сонирхолтой нь Монгол улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих талаар саяхан дэвшүүлсэн санаануудын гол нь энд дурьдагдсан эдийн засгийн эрх чөлөөг хангахад чиглэгдсэн санаануудтай нийцэж байна гэж хэлж болохоор байгаа юм. Эдийн засгийн эрх чөлөөг хангах нь өнөөдрийн хүндрэл, хямралыг даван туулах арга нь мөн юм байна гэдэг сэтгэгдэл төрснөө ийнхүү хуваалцав. ■

Сэтгэлгээний хоцрогдол ба эдийн засгийн эрх чөлөө

Д.Жаргалсайхан /Уул уурхайн эдийн засагч/

Танд асуудал бий болгосон сэтгэлгээ чинь хэвээрээ байх юм бол та асуудлуудаа шийдэж чадахгүй.

Алберт Энштейн

Эрх чөлөө гэж юуг хэлнэ вэ? Юу дуртайгаа хийж байх эрхийг хэлнэ гэж зарим нь тодорхойлно. Юу хүссэнээ хэнээс ч хамааралгүй хийх боломжийг хэлнэ гэх хэсэг ч бий. Ер нь бол дураараа дургихыг эрх чөлөө гэж ойлгодог нь давамгайлдаг бололтой. Тэгвэл эрх чөлөө дураараа дургих хоёрын хоорондын ялгаа нь юу юм бэ? Олон янзын тайлбар байдаг юм билээ. Гэвч хэн ч маргахгүй нэг ялгаа бол дураараа дургихын үр дагаврын төлөө хэн ч ямар ч хариуцлага хүлээдэггүй бол эрх чөлөөгөө эдэлсний үр дагаврын төлөө хэн нэг нь заавал хариуцлага хүлээдэгт байгаа юм. Өнөөдөр энд би хариуцлага хүлээдэг эрх чөлөөний тухай өгүүлэх гэж байна.

Та бид улс төрийн тийм эрх чөлөөгөө эдэлж, бас хариуцлагыг нь үүрч сурч байна. Үүгээрээ та бид бахархах эрхтэй

бас тэрхүү эрхээ хамгаалах үүрэгтэй. Одоо бид эдийн засгийн хариуцлагатай эрх чөлөөгөө эдлэх талаар ярих цаг нь болжээ. Ярихаар барахгүй энэхүү эрх чөлөөнийхөө төлөө тэмцэх цаг нь болжээ. Ийм эрх чөлөөгүй бол жагсах, шүүмжлэх, үг хэлэх эрхээр та бид яах юм бэ?

Эдийн засаг гэж юу юм бэ? Зузаан зузаан номуудаар, статистикийн байгууллагуудаас эмхлэн гаргадаг дотоодын нийт бүтээгдэхүүн гэх мэт төвөгтэй нэр томъёонуудаар эдийн засгийг төсөөлдөг хүмүүс бий, бас тийм зузаан номуудыг уншихаас төвөгшөөгөөд эдийн засгийн ухааныг ойлгохоос зугтаадаг нэг нь ч бас бий. Энгийнээр тайлбарлах гээд оролдье.

Иргэн хүн хөдөлмөрлөх, түүнийхээ үр шимийг хүртэх эрхийг Монгол улс Үндсэн хуулиараа баталгаажуулж, энэхүү эрхийг нь баталгаатай эзэмшүүлэх бүх нөхцөлийг хангах үүргийг Монголын төрд ногдуулсан байдаг. Иргэн хүний хөдөлмөрийн үр шим гэдэг нь юуны өмнө тэр иргэн бусдад тустай зүйл хийж олсон

орлогоороо хоол хүнс, өмсөх хувцас, амьдрах байр авч, сургууль, эмнэлэгээр үйлчлүүлж байгааг хэлж байгаа юм. Ийм үр шимийг зөвхөн уйгагүй, урт хугацааны хөдөлмөрөөр л бий болгодог жамтай. Тэр жамаас монголчууд бид гажих учиргүй.

Хөдөлмөр бол та бид бие биендээ хэрэгтэй зүйлийг нь хийж өгч, өөртэй хэрэгтэй зүйлээ олж авахын төлөө гаргаж байгаа хичээл зүтгэл, цаг зав, хөрөнгө хүч юм. Манайхан хөрөнгө оруулагчид гэж их ярьдаг даа. Олон улсад тогтсон өргөн ойлголтоор бол хөрөнгө оруулалт гэдэг нь өөртөө байгаа аливаа нөөц, боломжоо өөртөө хэрэгтэй байдлаар ашиглах үйл ажиллагааг хэлдэг. Энэ нөөц гэдэгт зөвхөн мөнгөн хөрөнгө биш харин цаг хугацаа, мэдлэг, хичээл зүтгэл хамгийн эхэнд хамаардаг байна. Энэ талаас нь авч үзвэл хөдөлмөр эрхэлж байгаа иргэн бүрийг хөрөнгө оруулагч гэж үзэж болох бөгөөд тэгэх ч хэрэгтэй гэж үзэж байна.

Эвдэрсэн машинаа засаж чаддаггүй Доржийн машиныг засварын газар ажиллуулдаг иргэн Дондог засаж өгөөд

олсон орлогоороо хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч байгаа бол талх хийдэг Саран, ногоо тарьдаг Наран, нүүрсний уурхай ажиллуулдаг Бат нар иргэн Дондогт бараагаа борлуулаад олсон орлогоороо мөн л бусдаас бараа үйлчилгээ худалдан авч байгаа жишээг энд авъя.

Ингэж иргэн хүн бусдын хэрэгцээг чанартай бараа, ажил үйлчилгээгээр хангаж түүнийхээ үр шимийг хүртэх үйл ажиллагааг бүхэлд нь эдийн засаг гэж томъёолоод байгаа юм. Бусдад хэрэгтэй зүйлийг нь хийж өгөөд оронд нь өөрийн хэрэгтэй зүйлээ олж аваад байх чадвартай, хүсэл эрмэлзлэлтэй төдийгүй ийм эдийн засгийн үйл ажиллагааг тууштай, уйгагүй эрхэлж үр шимийг нь хүртэж байгаа иргэд манай нийгэмд олонхыг бүрдүүлж байгаа.

Тэгвэл өнөөдөр Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэхэд нь иргэдэд ямар саад бэрхшээл яагаад учирч байна вэ? Улаан дээлтэй л бол манай авгай гэдэг шиг буруутан хайвал л төр рүү заадаг шиг хялбархан оношлогоо хийх хүмүүс гарах л байх. Гэвч энэ удаад хэдүүлээ ул суурьтай, сэтгэлийн хөдлөлд авталгүй оношлох гээд үзье.

Эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэхэд ямар нэг байдлаар саад тотгор болж болзошгүй хүчин зүйлүүдийг хүнээс хамааралтай, хүнээс хамааралгүй гэж хоёр хувааж ангилж болно. Байгаль цаг агаар, газар зүйн байршлаас үүдэлтэй олон хүчин зүйлүүд эдийн засгийн үйл ажиллагаанд янз янзаар нөлөөлдөг. Монгол орны хувьд сөрөг нөлөөлөл нь эерэг нөлөөллөөсөө давамгайлна. Далайд гарцгүй, хуурай уур амьсгалтай, усны нөөц багатай, өвөл хүйтэн, зун богино гээд л биднээс хамааралгүй олон хүчин зүйлийг энд нэрлэж болно.

Хүний хүчин зүйлүүдэд бидний сэтгэлгээ, алсын хараа, сахилга бат, мэдлэг, ур чадвар, хүсэл зорилго, зохион байгуулалт гэсэн суурь ойлголтууд багтдаг байна. Сонирхолтой нь бусад олон оронд хүнээс хамааралгүй хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөллийг бууруулахад хүнээс хамааралтай хүчин зүйлүүдээ давуу тал болгон ашигладаг юм билээ.

Бид тэгж чадаж байна уу? Чадахгүй төдийгүй харин ч бүр нэрмээс болж байна гэж хэлэх хүмүүс давамгайлах байх. Эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэхэд

учирч буй саад бэрхшээлүүдийг үгүй болгохын тулд бид саад болж байгаа учир шалтгаануудыг танин мэдэх хэрэгтэй байна. Ингэж танин мэдэхийн тулд эдийн засгийн эрх чөлөөнд нөлөөлдөг аливаа асуудалд шинэ сэтгэлгээгээр хандаж сурах шаардлагатай байна. Шинэ сэтгэлгээ гэж юуг хэлээд байна вэ? гэдэг дараагийн асуулт нь аандаа гараад ирнэ. Энэ нь нийгэм эдийн засгийн талаарх ойлголтуудаа шинэчлэхээс эхэлнэ. Жишээ болгож эдийн засгийн эрх чөлөөнд хамгийн ихээр нөлөөлдөг нэг хүчин зүйл болох төрийн тухай ойлголтоо авч үзье.

Идэх уух, өмсөх зүүх, эдлэх хэрэглэх бүхий л юмаа, тэр битгий хэл хайрлах дурлах, харамсан гашуудах эрхээ хүртэл нам, төрийн хэмээх нэрлэгдэх хэсэг бүлэг хүмүүсээс авдаг, түүнийхээ төлөө амаа үдүүлдэг, тэдний үйлдэл болгоныг хүлцэнгүй даган баясдаг байсан хуучин нийгэмд бидний оюун санаанд төлөвшсөн төрийн тухай загвар та бидний ухамсарт гүн бат суусан хэвээр л байна. Та бидний оюун санааны энэхүү хуучин загвар нь хариуцлагатай, үр өгөөжтэй төрийг Монголын нийгэмд төлөвшүүлэхэд хамгийн том саадаа болж байна.

Том дарга, сайд болж биш, аль нэг өөр хялбар аргаар биш харин тууштай, уйгагүй хөдөлмөрөөр амар амгалан, сайн сайхан амьдралд хүрч болдог, бас тэгж амьдрах нь хэрэгтэйг хүн бүр амьдралынхаа зорилго, итгэл үнэмшил болгох хэрэгтэй байна. Ийм замаар замнаж амжилтанд хүрсэн, тэгсэн хэрнээ чимээгүйхэн тайван амгалан, бас аз жаргалтай амьдарч байгаа иргэд бидний дунд бишгүй бий.

Ажилтай, орлоготой Дорж, Дондог, Саран, Наран, Бат нарын хажуугаар өндөр настай Должин, өвчтэй Болд, өсвөрийн насны Тэмүүлэн, мэргэжилгүй бас ажилгүй Гочоо нар бас манай нийгмийн нэг бодит хэсэг нь. Өсвөр насны Тэмүүлэнг сургуультай байлгах, өвчтэй Болдыг эмчлэх, өндөр настай Должин болон ажилгүй Гочоо нарыг халамжлах, бас дээр нь зодоонч Батаас, мөн гаднаас ирж болзошгүй элдэв аюул гамшгаас хамгаалах шаардлагын үүднээс л иргэд нь өөрсдийнхөө буурьтай, туршлагатай, чадалтай хэсгийг сонгож өөрсдөдөө үйлчилдэг төр хэмээх үйлчилгээний тогтолцоог бий болгох гэдэг нь хүн

төрөлхтний мөнхийн хүсэл, мөрөөдөл бас олон улсын орчин цагийн нийтлэг хандлага юм.

Бид ч гэсэн тийм төртэй болох гэж, түүгээрээ хамгаалуулаад хэнээс ч айж эмээлгүй ажил төрлөө эрхэлж, үр шимийг нь хүртдэг болохоор шийдэж, сонголтоо хийсэн билээ. Гэвч нөгөө залуу зангаараа, хуучин сэтгэлгээгээрээ бүхнийг төрийн хэмээх бүлэг хүмүүст даатгаж орхив. Тэд маньдаа үйлчилж байгаа эсэхийг нь хянадаггүй, бас дээр нь тэднийгээ даган баясдаг болж эхлэв. Ингээд л та бид залуу зан, хуучин сэтгэлгээ, зөвхөн ашиг орлого хөөсөн хүсэл эрмэлзлэлээсээ болж төр хэмээх бүтцийг ажиллуулж ч чадахгүй, Үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөгөө ч бүтэн эдэлж чадахгүй байдалд орж байна.

Төр бол үнэ цэнийг бүтээгч биш, харин дахин хуваарилагч юм. Өндөр настан, өвчин хуучтай иргэд, хүүхдүүдийг асрамжлан халамжлах, хамгаалах нэрээр төсвөө нэмнэ, түүний тулд хөдөлмөр эрхэлдэг иргэдийн бизнесийн орлогоос авдаг татвараа нэмнэ. Зээл авна. Засгийн газарт яагаад зээл амархан олддог вэ гэхээр та биднээс авах татвараар барьцаалдаг хамаг учир нь байгаа юм.

Татвар эсвэл зээл нэмэгдэхийн хэрээр хөдөлмөрлөдөг иргэдийнх нь эрх чөлөө тэр хэрээр хязгаарлагдана, харин тэр хэрээр нийгмийн өмнөх асуудлууд улам бүр ужигарч хуримтлагдсаар л байна.

Дэг журамтай байх шаардлагын үүднээс шинэ хууль гаргана, шинэ байгууллага байгуулна, шинэ тусгай зөвшөөрлүүдийг бий болгоно, хяналт шалгалтыг олшруулна. Тэр хэрээр л нөгөө хэдэн хөдөлмөр эрхэлдэг иргэдийн эрх чөлөө хумигдана.

Үүний хажуугаар сүүлийн жилүүдэд төр ашгийн төлөө бизнес эрхлэх нь нэмэгдэж төрийн зүгээс үйлчилгээ, халамж хүсэмжлэн суугаа иргэдтэйгээ өөрсдийнх нь төлсөн мөнгөөр өрсөлдөн бизнес эрхлэх хандлага нэмэгдэж байна.

Төр гэж хэнийг хэлээд байгаа юм бэ хэмээн хорин хүнээс асуухад 20 янзаар хариулж байгаа төдийгүй 50 хүнээс асуувал мөн л тийм тооны хариулт ирэх шинжтэй. Төр бол тогтолцоо болохоос хариуцлага хүлээдэг, эрх эдэлдэг хуулийн этгээд биш гэдгийг та бидний хэд нь мэддэг билээ? Тийм хуулийн ч,

ёс суртахууны ч хариуцлага хүлээдэггүй тогтолцоог төлөөлж байгаа нэг хэсгийгээ та бид хэр сайн мэддэг билээ? Бас хэрхэн хянадаг билээ?

Үндсэн хуулиар та бидэнд үйлчлэх үүрэгтэй төрийн маань тогтолцоо аажмаар өөртөө нийгмийг үйлчлүүлдэг, иргэдийнхээ эрхийг хязгаарладаг тогтолцоо болон хувирч байна. Ийм чанарын өөрчлөлт гарсаар байтал та бид дуугүй хараад суусаар байх уу?

Монголын нийгмийн өмнө тулгарч байгаа олон олон асуудлыг ганцыг нь ч атугай барьж аваад шийдвэрлэхийн төлөө тэмцэхийн оронд үлгэрт гардаг шиг ямар ч асуудлыг нэг дор нэг мөр бас тэгээд зөв шийдчихдэг нэг мундаг хаан, эсвэл ерөнхийлөгчтэй болчихвол өөрийнх нь асуудлууд шийдэгдчих мэтээр төсөөлж хүчтэй гарыг хүсэмжилдэг хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд өсөөд байгаа мэт. Миний үгийг хэн тоох юм бэ гэж тэдний зарим нь учирладаг. Юм мэддэггүй, залхуу хүмүүсийг л хэн ч тоодоггүй шүү дээ.

Хүчтэй төр гэж ямар төрийг хэлэх юм бэ? Лав л хэнд ч захирагддаггүй хаантай, хаандаа л захирагддаг түшмэлүүдтэй, асар их мөнгөтэй, цагдаатай, шоронтой төрийг л лав хэлдэггүй байх. Ардчилсан нийгэм дэх төрийн хүч нь түүнийг дэмждэг иргэдийн итгэл, дэмжлэгт л оршдог гэж сургадаг. Тэгвэл өнөөгийн төрийг ийм итгэж болох хэмжээнд нь хүртэл өөрчлөх ажил та бидний санал санаачилгаас л хамаарна.

Та бидний эрх ашгийг хөндсөн, хязгаарласан олон олон хууль, шийдвэрүүдийг та бидэнтэй огт зөвлөлдөхгүй, хэлэлцэхгүй үйлдвэрлэн гаргасаар л байна. Монгол Улсын нийгмийн харилцааг зохицуулдаг нийт 8300 орчим эрхийн актуудыг Legalinfo.mn сайтаас олж үзэж болно. Дунджаар нэг хуулинд 70 гаруй заалт байдаг хэмээн судлаачид гаргасан байдаг бол түүнээс 25 орчим нь төрийн тогтолцооны салаа мөчир бүрд янз бүрийн эрх олгосон заалтууд байгааг юу гэж үзэх вэ? Засгийн газрын тухай хууль гэж нэг хуулийг хэд хоногийн өмнө сөхөж үзлээ. Тэр хуулийн 3.2-д Засгийн газар Монгол улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байх юм. Үндсэн хуулиар иргэддээ үйлчил гээд заасаар байтал,

дээрх хуулиар Засгийн газар манийгаа удирдах болоод байгаа биз. Эндээс та бидний сэтгэлгээний хоцрогдол тодорхой харагдаж байна. Ийм л заалтуудыг маш овжин ашигладаг хүмүүс бас их олширч байгаа нь нууц биш.

Илт төрийн байгууллагуудын үүрэг байж болох функцуудыг эрх болгон оруулсан тохиолдлууд олон байх юм. Муу дээрээ муухай, муухай дээрээ улцан гэдэг шиг тэр эрх гээд нэрлээд байгаа үйлдлүүдийг хийсэн, үйлдсэн төрийн байгууллагууд, түшмэлүүдэд хүлээлгэдэг хариуцлагыг нь тогтоож өгөхгүй байгаагаас тэр эрх нь дураараа дургих үйлдлүүд болчихоод байна.

Түүнчлэн Их Хурлын тухай хуулийг сөхөж үзлээ. Уг хуулиар Их хурлын гишүүн нь “ Их хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая “ хэмээн тангараг өргөнө гэсэн байхыг олж мэдлээ. Тэгээд ямар үүрэг байдаг юм бол доо гээд хайсан чинь нөгөө хуулинд л лав тусгайлан заасан зүйл анги олж чадсангүй. Харин гишүүний бүрэн эрх гээд 27 заалттай зүйл олдож байх юм. Бусдын нэр хүнд, алдар хүндэд халдахгүй байх, хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон журмын дагуу гаргах гэх мэтийн илт үүрэг байвал зохих заалтууд эрх дотор нь цохиж явах жишээтэй.

Монгол улсын аль ч хуулинд байдаг хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага гэдэг нэртэй зүйл ангийг хайсан боловч тийм заалт бас л олдсонгүй. Ийм л хуулиудыг гаргаж байгааг зогсоох хэрэгтэй байна. Гишүүний тангаргын үгэнд байгаа Улсын ашиг сонирхол гэдэг ойлголтыг анхааралдаа аваарай.

Үндэсний эрх ашиг, үндэсний аюулгүй байдал гэдэг том том халхавчийг ашиглан төрийн тогтолцоог улам бүр данхар болгох хандлага газар авсаар. Үндэсний эрх ашиг гэж юу юм бэ, үндэсний аюулгүй байдал гэж юу юм бэ? Энэ бол Монгол улсын иргэдийн нийтлэг эрх ашиг юм. Түүнээс биш хэнд ч харагддаггүй хар хайрцганд хийчихсэн хадны мангаа биш.

Та бид эдийн засгийн эрх чөлөөгөө алдсаар байгаагийн бас нэг шалтгаан бол бид буруу гэдгийг нь мэдсээр байж

бүхий л юмыг идэж уух, инээх баясах, уурлах бухимдах эгээтэй л баах шээхээ хүртэл мөнгөөр хэмждэг болчихсон байна. Үүнийг сайн мэдэрсэн улс төрчид, намууд зүсэн зүйлийн нэртэй бэлэн мөнгө амлаж, бид тэр мөнгөнийх нь төлөө тэднийг засгийн эрхэнд гаргадаг. Харамсалтай нь түүнийхээ төлөөсөнд нь та бид эрх чөлөөгөө боомилуулсаар байгаа.

Мөнгө олж байвал юу ч хийж байсан болно хэмээн сэтгэлгээгээр хүний өөрийн хүнийг хуурах, молигдох, хүчирхийлэх нь энүүхэнд байдаг зүйл болоод “Нэр хугарахаар яс хугар” “ Хүн нэрээ Тогос өдөө” гэдэг өвөг дээдсийнхээ эрхэм нандин үнэт сургаалыг огоорчээ. Тийм ч учраас төрийн нэрээр байна уу, хувийн нэрээр байна уу хамаагүй луйвар хийх, хуурах, төөрөгдүүлэх, хүний, өөрийн хүнийг дарамтлах явдлууд нүдний маань өмнө болоод байхад та бид болох ёстой зүйл нь болоод өнгөрч байгаа мэтээр өнгөрөөдөг болж байна. Үүний улмаас та бид төрд битгий хэл бие биендээ итгэх итгэл алдарчээ.

Товчхондоо хэлбэл бид :

- Залхуу буюу хялбар аргаар үр дүнд хүрэх эрмэлзэлтэй

- Мэдлэггүй буюу аливааг сурч танин мэдэх хүсэл эрмэлзэлгүй

- Хэн нэгний төлөө амьдарч байгаа мэтээр сэтгэж амьдрал ахуйгаа хэн нэгэнд харанхуй даатгадаг

- Зах зээлийн харилцаа бол мөнгө олох харилцаа, мөнгөний төлөө бүхнээ золиослоход бэлэн байх ёстой хэмээн буруу ойлголттой

- Амьдралын бодит тодорхой зорилго тавьж түүндээ захирагддаггүй, мухар сүсэгт захирагддаг болжээ.

Ийм л сэтгэлгээ, зангаасаа болж та бид эдийн засгийн эрх чөлөөгөө улам бүр алдсаар л байна. Хялбар арга гэдэгт нь богино хугацаанд хүсэмжилсэн үр дүндээ хүрэх зорилгоор хэрэглэдэг аргууд, тухайлбал, хуурах, мэхлэх, хулгайлах, залилах, хахуульдах, төөрөгдүүлэх, аливаа юмыг үнэгүй эсвэл хямд хүртэх зэрэг сүүлийн үед өргөн хэрэглэгддэг болсон аргууд юм.

Төрөөс үнэгүй үйлчилгээ, хямд үйлчилгээ, мөнгө нэхнэ гэдэг бол та бид ажил хөдөлмөр эрхэлдэг хэсгээсээ мөнгө нэхэж, тэр хөдөлмөрч хэсгийнхээ эрх чөлөөг боомилж байна л гэсэн үг. Үүнийг ойлгож залхуугаасаа сална

гэдэг бол юуны өмнө худлаа амлалт өгөх, залилах, төөрөгдүүлэх, хулгайлах, хахуульдахаа, ер нь л хялбар аргаар амьдрахаа болино гэсэн үг.

Мэдлэггүй буюу аливааг танин мэдэж чаддаггүй гэдэг нь хэн нь худлаа хэлж хуураад байгаа, яагаад худлаа хэлж байгаа, яагаад хэн нэг нь танд хайртай царайлаад байгаа, амлаад байгаа зүйлс нь биелэх боломжтой эсэхийг, хамгийн гол нь яагаад өөрөө бүтэлгүйтээд байгаагаа мэдэхгүй байна л гэсэн үг. Дээр нь нэмээд юм мэдэхгүйгээ нуух гэж бөөн худлаа ярих хэрэгтэй болно. Тэгэхээр та бид мэдэхгүйгээ хэн нэгнээс нуухгүйгээр, аливаа танин мэдэх арга барилыг аль болох хурдан эзэмшиж чадвал энэ муу зуршлаасаа салж, адаглаад хэн худлаа яриад, бүтэхгүй зүйл амлаад байгааг нь таньж мэддэг болно. Нөгөө мянган үгний таглаа гэгддэг мэдэхгүй гэдэг үгнээсээ хагацна л гэсэн үг.

Өөрийнхөө бүтэлгүйтэлд хамгийн түрүүнд бусдыг буруутгадаг зуршил бидний өдөр тутмын амьдралд гүнзгий суусан. Худлаа ярьдаг амладаг улстөрчдийг мэдсээр байж л хэдэн төгрөг аваад саналаа өгчихдөг, хуудуутай хууль гаргадаг гэдгийг нь мэдсээр байж юу ч хэлэлгүй, юу ч хийлгүй байсаар байгаад хуудуутай хууль гаргахыг нь тэвчээд л байдаг, та бидний, татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийгээд байгааг нь мэдсээр байж түүнийг зогсоохын төлөө тэмцдэггүй нүдэн балай чихэн дүлий байсаар байгаад худалч улстөрчдийн, хоосон толгойтой түшээдийн, авилгач түшмэлүүдийн балагтай үйлдлийн улмаас учирдаг аюул заналхийлэл өөр дээр нь тулаад ирсэн үед өөрөөсөө бусдыг бүгдийг нь буруутган бухимдана. Сүүлдээ бүр байчхаад тэр улс төрчдийн төлөө, хоосон толгойтой түшээдийн төлөө, авилгач түшмэдийн төлөө амьдарч байгаа мэтээр загнана. Бүр сүүлдээ өмх хоолоо өвчүүнийхээ цаагуур давуулж байгаагаа бусдын төлөө хийж байгаа мэтээр аяглаж, үхэх, өлсөхөөрөө айлгана, далайлгана. Бид ийм л араншинтай болчихоод байгаа бус уу.

Ингэж өөрийн бүтэлгүйтэлдээ тэднийг буруутгаж суухын оронд улс төрчдийн биелэгдээгүй амлалтуудын, худлаа мэдэгдлүүдийн, хуудуутай хуулиудын, их мөнгө төгрөгийн асуудалд

орооцолддог түшмэлүүдийн бүртгэлийг нэн даруй хөтөлж эхэлбэл яасан юм бэ?

Тэр Их хурлын тухай хууль болон түүнтэй адил бөөстэй, цоорхойтой хуулиудын цоорхойг бөглөж, бөөсийг нь түүхээр амлаж байгаа хүмүүсийн төлөө саналаа өгдөг байвал яасан юм бэ?

Сонгох саналаа мөнгөөр эсвэл хоосон амлалтаар худалдахаа больж, хоосон толгойтой түшээдийн хууль гаргах үйлдэл бүрийг нь, авилгач түшмэлүүдийн алхаа гишгээ болгоныг ил тод болгох талаар боломж бүрийг ашиглаж, өөрсдийнхөө, үр хүүхдүүдийнхээ төлөө санаачилга гаргаж ажиллавал ямар вэ? Хууль санаачлах талаар эрхийг минь бас хааж, зөвхөн өөрсдөдөө олгосон байна, тэр эрхээ эргүүлэн олж авахын төлөө хамтдаа ажиллацгаая.

Та бидний харанхуй бөгөөд юм мэддэггүй байдал, бас дээрээс нь нэмээд хуудуутай хуулиудыг манай нийгмийн сонор сэрэмжийн цоорхой гэж үзвэл тэр цоорхойг ашиглаж өөрсдийн эрх ашгаа ил, далдаар нийгэмд тулгадаг, түүнийгээ хэрэгжүүлдэг нэг хэсэг байна. Тэднийг буруутгаад ч яах юм бэ? Харин ч тэд бол ядаж л маниасаа илүү овсгоотой, мэдээлэлтэй, бас залхуурдаггүй, дайчин хүмүүс төдийгүй манай нийгмийн сул цоорхойг ил гаргаж өгч байгаа хүмүүс юм. Бид тэднийг буруутгаж суухын оронд тэр цоорхойнуудыг бөглөх ажлуудыг нэн даруй хийх шаардлагатай. Төрийн салаа мөчир болгоныг ил тод тунгалаг болгохын чухлыг ойлгож, бас ихээхэн санаачилга гаргаж ажиллаж байгаа улстөрчид, түшээдүүд байгааг бас хэлэх нь зүйтэй.

Тэдний хичээл зүтгэл, уйгагүй хөдөлмөрийн үр дүнд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хууль, Хуулийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг төрийн салаа мөчир бүрийн үйл ажиллагааг ил тод байлгахад чиглэгдсэн чамбай хуулиуд батлагдан гарсан. Зарим нь хэрэгжээд зохих үр дүнгээ өгөөд эхэлсэн. Гэвч иргэдийн эрхийг бодитойгоор эдлүүлэхэд чиглэсэн эдгээр хуулиуд нь урт хугацаанд манай нийгэм улам бүр эрүүлжиж бид бүхний Үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөг


баталгаатай хангахад дорвитой үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна. Эдгээр хуулийг санаачилан боловсруулж, батлуулах, мөрдүүлэхэд итгэл зүтгэл гарган ажилласан бүх улстөрчид, түшээд, түшмэлүүдэд энэ боломжийг ашиглаад “ Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж өгсөнд тань баярлалаа” гэж хэлье. Ийм л хүмүүсийн төлөө саналаа өгдөг баймаар байна. Ямааны, тэмээний, хүүхдийн, хөгшиний, залуусын гээд ямар ч нэртэй байсан хамаагүй, бэлэн мөнгө амалж байгаа хүмүүсээс өөрсдийгөө ч, төрийг ч аль болох холхон байлгамаар.

Эдгээр хуулийн хүрээнд төрийн аливаа салаа мөчрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, чухал шийдвэрүүдийг гаргахад иргэдийн оролцоог хангах, төрийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох боломжууд нээгдэж байгаа гэж үзэж байна. Хуулийн хэрэгжилтийг зөвхөн цагдаа, шүүгч, хуулийнхан хариуцан албадлагын журмаар хангадаг гэсэн бас нэг хуучин сэтгэлгээнээсээ иргэд та бид нэн даруй салж, өөрсдийнхөө эрх ашгийн төлөө, бизнесийн эрх чөлөөнийхөө төлөө дээрх хуулиудаар бий болгосон боломжуудыг үр дүнтэй ашиглахын төлөө хамтран ажиллахыг хүсэж байна. Та бид үүнийг хийхгүй бол хэн хийх юм бэ? Өнөөдөр хийхгүй бол хэзээ хийх юм бэ?

Хуучин сэтгэлгээний загвар, мухардал руу хөтлөх ааш араншингаасаа эртхэн салахгүй бол хуулийн цоорхойг ашиглан та бидний энэхүү сэтгэлгээний хоцрогдол дээр тоглолт хийдэг элдэв улстөрчид, ардын баатрууд, популистуудын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр, тэд Дагдангийн эхнэр шиг таргалсаар, бид Цэрмаа шиг турсаар байх нь байна шүү. Та минь ээ. ■

Улаанбаатар, 2015.09.03 .
“Дисковер Монголиа”
чуулгандтавьсан илтгэл.

Эрх чөлөөний тухай хэдэн үгс



Г.Агар-Эрдэнэ /Хуульч/

“Эрх чөлөөгүй амьдрал сүнсгүй бие махбодитой адил”

Халил Гибран /Ливаны яруу найрагч/

Эрх чөлөө гэж юу вэ? Ямар учраас эрх чөлөө үнэ цэнэтэй вэ? гэсэн асуулт өнгөрсөн түүхийн хугацаанд сэтгэгчид, онолчдын маргааны төвд байсаар иржээ. Үндсэндээ эрх чөлөө гэдэг нь хэн нэгэн хүн өөрийн хүслээр амьдрах сонголт хийх боломж бөгөөд ийнхүү сонгосон замаараа амьдрахдаа бусдын амьдралд саад тотгор учруулахгүй байх явдал юм. Эрх зүйн сэтгэлгээний нэрт төлөөлөгч Жон Стюарт Милль хүн бүр бусдын эрх чөлөөнд саад, тээг учруулахгүй л бол өөрийн дураар, хэрхэн амьдрахаа сонгох эрхтэй гэж хэлсэн байдаг. Түүний энэхүү үзэл санааг үе үеийн сэтгэгчид улам төгөлдөржүүлэн хөгжүүлсээр ирсэн бөгөөд өдгөө эрх чөлөө гэдэг үг хүний оршихуйн хамгийн үнэт зүйл болон төлөвшжээ.

Гэвч аливаа сайн бүхэнд саад бэрхшээл тохиолддогийн нэгэн адил эрх чөлөө гэдэг ойлголт бүрэн төлөвших хүртэл төрөл бүрийн маргаан, мэтгэлцээн өрнөсөөр ирсэн байдаг. Түүхийн ихэнх цаг хугацаанд төрийн зорилго бол сайн сайхан амьдрал, иргэний нийгмийг бий болгох явдал гэж үзсээр ирсэн боловч эхэн үед эрх чөлөөг ихэс дээдэс, эрх мэдэлтнүүдэд л байх ёстой тусгай эрх гэж ойлгож байжээ. Тодруулбал, эрх чөлөөг зөвхөн тодорхой бүлэг этгээд л

эдлэхээс бус энэ нь бүх нийтэд хамаарах асуудал биш гэж үздэг байлаа.

Мөн XIX зууны сүүлээр социалистууд нийгмийн эдийн засгийн суурийг чухалчлан үзэж, анги давхаргын үзэгдэл, формацийн онол ёсоор эдийн засгийн суурь өөрчлөгдөхөд эрх зүй нь даган өөрчлөгдөж байдаг, эрх зүй нь эргээд суурьтаа нөлөө үзүүлж, үйлчилж байдаг гэсэн үндэслэл гарган илэрхийлж, улмаар эрх чөлөө нь улс үндэстний өчүүхэн зорилго төдий зүйл бөгөөд эрх чөлөө гэх ойлголт өөрчлөгдөж болно гэж үзэж байв. Тодруулбал, төрөөс хүний хувийн амьдралд хөндлөнгөөс оролцох шаардлагатай тохиолдолд энэ нь зөвшөөрөгдөхүйц асуудал хэмээн томъёолсон нь эрх чөлөөний тухай сонгодог ойлголтыг үндсээр нь үгүйсгэсэн явдал болсон бөгөөд хувь хүн өөрийн амьдралаа өөрөө сонгох тэрхүү боломж үгүй болсон юм. Орост шинэ тутам ялсан пролетарийн хувьсгалын дараа В.И.Ленин зөвлөлт засгийг улам төгөлдөржүүлэх хувьсгалын үндсэн зорилтуудыг тодорхойлохдоо эрх чөлөө гэсэн ойлголтыг арилгах ёстой гээд “Энэ бол хэмжээлшгүй их эрхэм зорилт, үүнийг шийдвэрлээгүй цагт социализм байхгүй гэдэг нь илэрхий хэрэг” хэмээн номлож байв. В.И.Лениний энэхүү тайлбар эрх чөлөөг үгүй хийх социалист эрх зүйн үндсэн зорилтыг шууд тодорхойлсон бөгөөд нийгмийн гишүүн бүрийн амьдралд төр хөндлөнгөөс оролцож, хувь хүний чөлөөт сонголт хийх эрхийг бүдүүлгээр зөрчиж байлаа.

Харин эрх чөлөө хүн бүрт хамаарах ёстой гэсэн ойлголтыг Томас Хоббс, Жон Локк нар үндэслэсэн билээ. Эрх зүйн онолч, сэтгэгч Жон Локк нэгэнтээ “Хуулийн зорилго бол эрх чөлөөг устгах буюу хавчин гадуурхах явдал биш, харин түүнийг хамгаалж, өргөжүүлэх явдал мөн” гэж дурьдсанчлан тэрээр эрх чөлөөг хүн бүр эдлэх ёстой жам ёсны зүйл гэж үзсэн юм. Мөн тэрээр “Хүн бүр өөрийн шинж чанараар эрх чөлөөтэй бөгөөд тухайн хүн өөрөө л зөвшөөрөөгүй тохиолдолд түүнийг өөр хэн ч, юу ч энэ газар дээрх аливаа эрх мэдлийн захиргаанд оруулж чадахгүй” гэсэн ба хүн өөрийн бие махбодийг бүхэлд нь удирдан захирч байгаа тохиолдолд өөрөө өөрийнхөө эзэн мөн, харин тэр хүн боол байгаа тохиолдолд эзэн нь түүний биеийг захирч, тэр хүн эрх чөлөөгүй болно гэсэн юм. Тодруулбал, тэр эрх чөлөөний үндсийн үндэс нь хүн юм гэсэн үзэл санааг дэвшүүлж, хувьдаа эрх чөлөөтэй байгаа хүн өөрийн амьдралд шаардлагатай асуудалд сонголт хийх боломжтой болдог гэж үзжээ. Энэхүү үзэл санаа нийгмийн гэрээний онолтой хамт хөгжиж төрийн үүрэг бол хувь хүмүүсийн эрх чөлөөг хангах, хамгаалах явдал мөн гэх үзэл санаа хүчтэй түгэж, эрх чөлөө нь улс төрийн тогтолцооны нэгэн чухал үнэт зүйл болон төлөвшсөн билээ.

Энд сонголт гэдэг үгийг онцлон авч үзье. Хүн өөрийн амьдралаа хэрхэн авч явахаа сонгох явдал бол эрх чөлөөний илрэн гарах хэлбэр юм. Өөрийн бодол

өөртөө зөв гэдэгчлэн бодол санаа, ухамсартаа тулгуурлан өөрийн зөв гэж үзсэн үйлдлээ хийх сонголтыг хүн хийдэг бөгөөд энэ бол эрх чөлөө юм. Эрх чөлөөг тодорхойлох өөр олон хүчин зүйл байдаг ч хувь хүн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр өөртөө ямарваа нэгэн үр дагавар бий болгох тэрхүү сонголтыг хийх боломж олгодог гэдэг утгаараа энэ нь үнэ цэнэтэй юм.

Орос-еврей гаралтай Английн сэтгэгч Исаиа Берлин 1958 онд Оксфордын их

сургууль дээр тавьсан “Эрх чөлөөний талаарх хоёр үзэл” хэмээх илтгэлдээ эрх чөлөөний хоёр хэлбэрийг гарган илэрхийлсэн ба эхнийхийг “Негатив эрх чөлөө”, удаахийг “Позитив эрх чөлөө” хэмээн тодорхойлсон байдаг. Тэрээр негатив эрх чөлөө гэдэг нь бусдын зүгээс үзүүлэх саад тогтор, хязгаарлалт огт байдаггүй хүрээ гэж үзсэн бол позитив эрх чөлөөг өөрөө өөртөө эзэн нь байх явдал гэж тодорхойлсон байдаг.

“Амьдралын зорилго бол зорилготой

амьдрах явдал юм” гэсэн үг байдаг. Нийгмийн түүхийн бүхий л цаг үед зорилготой амьдрах боломж нь эрх чөлөө байсаар иржээ. Орчин үеийн ардчилсан төрийн үүрэг бол хүн бүрийн эрх чөлөөг хангахад чиглэсэн хууль тогтоомжийг дагаж мөрдүүлэх, бусдын эрх чөлөөнд саад болохгүй байх нөхцлийг бүрдүүлэх явдал бөгөөд энэ утгаараа жинхэнэ эрх чөлөө зөвхөн ардчилсан нийгэмд оршиж, хувь хүн өөрийн гэсэн зорилготой амьдрах боломжтой байх ёстой юм. ■

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Г.Агар-Эрдэнэ /Хуульч/

Хүний эрхийн түгээмэл тунхаглал бол хүн төрөлхтний XXI зууны томоохон ололтын нэг яах аргагүй мөн. Үүнээс өмнө хүний эрхийн асуудалд дэлхий нийтийн анхаарлыг хамгийн ихээр хандуулж байсан явдал энэхүү баримт бичиг батлагдсан үетэй харьцуулахад түүхэнд ховор юм.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх бол нэг хэрэг, хэрэгжүүлэх нь бас өөр хэрэг. Хүний эрхийг бэхжүүлэх, дагаж мөрдөх явдлыг баталгаажуулахад төрөл бүрийн хяналт, хэрэгжилтийн механизмууд шаардлагатай байдаг. Үүнийг эрх зүй, дипломат, улс төрийн болон иргэний нийгмийн арга хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэх боломжтой. Гэвч энэ бүхнийг нэгтгэх үндсэн баримт бичиг зайлшгүй хэрэгтэй гэж үзсэнээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал бүтэх нөхцөл, боломж бүрдсэн юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний эрх бол хүнийг төрж мэндэлсэн цагаас хамт бий болдог агаад хүйсийн байдал, угсаа, гарвал, итгэл үнэмшил зэргээс үл хамааран адил тэгш эдлэгдэх эрхүүд юм гэдгийг дэлхий нийтэд зарлан тунхаглаж, үндэсний болон олон улсын түвшинд энх тайван байдлыг тогтоох үндэс болсон баримт бичиг хэмээн хүндлэгддэг. Ийм ч учраас уг баримт бичгийг хатуу тогтоосон, заавал дагаж мөрдөх хэм хэмжээ гэхээсээ илүүтэй олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тунхаглал хэмээн ойлгож, сайн дурын үндсэн дээр нийтээр хэрэглэж заншжээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг нөгөөтэйгүүр “хүний эрхийн бүрэн төгс хөтөлбөр” гэж үздэг. Учир нь өдгөө олон улсын түвшинд хүчин төгөлдөр үйлчилж буй бүх төрлийн гэрээ, конвенциуд уг тунхаглалаас эхтэй бөгөөд тунхаглалд заасан хүний эрх бүрийг нарийвчлан зохицуулах зорилгоор батлагдан гардаг билээ.

Түгээмэл тунхаглалыг анх Канадын хуульч Жон Питерс

Хамфри 1946 онд боловсруулж, эхний төсөл бэлэн болсны дараа хоёр жилийн турш хэлэлцэн, засварласны үр дүнд 1948 оны арванхоёрдугаар сарын 10-ны өдөр НҮБ баталсан түүхтэй. Түгээмэл тунхаглалыг батлах санал асуулгад 56 улс оролцож, 48 улс зөвшөөрч, нэг ч улс татгалзаагүй хэдий ч найман улс санал өгөхөөс түдгэлзсэн байдаг. Санал өгөхөөс түдгэлзсэн найман улсын зургаа нь ЗХУ, Беларус, Украин, Югослав, Польш буюу коммунист дэглэмийг шинэ тутам хэрэгжүүлж буй улсууд байсан агаад тэд нийгмийн тогтолцоонд нь харшлах хэд хэдэн заалт агуулсан баримт бичиг байна гэж үзээд санал өгөхөөс түдгэлзэж байжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 28 дугаар зүйлд “Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй” гэж заасныг дээрх улсууд хүлээн зөвшөөрч байсан хэдий ч хүний эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлсон гол заалт болох “Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй”, “Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй”, “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэсэн заалтууд нь шинээр байгуулахаар зорьж буй социалист үзэл сурталд харш байна гэж үзээд түдгэлзэж байжээ.

Социалист улсууд хувийн өмч нь мөлжлөгийг төрүүлдэг учраас нийгэм өмчтэй, өмчгүй ангид хуваагдаж, эцэстээ энэ нь хүчирхийлэл болох нийгмийн хувьсгалын замаар шийдвэрлэгдэж, өмчийн харилцааг төрийн өмч дангаар ноёрхсон нийгмийн харилцаа болгох ёстой гэж үздэг тул санал өгөхөөс түдгэлзэж байв.

Тэгвэл эдгээр орны санал өгөхөөс түдгэлзэж байсан тэрхүү

эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлсон заалтууд ямар ач холбогдолтой талаар товч авч үзье.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлд “Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй” гэж заасан нь эдийн засгийн эрх чөлөөний гол шалгуур болох хүний өмчлөх эрхийг нийтээр нэг мөр ойлгоход нэн чухал ач холбогдолтой юм. Түгээмэл тунхаглалыг дэмжин баталсан орнууд бүгд энэхүү тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг хангах үүргийг дотооддоо хэрэгжүүлэх үүрэгтэй. Тодруулбал, сонгодог ардчилсан онол ёсоор төр нь иргэдийнхээ төлөө ажиллаж, иргэд нь төрийн хамгаалалт дор эдийн засгийн эрх чөлөөгөө жинхэнэ утгаар хэрэгжүүлэх үндсийг бэхжүүлэхэд өмчлөх эрх нэн чухал бөгөөд энэ нь хүн бүрийн жам ёсны эрх юм. Өөрөөр хэлбэл, өмчлөх эрх бол эрх чөлөөний мэдрэмжтэй үйлдэл хийх, түүнээс үүдэн бий болох фактаас шаардах, нэхэмжлэх хүч чадлыг өөртөө агуулж байдаг халдашгүй эрх билээ. Орчин үеийн өмчийн онолч А.Алчин “Өмчлөх эрх нь хүний эрхтэй зөрчилддөггүй. Өмчлөх эрх бол эд баялгийг ашиглах, түүнийг солилцох хүний эдийн засгийн эрх чөлөөний түлхүүр юм” гэсэн байдаг.

Дахин түүх сөхвөл, Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлах үед тунхаглалын бүтцийг хэрхэн тодорхойлох талаар

хэлэлцүүлэг нэлээд өрнөсний эцэст дөрвөн бүлэгтэй байхаар шийдэж байсан гэдэг.

Эртний Грект академи нь эрдэм мэдлэг, хүч чадлын илэрхийлэл болж байсан бөгөөд барилгын загвар нь дөрвөн том нүүрэн баганаас бүтэж байв. Үүнтэй нэгэн адил Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дөрвөн бүлэгтэй хийж, бүлэг тус бүр нь өөр өөрийн гэсэн онцлогийг агуулсан байхаар төслийг боловсруулж байжээ. Үүний нэгдүгээр баганад хувь хүний эдлэх түгээмэл эрхийн баталгаа, хоёрдугаар баганад улс төрийн эрх чөлөөний баталгаа, гуравдугаар баганад шашин шүтлэг үзэл бодлын эрх чөлөөний баталгаа, харин сүүлийн дөрөв дэх баганад эдийн засгийн эрх чөлөөний баталгааг тусгасан байдаг.

Нийгмийн амьдралын өнгөрсөн хугацааны түүхээс үзвэл хүний эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж байсан олон янзын арга замуудын жишээ байдаг. Үүнээс хамгийн чухал арга хэрэгсэл нь эдийн засгийн эрх чөлөөг хамгаалах хууль зүйн хамгаалалт байх ёстой гэсэн шаардлага бөгөөд өдгөө дэлхийн улс бүрийн Үндсэн хууль, бусад хуульд тусгагдсан эдийн засгийн эрх чөлөөний заалтыг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэсэн баримт бичгүүдийн нэг бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал билээ. ■

Үндсэн хууль ба эдийн засгийн эрх чөлөө

Б.Цэцэнбилэг/хуульч/

Олон нийтийг хамгаалах нэрийдлээр хууль зөрчиж байгаа газарт Үндсэн хууль байдаггүй. Н.Мальбранш



Монгол улсын үндсэн хууль
5.2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.

Шог зургийг А.Амарсайхан

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлд “Социалист төр нь нийгмийн социалист өмчийг хамгаалж бэхжүүлэх, аж ахуй соёлын байгуулалтад нийгмийн бүх гишүүнийг идэвхтэй оролцуулах, хөдөлмөрийн социалист сахилгыг бүх аргаар бэхжүүлэх, улс орныг империалист түрэмгийллээс батлан хамгаалах явдлыг зохион байгуулна. Эдийн засгийн талаар бие даасан байх нь улсын тусгаар тогтнолын нэг гол баталгаа болдог” гэсэн байдаг.

Тухайн үед “социалист өмчийг хамгаалж бэхжүүлэх” нь социалист төрийн үндсэн үүрэг байсан.

В.И. Ленин “Залуучуудын эвлэлийн зорилтууд” номдоо “Хэрэв тариачин хэсэг газрыг эзэмшвэл бүх илүүдэл тариа буюу өөрөөр хэлбэл өөрт нь ч, малд нь ч хэрэггүй тариагаа хувьдаа завшиж байхад бусад нь талх тариагүй хоосон байвал энэ нь тэр тариачин мөлжигч болж байгаа хэрэг.

Тийм тариачин хичнээн их тариа

үлдэж байвал өөртөө төчнөөн их ашиг олж, бусад хүн өлсөж л байг “тэд хичнээн их өлсвөл, би төчнөөн их үнээр тариагаа худалдана” гэдэг. Бүгдийг нэг ерөнхий төлөвлөгөөгөөр нийтийн газар, нийтийн фабрик, заводод нэг журам баримтлан ажилладаг болгох хэрэгтэй.” гэсэн байна.

Социалист нийгмийн үед өмчийг, эдийн засгийн харилцааг, ашгийг юу гэж ойлгож байсан талаар бага ч гэсэн дүр зураг буулгах гэсэндээ дээрх эшлэлүүдийг орууллаа.

Социалист өмч гэж яг хэний өмч вэ? Хэнээс, юунаас, яаж хамгаалах вэ? гэсэн асуулт тодорхойгүй бөгөөд хэн ч социалист өмчийн дайсан болох боломжтой байснаараа олон хүний хувь тавилан хохирсон.

В.И Ленины үзэл номлолоор өөрийн тарьсан тариа өөрийнх нь хэрэгцээнээс илүү гарах л юм бол мөлжигч гэж үзжээ. Ийм үзэл номлолоор бид 70 жил явсан. Одоо ч түүний ул мөр байсаар л байна. Манай Улс 1992 онд Үндсэн хуулиа шинэчилэн баталснаар эдийн засгийн тогтолцоо, бодлогын үндсэн зарчмыг тогтоосон. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн

зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” хэмээн заасан байдаг.

Үндсэн хуулийн энэхүү заалт нь ашгийн төлөө шударга өрсөлдөөнөөр зохицуулагддаг зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшин хөгжих үндэс болсон.


Уг өөрчлөлт нь том өөрчлөлт болсон бөгөөд эдийн засагт төрийн оролцоо эрс хязгаарлагдаж олон мянган өмчлөгчид өөрсдөө ашгийн төлөө шударгаар өрсөлдөж, чөлөөтэйгөөр бүтээн туурвих нөхцөл бүрдэж эхэлсэн болохыг нэрт хуульч Б.Чимид гуай өөрийн бүтээлдээ тэмдэглэж байсан.

Өнөөдөр үнэхээр дээр дурьдсан хувийн өмчийг хамгаалсан, ашгийн төлөө шударга өрсөлдөөнийг дэмжсэн төрийн бодлого хэрэгжиж байна уу гэдгийг нэг тунгаан бодох цаг иржээ.

Хувийн өмч гэхээр өмчлөгчид л

хамаатай асуудал гэсэн ойлголт газар авчээ. Гэтэл хувийн өмч гэдэг нь энэхүү бидний цогцлоон бий болгох гээд байгаа ардчилсан зах зээлийн эдийн засгийн хамгийн чухал үнэт зүйл юм. Өмнөх үеийн сэтгэлгээ өнөөдрийг хүртэл байгаа бөгөөд “баялгийн тэгш хуваарилалт”, “стратегий”, “ард түмний өмч” гэх мэт сүржин үг, хэллэг улстөрчдийн дунд ихээр хэрэглэгдэх болж байгаа нь дээр дурьдсан “социалист өмч”, “мөлжигч” “хөдөлмөрийн социалист сахилга” гэх мэт үгстэй агаар нэг мэт. Ийнхүү сүржин үг, хэллэг газар аваад эхлэх юм бол бидний түүх давтагдаж магадгүй юм. Өнөөдрийн байдлаар үл хөдлөх хөрөнгө бол стратегийн хөрөнгө юм гээд бүх үл хөдлөх эд хөрөнгийн хамтран өмчлөгч төр байхаар хууль гарах юм бол нэг их гайхаад байх зүйл биш болоод байна. Бүх зүйл ингэж л эхэлдэг. ■

Яагаад татвар төлөх ёстой вэ?



Г.Агар-Эрдэнэ /Хуульч/

Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг мөн. Үндсэн хуулиар иргэнд энэхүү үндсэн үүргийг ногдуулахдаа шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн ёсчлон биелүүлэхээр үүрэг болгосныг анхаарах хэрэгтэй. Тэгвэл сайн дурын шинжтэй байсан зүйл яагаад заавал биелүүлэх ёстой үндсэн үүрэг болов? Татварыг яагаад төлөх ёстой юм бэ?

“Төр оршихуй дор татвар буй, татвар оршихуй дор төр буй.” гэдэгчлэн төр, татвар хоёр салшгүй холбоотой агаад төр үүссэн тэр цагаас хойш татвар хамт бий болжээ. Анх эртний Грек, Ром, Египтэд татварын анхны хэлбэрүүд үүссэн бөгөөд түүхийн туршид хэд хэдэн үе шатыг дамжин хөгжсөн байдаг. Мэдээж төр нь ард түмэнд хадгалагдаж буй эрх мэдлийг өөртөө шингээж, эргээд ард түмэндээ үйлчлэх үндсэн үүрэгтэй. Ард түмний эрх ашгийг хамгаалах

үүргээ хангалттай хэрэгжүүлэхэд зарим санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байсан тул татварыг бий болгож иргэд сайн дураараа төлдөг байснаа, хожмоо татвар төлөх нь иргэний үүрэг болон хэлбэржсэн байна. Өөрөөр хэлбэл, тусгаар тогтносон улсын иргэд нь өөрсдийн аюулгүй байдал, сайн сайхан аж амьдралыг нь хамгаалан бэхжүүлэх үүрэгтэй төрд тодорхой хэмжээний санхүүжилт өгч эрх, ашгаа хамгаалуулах болжээ.

XVIII зууны сүүлчээр буюу 1776 онд эдийн засагч Адам Смит “Үндэстнүүдийн баялгийн мөн чанар ба учир шалтааныг судлах нь” номоо хэвлүүлж, татварын үндсэн үүрэг, ашиг тусын тухай номлосон бөгөөд түүний дэвшүүлсэн үзэл санаа өнөөгийн татварын онолын суурийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй хэрэглэгдсээр байна. Адам Смит хувь хүний өөрийгөө хөгжүүлэх төрөлхийн хүсэл зоригийг төр хүндэтгэн үзэх ёстой гэж үзэж байсанд гол үзэл санаа нь оршиж байв. Хүн өөрийн энэхүү төрөлх хүсэл зоригоо дагах бололцоог олгосон эдийн засгийн тогтолцоо нь төрийн зохицуулалт бага, цэцэглэн хөгжсөн улс үндэстнийг бий болгоно гэж үзэж байжээ.

Энэ үзэл санааны хүрээнд тэрээр татварын тухай суурь дөрвөн зарчмыг санал болгосон ба **нэгдүгээрт**, татвар нь хүний төлж чадах бодит боломжид тулгуурласан байх ёстой (энэ ч үүднээс өдгөө барууны орнуудад төлбөрийн чадавхад суурилсан татварын тогтолцоог илүүд үзэж байна. Хэрвээ их орлого олж байвал тэр хэмжээгээр их татвар төлнө. Эсрэгээрээ орлого бага байвал бага татвар төлнө гэсэн үг.), **хоёрдугаарт**, татвар нь бүх хүнд ил тод, шударга байх ёстой, (тодруулбал, татварын төрөл, хувь хэмжээ нь хэнд ч ойлгомжтой байхаар зохицуулагдах ёстой), **гуравдугаарт**, татвар цаг хугацаандаа, зөв төлөгдөх ёстой, (төр татвар хураахдаа татвар төлөгчийн татвараа төлөх тэрхүү боломжит цаг хугацааг харгалзан үзнэ гэсэн үг), **дөрөвдүгээрт**, татвар хураахад зардал чирэгдэл бага гаргах ёстой гэжээ.

Дээрх зарчмаас үзвэл юуны өмнө төр нь татварыг иргэдээс цуглуулж, хуримтлуулах, ийнхүү хуримтлуулсан хөрөнгийг нийтийн сайн сайхны төлөө, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, улсын аюулгүй байдал,

тусгаар тогтнолын баталгааг хангах зорилгод нийцүүлэн захиран зарцуулах үүрэг хүлээдэг. Иргэд татвар төлөх эсэх асуудлаар шүүхэд хандаж гомдлоо гаргах бүрэн эрхтэй ч татварын хууль тогтоомжийг зөрчих, эс тоох явдал гаргах ёсгүй гэсэн үг. Зарим хүн татвар өөрөө хууль бус зүйл, бүр дээрэм тонуул гэж үздэг ч татварын тогтолцоог зөв бүрдүүлж чадах аваас иргэний төлсөн татвар эргээд өөрт нь болон үр хүүхдэд нь ашиг тусаа өгөх гол зорилготой юм. Иргэдийн өнөөдөр төлж буй татвар ирээдүй, хойч үеийнхний тусын тулд хийж буй томоохон хөрөнгө оруулалт байх учиртай. Хэрэв өнөөдөр тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудлыг татварын орлогоор шийдвэрлэхгүй бол ирээдүйд зардал нь улам л нэмэгдэнэ.Цаашлаад татвар нь гал унтраах, гудамж талбайг цэвэрхэн байлгах аас эхлээд үр хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх, гэр бүлийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангах зэрэг өдөр тутмын амьдралд шаардлагатай үйлчилгээг тасралтгүй хангах хөрөнгийн эх үүсвэр болдог. Харин татвар төлсний хэмжээгээр төрийн үйлчилгээ чанартай, хүртээмжтэй байх ёстой. Түүнийг иргэдэд хүргэх үүрэгтэй албан хаагчид хариуцлагатай, шуурхай ажиллах үүрэгтэй. Тэр ч хэрээр тэд татварын орлогоос цалинжих эрхтэй байх учиртай ажээ. Өөрөөр хэлбэл, татвар нь хувь хүн дангаараа хийх боломжгүй ажил үйлчилгээг хамтдаа хийж гүйцэтгэх тэрхүү боломжийг олгодог учраас зөв зүйлдээ, зөв цаг хугацаандаа зарцуулагдаж чадах аваас үр шимээ хангалттай өгч чадна.

Товчхондоо “Соёл иргэншил оршин тогтнох үндэс нь иргэд татвар төлөхөөс эхэлдэг” гэж Америкийн нэртэй хуульч Оливер Уэнделл Холмс хэлсэнчлэн тусгаар тогтносон улс орны хөгжин цэцэглэх үндэс нь татвар болдог тул иргэд нь энэ үйлсэд хувь нэмрээ оруулах үндсэн үүрэгтэй гэж ойлгож болно.

Харин төр нь энэхүү үүргээ хангалттай гүйцэтгэж чаддаггүй улсад татвар нь иргэдийн нуруун дээр хүнд ачаа болж, эргээд татварыг эсэргүүцэх, татвар төлөхөөс зайлсхийх хандлага нэмэгддэг байна. Тиймээс төр оршин тогтнох баталгаагаа хангахын тулд татварын зөв, оновчтой бодлогыг хэрэгжүүлэх явдал чухал билээ. ■

“Татвар нь хувь хүн дангаараа хийх боломжгүй ажил үйлчилгээг хамтдаа хийж гүйцэтгэх тэрхүү боломжийг олгодог учраас зөв зүйлдээ, зөв цаг хугацаандаа зарцуулагдаж чадах аваас үр дүнтэй.”

Өмчлөх эрх ба үндсэн хуулийн хамгаалалт

Г.Агар-Эрдэнэ /Хуульч/



“Шударга ёсны хамгийн чухал шаардлага бол хүн бүрт өмчлөх эрхийг нь баталгаатай эдлүүлэх явдал юм.” – Цицерон

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн хоёр дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж заасан ба Арванзургадугаар зүйлийн гуравт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй...” гэж иргэдийн өмчлөх эрхийг “хамгаалсан” билээ.

Энд “хамгаалсан” гэдэг үгийг яагаад онцолж байна гэвэл угтаа өмчлөх эрх нь хүний жам ёсны, халдашгүй эрх бөгөөд энэ эрхийг төрөөс баталгаажуулах шаардлагагүй, харин хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх үүрэгтэй юм. Тодруулбал, хүний эрх, эрх чөлөөг нөхцөлдүүлэгч хамгийн гол эрх бол өмчлөх эрх бөгөөд амьд явах эрхтэй нэгэн адил үнэ цэнэтэй, халдаж, хязгаарлаж үл болох үндсэн эрх юм.

Өмчлөх эрх нь нийгэм бий болохоос өмнө буюу хүн үүссэн тэр цагаас эхлэн хүнтэй хамт хөгжиж, өөрчлөгдөж, хувьсаж ирсэн бөгөөд төр өөрөөс нь өмнө бий болсон жам ёсны шинжтэй энэхүү эрхийг өөрчлөх, хязгаарлах ёсгүй. Харин ч тэднийг хуульчилж, хамгаалах ёстой юм. Төр, нийгэм, хувь хүний харилцан шүтэлцээг өмчлөх эрхтэй холбон тайлбарласан Английн нэртэй онолч Жон Локк “Төр нь хүний эрх, эрх чөлөө, өмчийг хамгаалагч мөн” гэж хэлсэн байдаг. Тодруулбал, төр нь хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж байгаа учраас л оршин тогтнож буй хэрэг бөгөөд энэ бол нийгмийн хүсэл зориг юм.

Нийгмийн хүсэл зориг хаашаа чиглэж буй тухайг товчхон тайлбарлавал, хүн зөвхөн байгалийн хуульд захирагдаж энэ хуулийн шаардлагыг жам ёсны байдалд хэрэгжүүлэх нь өмчлөх эрхийн халдашгүй дархан байдлыг бэхжүүлэхэд хангалтгүй. Иймээс энэ бүхнийг шийдвэрлэхээр төрийг бий болгосон бөгөөд төр нь нийгэмтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа хэрэг. Гэрээний үндсэн дээр бүрэлдсэн төрийн

эрхэм зорилго нь хүн бүрийн өмчлөх эрх, бусад эрх чөлөөг хамгаалах явдал гэж үздэг.

Тэгвэл төр энэхүү эрхийг хэрхэн хамгаалах ёстой вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Өмчлөх эрхийг хамгаалах нэн тэргүүний шаардлага бол түүнийг Үндсэн хуульчлах явдал юм. Үндсэн хууль нь төрийн эрх мэдлийг хязгаарлан тогтоож, хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэх зорилгод үйлчилдэг учраас энэхүү суурь хамгаалалтыг хийх үндсэн баримт бичиг болдог. Хэрэв жам ёсны шинжтэй эрх, эрх чөлөөний халдашгүй байдлыг хангаж, түүнд хамгаалалт тогтооё гэж бодож байвал түүнийг Үндсэн хуульд тодорхойлон бэхжүүлэх ёстой гэж ихэнх судлаач үздэг. Учир нь бичмэл бус хэм хэмжээнд хэн дуртай нэгэн нь тайлбар хийх эрсдэлтэй тул бичмэл хэм хэмжээнээс илүү хурдан өөрчлөгдөх, гуйвуулагдах аюултай хэмээн тайлбарладаг. Иймд хүний халдашгүй эрхийг Үндсэн хуулиар хамгаалах асуудлыг чухалчлан үздэг байна.

Өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалаагүй тохиолдолд энэ нь “нүцгэн эрх чөлөө”-нөөс өөрцгүй хэмээн улс төр, эрх зүйн философич Алон Харел үзсэн бөгөөд эрх чөлөөг хамгаалах хүрээ хязгаарыг тогтоож өгснөөр түүний үнэ цэнэ өсдөг гэсэн нь бий. Иймд “хамгаалалтын хүрээ” буюу Үндсэн хууль нь хүний салшгүй, халдашгүй үндсэн эрх чөлөөг хамгаалахад тусгайлан зориулагддаг учиртай.

Эцэст нь тэмдэглэхэд орчин үеийн эрх зүйт улс бүр өөрийн Үндсэн хуультай, тэрхүү Үндсэн хууль нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн гол хэрэглэгдэхүүн нь болж байна. Үүнийг Орос гаралтай Америкийн философич Эйн Рэнд “Гэмт хэрэгтнүүдээс хүнийг хамгаалахын тулд Засгийг тогтоодог бол хүнийг Засгаас хамгаалахын тулд Үндсэн хуулийг бүтээдэг” хэмээн тодорхойлсон бөгөөд Үндсэн хууль нь хувь хүн болон төрийн хоорондын харилцааг зааглан тодорхойлж, өмчлөх эрхийг нүцгэн эрх чөлөө болж хувирахаас сэргийлэх ач холбогдолтой баримт бичиг болдог юм. ■

Английн нэртэй онолч Жон Локк “Төр нь хүний эрх, эрх чөлөө, өмчийг хамгаалагч мөн” гэж хэлсэн байдаг.

Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох хэрэгцээ, шаардлага


Б.Оюунсүрэн
/Улаанбаатар их сургууль,
Бизнес менежментийн тэнхим, Докторант/

Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох асуудал сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээнд ахицтай хөгжиж байна. Энэ нь иргэд өөрийн мөнгө санхүүгийн асуудалд оновчтой хуваарилан зарцуулах боломж олгож байгаа. Гэсэн хэдий ч залуучууд, залуу гэр бүл, дунд орлоготой иргэд рүү чиглэсэн хөтөлбөр үйл ажиллагаа маш хомс байна. Зөвхөн төсөл хөтөлбөрийн хүрээнд төрөөс амьжиргааны түвшин доогуур нэн ядуу иргэдийн амьдрал, аж ахуйг дээшлүүлэх зорилгоор тодорхой хугацаанд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нийгмийн нэг хэсэг масс руу хэт анхаарч зарим мэдээлэл, сургалт, сурталчилгаа шаардлагатай хэсгээ хаяад байна уу гэлтэй харагдах юм. Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох асуудал нь ганц нэг хүнд гэсэн утгаар бус тухайн иргэний амьдарч буй гэр бүлд нь чиглэсэн байх нь зүйн хэрэг.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод гэр бүлийн хөгжлийг хангах хүрээнд “Гэр бүлийн эдийн засгийн талаар бие даан хөгжих чадавхаа дээшлүүлэх, өмч хөрөнгө өсгөн арвижуулах аливаа шударга санаачлага, үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэж тусгасан байдаг.

Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал 2010 онд хийгдсэн суурь судалгаанаас харвал өнөөгийн залуусын гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн байдал нь 11,8% сайн, үлдсэн 88,2% нь дунд болон хангалтгүй гэсэн буюу таван хүн тутмын нэг нь муу бэлтгэгдсэн гэж хариулсан байна. Өрхийн төсөв, санхүүгээ хэрхэн оновчтой зарцуулах талаар 47,9% нь хаанаас ч мэдээлэл авахаа мэдэхгүй гэж хариулсан. Мөн гэр бүлийн зөрчил маргааны 42,2% нь мөнгө, санхүүгийн асуудлаас үүсдэг. Гэр бүлийн амьдралд тохиолдож буй бэрхшээлтэй асуудал нь 67,7% нь мөнгө санхүү байна гэж хариулснаас үзвэл

Гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн байдал



энэ чиглэлийн үйл ажиллагаа нийгэмд тодорхой хэмжээнд үгүйлэгдэж байгааг харуулж байна. Гадаадын улс орнуудад иргэд рүү чиглэсэн эдийн засгийн боловсрол олгох асуудал нь төрийн бодлогын хүрээнд зохицуулагддаг байна.

Монгол Улсын хувьд энэ асуудал нь албан сургалтаас илүүтэйгээр албан бус сургалтын хүрээнд хөгжиж байна. Сангийн яам, Дэлхийн банкнаас улсын хэмжээнд хэрэгжүүлсэн судалгааны ажлаас харвал иргэдэд санхүүгийн боловсрол олгох нь чухал гэж дурьдсан байна. Санхүүгийн боловсролоор дамжуулан иргэд өөрийн өрхийн төсвөө зөв захиран зарцуулахаас гадна санхүүгийн бүтээгдэхүүнийг оновчтой хэрэглэж сурах давуу талуудтай юм. Мөнгө менежменттэй зарцуулж чаддаг иргэн хадгалах, хэмнэх сэтгэлгээ маш сайн байдаг.

Хүн мөн хэмнэж, хадгалаж сурна гэдэг нь цаашлаад гэр бүлийн бүх гишүүнд үлгэр дуурайлал болоод зогсохгүй санхүүгийн зах зээлд хэрхэн санхүүгийн бүтээгдэхүүнийг ашиглах вэ гэсэн мэдлэг мэдээлэл авахыг хүсдэг. Ер нь иргэд санхүүгийн боловсрол сайн байх тусмаа л мөнгө зүгээр хадгалахгүй, эргэлтэд оруулж өсгөх, ашиг хүртэх боломжийг олж харж чаддаг.

Иргэдийн хувьд хадгаламж нь өнөөгийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй зарим нэг хэрэгцээгээ хязгаарлан ирээдүйн хэрэглээндээ зориулан төлөвлөн бэлдэж буй хөрөнгө юм. Хадгаламж нь гэр бүлийн хөрөнгө мэт боловч зарлага болдог шинж чанартай. Мөн гэр бүлийн хадгаламж нь банк бусад санхүүгийн байгууллагаар дамжин аж ахуй нэгж, компани, корпораци, жижиг бизнес рүү хөрөнгө оруулалт болж очдог. Орлогын доогуур түвшинд орлого, хэрэглээ хоёр тэнцэх хүртэл өрх хэрэглээгээ өр зээлээр буюу өмнөх хуримтлалаараа хангаж байдаг. Ийм үед хэдийгээр өрхүүдэд хадгалах, хуримтлуулах сонирхол байлаа ч ингэх боломжгүй. Харин орлого, хэрэглээ хоёр тэнцэж ирсэн үеэс эхлэн өрхөд хадгаламж үүсэх боломжтой болдог. Хадгаламж нь хэрэглээндээ зарцуулаад үлдэж буй орлогын тэр хэсэг юм.

Хуримтлал нь орлогын нэг хэсэг учраас орлого хуримтлал хоёр шууд хамааралтай. Орлого өсөхөд хуримтлал дагаж өснө. Орлого нэг нэгжээр нэмэгдэхэд түүний үр дүнд хуримтлалд гарч буй өөрчлөлтийг ахиуц хуримтлал гэнэ.

Сүүлийн үед, манай иргэд мөнгөн орлогынхоо тодорхой хэсгийг хадгалах нь нэмэгдэж байна. Энэ нь арилжааны банкууд олон болж, хувийн хадгаламж хийх боломж бололцоо өссөн. Хадгаламж нь орлогоо зөв хуваарилах ухаалаг найдвартай

арга юм.

Хадгаламжийн төрөл:

1. Хувийн хадгаламж буюу сайн дурын хадгаламж

2. Бизнесийн хадгаламж буюу ашгийн хадгаламж

Хувийн хадгаламжийг дотор нь мөнгөн хадгаламж буюу биет хадгаламж.

-Мөнгөн хадгаламжийг дотор нь хугацаатай мөнгөн хадгаламж, хугацаагүй мөнгөн хадгаламж гэж хоёр ангилна.

-Биет хадгаламж гэдэг нь алт, үнэт эдлэл, үнэ бүхий эд зүйлээ хадгалуулахыг хэлнэ.

Мөнгөн хадгаламж буюу мөнгөн даатгалын онцлог:

Мөнгөн хадгаламж нь өрх гэр нийт орлогоос нийт зардлаа хасаад үлдэж буй мөнгөн хөрөнгийг хадгалах буюу хуримтлуулахыг хэлдэг. Мөнгөн даатгал гэдэг нь өрх гэр өөрийн орлогоос тодорхой зорилго тавьж санхүүгийн төлөвлөгөө

гаргахдаа хамгийн их эрсдэл гарч болзошгүй, гэнэтийн зардалд зориулж мөнгөн даатгал хийлгэхийг хэлнэ. Жишээлбэл, амь нас эрүүл мэндээ даатгуулах, ингэснээр гэнэтийн өвчин зовлон учрах, эрүүл мэндийн хохирлын үед даатгалаас нөхөн олговор авч болно. Ихэвчлэн мөнгөн даатгалыг хүн эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийлгэдэг юм. Даатгал нь эрсдлийн зарим хэсгийг даатгах эдийн засгийн хэрэгсэл юм.

Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох нь санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүнүүдийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болохоос гадна оновчтой удирдан зохицуулах менежментийг эзэмшинэ.

Тиймээс санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд энэ чиглэлийн үйл ажиллагаанд анхаарч, тодорхой мэдээлэл, мэдлэг олгох үйл ажиллагаа, сурталчилгаа хэрэгцээтэй байгаа юм. ■



Монголын нэргүй баатрууд

А.Билгүүн /Эдийн засагч/

Жирийн иргэдийн нэрнээс авхуулаад нийслэл хотын маань нэр хүртэл баатар гэдэг

үгийг бидэнд өдөр тутам сануулсаар байдаг. Бид түүхээс, мөн өнөөгийн нийгмээс баатруудыг эрэн хайж тэдний

үлгэр жишээгээр өөрсдийн өдөр тутмын шалгууруудыг давахыг хичээдэг, нэг үгээр бидэнд сэтгэлийн хүч хайрлах

тэрхүү төгс төгөлдөр нэгнийг хайсаар эцэст нь заавал хэн нэгэнд хүчээр тохож түүнийгээ нийтээрээ магтан дуулах нь коммунизмаас үүдэлтэй муу зуршил. Үнэндээ өнөөдөр бидний дунд аж төрж буй баатруудыг тоох нь битгий хэл ад үзэх нь ихэсч байгаа нь энэхүү нийгэм буруу тийшээ яваад байгааг илэрхийлнэ.

Баатар гэж хэн юм бэ? Оксфордын нэвтэрхий тольд “баатар” хэмээх үгийг

эхлээгүй хөрөнгүүдийг хэлнэ.

Тэдгээр хөрөнгүүдийг худалдан авч нэмүү өртөг шингээн эдийн засгийн эргэлтэд оруулах хамгийн шударга систем бол хувийн салбар гэдэгтэй маргах нэгэн гарахгүй. Учир нь тэд бүх зүйлийн үнийг байгалийн жамаар нь тогтоож өгдөг, чанар муутай бичгийн цаасыг хямдханаар, чадвартай мэргэжилтний цалинг аяндаа өндрөөр

дэлхийтэй танилцуулсан. Тэднийг 2000 оны эхээр барууны өндөр хөгжилтэй орнуудаас техник технологи, хөрөнгө оруулалт татахаар мэрийж байхад Монгол хэмээх улсыг газрын зураг дээр хаана байдгийг мэддэггүйчүүд их байсан гэдэг. Одоо ч гэсэн мэр сэр байсаар л байгаа.

Үнэндээ сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтөөрөө олон улсыг “өнгөлж”

“Тэдгээр нэргүй баатрууд 1993 онд нэрлэсэн үнээр 768 мянган долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бичил эдийн засгийг 2012 онд 8.7 тэрбум долларын (11.3 дахин том) бөгөөд дэлхийд хөгжлийнхөө хурдаар тэргүүлэгч эдийн засаг болгожээ.”

“эр зориг, ололт амжилт, зөв шударга үйлсээрээ бусдад хүндлэгдсэн нэгэн” хэмээн тайлбарлажээ. Тэгвэл бидний дунд баатрууд оршоор л байгаа юм байна. Үгүй ээ, гудамж талбайд жагсаал зохион байгуулж, хэзээ ч биелэгдэшгүй хүсэл мөрөөдлөө нийгэмд тулгаж, түүгээрээ өөрийнхөө “од” болох өчүүхэн хүслээ биелүүлэх тэдгээр нөхөд биш шүү. Харин идэх талхнаасаа хэмнэн байж, гэр орон гал голомтоо барьцаанд тавин бизнес эхлүүлсэн тэдгээр бизнес эрхлэгчид болон тэрхүү хувийн салбарт ажиллагсад л жинхэнэ бидний дунд орших баатрууд мөн.

Яг л байлдаж буй баатруудын ижлээр бизнесийн талбарт алдагдалтай ажиллаж бүхий л эд хөрөнгөөрөө хохирсон баатрууд ч бий. Дайсанд урвасан цэргүүд шиг хууль бус аргаар ашиг хайж яваад баригдаж “толгойгоо авахуулсан” хулчгарууд ч бас бий. Тэд улс оронд байсан сул баялгуудыг хуулийн дагуу эргэлтэд оруулж баялаг бүтээдэг чанараараа л баатар хэмээх тодотгол зүүх эрхтэй. Баялаг гэхээр уншигч та зөвхөн эрдэс баялга хэмээн бүү эндүүрээрэй, эргэлтэд ороогүй баялаг нь ажилгүй байгаа иргэн, зарагдаж амжаагүй байгаа бичгийн цааснаас эхлээд нийгэмд хараахан эрэлт нь үүсч

үнэлж эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Бид хувийн салбарын ач тусыг дурсахдаа юун түрүүнд улсад төлдөг татвар болон шинээр бий болгосон ажлын байрыг онцлох нь олонтаа ч энэ бол зөвхөн нэгэн хэсэг нь. Харин тухайн бизнесийн худалдан авсан түүхий эд, албан байрны түрээс гэх мэт зардлууд нь хүртэл дотоодын эдийн засагт агрегат эрэлт үүсгэж байдаг бөгөөд үүссэн агрегат эрэлт нь бусад төрлийн бизнесийн цэцэглэн хөгжих зах зээл нь болж байсныг сүүлийн 23 жил бидэнд нотолжээ.

1990 онд бидний алдаршуулж байсан коммунизм задран унаж, бидний “ах” хэмээн авгайлдаг байсан “баатрууд” Монголыг орхин гарах үед манай эдийн засаг хоол нэхэн ангалзах ангаахайнууд шиг байдалтай үлдсэнийг ихэнх уншигч санаж байгаа. Тэр л үед бидний дунд өнөөгийн нэргүй баатрууд төрөн гарсан. Тэдгээр нэргүй баатрууд 1993 онд нэрлэсэн үнээр 768 мянган долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бичил эдийн засгийг 2012 онд 8.7 тэрбум долларын (11.3 дахин том) бөгөөд дэлхийд хөгжлийнхөө хурдаар тэргүүлэгч эдийн засаг болгожээ. Тэд урьд нь зөвхөн ЗХУ-ын техник технологиор хөдөлдөг байсан эдийн засгийн “нүдийг нээн”

гадны хөрөнгөтнүүд Монгол руу хошуурч байсан нь эрдсийн бүтээгдэхүүний үнэ болон БНХАУ-ын 1.3 тэрбум хүнтэй зах зээлийн эдийн засгийн үсрэнгүй өсөлттэй л нягт холбоотой бидэнд олдсон цухасхан боломж байжээ. Нэгэнт бий болсон эдийн засгийн үсрэнгүй хөгжил, түүнийг бүтээсэн нэргүй баатрууд бол байгалийн жамаар оршин тогтнох хүчин зүйлс. Гэвч тухайн хөгжил цэцэглэлтийг өөрийн нэр дээр, өөрсдийн хүслээр жолоодох жинхэнэ шуналтнууд ч энэхүү хөгжлөөс хоцорсонгүй. Аливаа зохиолд амжилттай, алдартай баатрыг устгаж түүний амжилтыг өөрт тохох сонирхолтой “Исмэл тайжууд” байсаар байдаг нь амьдрал дээр ч үнэн бололтой. Тэдгээр “Исмэл тайжууд” Монголын эдийн засгийн 23 жилийн хугацаанд туулж, хөгжиж ирсэн хувийн салбар хэмээх механизмыг үгүйсгэн, хүрсэн жоохон амжилтыг төрөөр дамжуулан ард иргэдэд хувааж өгсөн нэр зүүн хувийн улс төрийн ашиг хонжоо болон цаана нь бий болох авлигалын зах зээлийг урьтал болгосоор 2012 онд хүслээ гүйцэлдүүлж чадсан. Тэд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах “эх оронч” нэртэй хуулиараа нэргүй баатруудыг ажилгүй болгон олон нийтийг төөрөгдүүлэх замаар бүх зүйлийг зөвхөн өөрсдөөсөө хамааралтай

“Эрдэмт хүн даруу, их мөрөн дөлгөөн байдгийн ижил Монголын нэргүй баатрууд өнгөрсөн 23 жилд чимээгүй боловч бүтээсэн нь их байжээ. Гавьяаг нь бид өнөөдөр ч эдэлсээр байна. Цээжээ дэлдэх “эх оронч”-дын ижил тэд магтан дуулуулахыг хүсэхгүй, авлига авч бусдыг дарамтлахыг ч хүсэхгүй. Зүгээр л тэдэнд ажиллах боломж олгоход л хамгийн том шагнал нь тэр.”

болгохыг зорьдог. Нийгэмд айдас түгээж, бутарган устгаад эхэлчихсэн тэрхүү “Исмэл тайжуудын” ачаар эдийн засгийн өсөлт 2011 онд дээд цэгтээ буюу 17.5 хувьд хүрч байсан бол 2012 онд 12.3 хувь, 2013 онд нэг оронтой тоонд орсон. Дээр дурьдсан агрегат эрэлт багассанаар гадаад худалдааны эргэлт 2011 онд 11.4 тэрбум доллар байсан бол 2012 онд 11.1 тэрбум болж харин 2013 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс даруй 15 хувь буурсан эдийн засгийн идэвх ямархуу түвшинд байгааг харуулж байна. Идэвхгүй байгаа эдийн засагт эрэлт нь нийлүүлэлтээсээ түрүүлж багасах нь ойлгомжтой.

Инфляцийн түвшин 9.8 хувь болон буурсан үзүүлэлтийг эдийн засагчид дисинфляци буюу эдийн засгийн хөрөлтийг илэрхийлсэн үзүүлэлт хэмээн болгоомжилдог боловч манай бодлого боловсруулагчид бараа материалын үнийн өсөлттэй тэмцсэн мэтээр ярьж нийгмийг төөрөгдүүлсээр. Эдийн засгийн сулралаас үүдсэн төгрөгийн ханшаа барихын тулд Төвбанк нь зөвхөн 2013 оны дөрөвдүгээр сарын туршид нийт есөн удаа валютын зах дээр интервенц хийж нийт 258.4 сая доллар своп (эрсдэлийн солилцоо) хэлбэрээр валютын нөөцөөсөө борлуулсан. Гэсэн ч

төгрөгийн ханш тухайн сардаа 0.16 хувь, жилийн хугацаанд 8 хувиар унасан билээ. Мэдээж дэлхийн эдийн засгийн байдал дотоодын уул уурхайн салбарт нөлөөлж байгаа боловч дээрх хууль болон манай “эх оронч”-ийн маск зүүсэн улс төрчдийн урьдчилан таахын аргагүй араншин нь дотоодын бусад салбарыг ч гэсэн гадаад орчноос тасдаад нэг жилийн нүүр үзэж байна. Хэдийгээр тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх боловч хувийн салбарын хөрөнгө оруулалтын хэлцлүүд Засгийн газраас зөвшөөрөл авах хүндхэн даваанаас салгаагүй л байна. Угаас тэр шалгуурыг нь давсан хэлцэл ч сүүлийн нэг жилд гарсангүй, тийм сонирхол ч байсангүй. Нэргүй баатруудаа магтан дуулдаггүй юмаа гэхэд нийтээрээ үзэн ядах өнөөгийн үзэгдэл цаашид үргэлжилбэл бид 1990-ээд оны гамшгийн байдалд хүрэх нь гарцаагүй. Эрдэмт хүн даруу, их мөрөн дөлгөөн байдгийн ижил Монголын нэргүй баатрууд өнгөрсөн 23 жилд чимээгүй боловч бүтээсэн нь их байжээ. Гавьяаг нь бид өнөөдөр ч эдэлсээр байна. Цээжээ дэлдэх “эх оронч”-дын ижил тэд магтан дуулуулахыг хүсэхгүй, авлига авч бусдыг дарамтлахыг ч хүсэхгүй. Зүгээр л тэдэнд ажиллах боломж олгоход л хамгийн том шагнал нь тэр. ■


Нийгмийн эрүүл мэндийн даатгал уу, халамжийн эрүүл мэндийн даатгал уу?

Ж.Цогзолмаа /Сэтгүүлч/

Өнөөдөр Монгол Улсад өвчтөний тусламж, үйлчилгээний зардлыг 115 оношийн хамааралтай бүлгээр тогтоосон байна. Хамгийн хүнд болох зүрхний мэс засал хийлгэсэн тохиолдолд 536 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэг удаад төлөхөөр бас хуульчилжээ. Харин өнөөдөр энэ мэс заслын үндсэн төлбөр таван

сая төгрөгөөс дээш өртөгтэй байгаа гэвэл эрүүл мэндийн даатгалаас төлж буй төлбөр нь түүний арван хувьд ч хүрэхээргүй. Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлж буйгаар нийт тусламж, үйлчилгээний төлбөрийн 10-15 хувийг даатгуулагч өөрөө, үлдсэнийг нь төр хариуцдаг гэж буй ч бодит байдалд дээрх нөхцлөөр үйлчилгээ нь хэмжигдэж байгаа юм.

Хөдөлмөр эрхлэгчид цалингаасаа дөрвөн хувийн шимтгэл төлдөг бол 0-16 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, хорих ял эдэлж байгаа ялтан зэрэг хүний шимтгэлийг сард 670, жилд 8040 төгрөгөөр тооцон төр хариуцдаг. Ажил олгогч даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангийн 83.5 хувийг бүрдүүлдэг ч зардлын дөнгөж



хийж зоригтойгоор нэг алхам урагшлах ёстой юу? Бидний жишээ авах дуртай хөгжингүй орнуудын туршлага эрүүл мэндийн даатгалын хойшдын чиг хандлагад чухал нөлөө үзүүлэх болов уу гэдэг үүднээс нэгэн жишээг дурьдмаар санагдлаа. Австрали улсын хувьд даатгалын системээ уян хатан, иргэдэд ашигтай байдлаар шийдвэрлэдэг байна. Тодруулбал, бүх иргэн эрүүл мэндийн даатгал төлөх ёстой бөгөөд тодорхой хязгаараас давсан орлоготой бол хувийн эрүүл мэндийн даатгалын компанид даатгуулах ёстой төдийгүй хэрэв хувийн даатгалд хамрагдаагүй бол нэмж татвар төлдөг байна. Мөн тухайн иргэн хувийн даатгалд хамрагдвал хураамжийнх нь 30-40 хувийг төрөөс даадаг ажээ. 2010 оны гуравдугаар сарын байдлаар нийт австраличуудын 44,5% нь хувийн эрүүл мэндийн даатгалтай байна гэсэн судалгаа байна.

17.1 хувьтай тэнцэж байна. Гэтэл эсрэгээрээ төр хариуцах иргэд эрүүл мэндийн даатгалын сангийн 12.6 хувийг бүрдүүлдэг хэрнээ нийт зардлын 62.9 хувийн үйлчилгээ авч байна.

Ингээд бодохоор нэг хүнд ногдох эмчилгээний зардлын хэмжээ маш бага хувьтай гарч байна. Үүнээс болоод эмчилгээний чанар буурах, эмнэлгийн ачаалал нэмэгдэх гэсэн сөрөг хандлагууд бий болж байна.

Ачааллаа даахаа больсон эмнэлгүүдэд даатгуулагчид очоод ч өмнө төлсөн шимтгэл, төлбөрийнхөө үр дүнг үзэж чадалгүй бухимдлаа барсаар гарч буйн энгийн шалтгаан энэ юм. Өөрөөр хэлбэл, даатгуулагч аль хэдийнээ мөнгөө төлчихөөд байхад ч сэтгэлд хүрсэн үйлчилгээгээ авч чаддаггүй. Өнөөдөр эмнэлэгт үзүүлэх шаардлагатай боллоо гэхэд хэдэн сарын дараа дугаар авах, ор байхгүйн улмаас үүдний хонгилд хэвтэх зэрэг хүндрэлтэй асуудал олон байна.

Төр өөрийн заавал хариуцах ёстой иргэдийн эрүүл мэндийн асуудлыг эв санааны нэгдлийн зарчмаар түрий барьж өөртөө бус ажил хөдөлмөр эрхэлж, даатгалын сангийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг бүлэгт оногдуулж байгаа нь нэг талаар шударга бус мэт.

Даатгалынхаа үр шимээ хэрхэн хүртэх вэ?

Миний нэг танил улсад 22 жил ажилласан нэгэн. Энэ хугацаанд тасралтгүй эрүүл мэндийн даатгал

төлсөн. Нэг ч удаа эмнэлэг гэж харайлгаж яваагүй тэрбээр өнгөрсөн жил айхтар өвдөж, хүнд мэс засалд орохдоо зургаан сая төгрөг өөрөөсөө гаргасан юм. Мэс заслын дараа түүнд харьяа Халамж, үйлчилгээний хэлтсээс нь 600 мянган төгрөг өгснөөс өөрөөр эрүүл мэндийн даатгалын үр ашгийг амсаагүй. “Би мэс засалд төлсөн мөнгөнөөсөө илүү ихийг л эрүүл мэндийн даатгалд төлсөн байх. Гэвч энэ олон жил ингэж даатгал төлчихөөд өөрөөсөө хамаг төлбөрөө хийж байгаагийнхаа учрыг олохгүй юм” гэж тэрбээр хэлсэн. Энэ бол даатгал нэрээр улсад мөнгө тушааж байгаа бидний олонход тохиолдож буй хамгийн том бэрхшээл юм. Хичнээн даатгал төлсөн байлаа ч хүндээр өвдлөө гэхэд хэтэвчиндээ мөнгөгүй л бол дуусаа гэсэн үг болоод байна.

Даатгалын шимтгэл төлж буй даатгуулагчдын хувьд баталгаатай, чанартай, түргэн шуурхай эрүүл мэндийн үйлчилгээг авч чадаж буй эсэхээс хамаарч үр шим хэмжигдэнэ. Түүнээс биш даатгал гэдэг чинь өдөр шөнөгүй ажиллаж, даатгалд шимтгэл төлчихөөд хожмын нэг өвдөх зовох цагт хоосон халаасаа тэмтрээд аврал хайхын нэр биш. Монголд эмнэлэгээр явах үнэхээр хэцүү гэдгийг хэн хүнгүй л хэлнэ. Эмч нь гайгүй байлаа гэхэд эм, тоног төхөөрөмж нь үеэ өнгөрөөсөн байх жишээтэй.

Цаашид яах хэрэгтэй вэ, ингээд яваад байх уу аль эсвэл өөрчлөлт

Хувийн даатгалын үр дүнд даатгуулагчийн хамрагдах боломжтой эмнэлэгийн цар хүрээ илүү өргөжиж заавал улсын эмнэлгүүдэд үзүүлэх шаардлагагүйгээр хувийн эмнэлгүүдээс ч бүрэн дүүрэн үйлчилгээ авах нөхцөл бүрдэж буй хэрэг юм. Энэ нь нэг хүнд ноогдох даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлэгийн ачааллыг бууруулахад томоохон үүрэг гүйцэтгэдэг байна. Ийнхүү Австрали шиг хувийн болон улсын эрүүл мэндийн даатгалын хослолыг нэвтрүүлсэн улсууд олон байдаг бөгөөд манай улсад ч тийм боломж бий. Бид дан ганц нийгмийн даатгалын “гарыг” харж суухгүйгээр өөр бусад боломжийг эрэлхийлж, амьдралд нэвтрүүлэх замаар эрүүл мэндийн салбарыг цогцоор хөгжүүлэх цаг нь болжээ. 2013 он ■



Төрийн өмчөөс иргэд хожихгүй байна

А.Билгүүн /Эдийн засагч/

Хүн өөрийн өмч хөрөнгийг бусдынхаас илүүтэйгээр арчилж торддог нь гэм биш зан, байгалиас заяасан дасан зохицох чанар нь ажээ. Тиймдээ ч бид чинь уг нь өмчийн хэлбэрийг нь заагаад өгчихсөн ардчилсан нийгэмд амьдардаг улс. Манай Үндсэн хуульд хувийн, төрийн, нийтийн гэж гурван төрлийн өмчлөл дурдагддаг. Дээрх гурван төрлийн өмчлөлөөс нийтийн өмчийг нь төрийн өмчтэй эндүүрэх хэсэг цөөнгүй, социализмын үед тэгээд ойлгуулчихсан юм чинь. Миний мэдэхийн Гандантэгчилэн хийд маань ямар ч байсан нийтийн өмч гэдэг тодотголтой. Соц нийгмийн үед л хувьсгалын өмчийг “нүдний цөцгий мэт” хайрлах ёстой хэмээн сурталдаж, хувьдаа машин авсан нэгнээ нийтээрээ үзэн яддаг “гажиг” сэтгэхүйг бидэнд хүчээр тулгаж байсан нь хүний байгалиас заяасан араншинг эвдэхээр оролдож, нуулгүй хэлэхэд боолчилж байсан байгаа юм. Тиймдээ ч тэр нийгэм нуран унасан, учир нь социалист эдийн засгуудыг хөдөлгөгч хүч болох хямд ажиллах хүчин туйлдсан бөгөөд 70 жил хууртсан хүмүүс “хангалттай” гэж бодсон бизээ. Төрийн өмчөөс яагаад иргэд хождоггүй талаар хэдэн жишээ дурдъя.

Баримт 1: Хувийн өмч бол эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр

Социализмын сүүлээр буюу 1989 онд Монгол Улс 24.67 сая толгой малтай байжээ. Тухайн үед малынхаа тоог 30 саяд хүргэнэ гэдэг “мөрөөдөл” байлаа. Харин ардчилал ялсан 20 жилийн дотор 2009 он гэхэд малын тоо 78.4 хувиар

өссөн байх юм. Одоо бүр 41 сая хол даваад явчихлаа. Яагаад ингээд огцом өссөнийг нь гайхах зүйл алга. Хамгийн чухал нь мал иргэдийн хувийн өмч болсон явдал. Хүн өөрөөсөө хулгай хийдэггүй, харин ч илүү өсгөн үржүүлэхийг боддог. Түүгээр ч зогссонгүй нэгэнт хувийн өмч болсон тул мал маллаж чадахгүй бөгөөд дургүй нэгнүүд нь өөрийн малаа бусдад худалдах, түрээслэх эрхтэй болсноор “мэргэжлийн” малчид бий болох эх үүсвэр нь тавигджээ. Үнэхээр хуучин “Мянгат малчин” болох нь одон медалийн төдий байсан бол өнөө үед үнэхээр мянган малтай хүнд бол одон медаль гэдэг төмөр төдий болжээ.

Баримт 2: Хувийн өмч шударга өрсөлдөөний түлхүүр

Хувиараа бизнес эрхэлдэг хэн ч гэсэн шударга өрсөлдөөнийг хүсдэг. Тэгснээрээ ч нийгэмд маань хүн төрөлхтөн дэвшиж, хөгжиж байдгийн тодхон жишээ нь “Microsoft”, “General Electric”, “Mercedes Benz” гээд үндэстэн дамнасан томоохон компаниуд. Дээрх компаниудын амжилтын гол тулгуур шударга өрсөлдөөнд манлайлах. Харин Монголд бол өнөөдөр бизнесийн өрсөлдөөн гэдэг нь яаж ийж байгаад томоохон төрийн компанид “шахааны бизнес”-тэй болчихвол өрсөлдөгчдөө “хол хаяна”. Цаад төрийн компаниуд нь ч тоохгүй, өөрийн танил талдаа л бизнесийг нь өгч байвал гарах зардал бол сонин биш. Учир нь тухайн төрийн компани алдагдалтай ажиллалаа гээд хариуцлага хүлээхгүй, тооцох ч үгүй. Төр яагаад өөрийн компанитайгаа



хариуцлага тооцдоггүй гэж үү? Учир нь ашгийн төлөө компанитай хариуцлага тооцох нь төрийн үүрэг биш, төр иргэддээ үйлчлэх л ёстой, иргэд үйлчилгээг нь харж сонголтоо хийдэг болохоос тэр ашгийн компанитай хариуцлага тооцно гэдэг тийм ч чухал биш. Харин хувийн компаниуд бол ширхэг цаас авсан ч гэсэн хаана илүү чанартай бас хямдхан цаас байгааг нь хайхаас биш танил тал, хамаатан садан тэнд сонин биш ажээ. Тиймдээ ч ханган нийлүүлэгчээ сонгохдоо үнэ, чанараар нь ангилахаас биш садан төрлийн хэлхээ сонин биш ажээ.

Баримт 3: Хувийн өмч үрждэг

Мал үржих ойлголт биш шүү. Харин эдийн засгийн “үржүүлэгч үзэгдэл” гэдэг ойлголтын талаар дурдах гэсэн юм. Мал аж ахуйн салбар дээр жишээ авъя л даа. Монголын мал 40 сая гараад ирэхээр дөчин сая малын чанартай, хямдхан тэжээл хэн нийлүүлж чадах вэ гэдэг уралдаан болно. Тэгэхээр малын тэжээл үйлдвэрлэдэг эсвэл импортлогч компаниуд хийх ажилтай болноо доо. Тэр тэжээлийн үйлдвэрүүдэд ажиллах хүчин, тээвэр, шатах тослох материал, бичиг хэргээс авхуулаад хэрэгцээ зөндөө үүснэ. За тэгээд малын эмчээс эхлээд нэмнээ, лаа, шүдэнз гээд зах зээлийн эрэлтийг үүсгэнэ.

Тэр нь эргээд ажлын байр, татвар, урсгал зардлууд гэх мэтээр бусад салбартаа нөлөөлдөг. Энэ бол зөвхөн мал аж ахуйн салбарын жишээ шүү. Уул уурхайн салбар бүр нүсэр бөгөөд эдийн засагт үүсгэдэг эрэлт хэрэгцээ

нь ч асар их. Монголд уул уурхайн хайгуулын хөрөнгө оруулалт хийхэд дагаад геологийн компаниуд, өрмийн компаниуд, бүр ШУТИС, МУИС-ийн Геологийн ангийн оюутнууд хүртэл яаж олшрохыг бид гэрчилсэн шүү дээ. Зөвхөн геологичдоор ч зогсоогүй тээвэр, хоол хүнс, барилгын компаниуд хүртэл ажлаа дийлэхээ байж тэр чигээрээ орлого ихтэй, олон хүнийг ажлын байраар хангадаг нүсэр салбар болсон.

Баримт 4: Хувийн өмч нийтийн өмч болдог

Улстөрчид “Монголын байгалийн баялгийг олон улсын бирж гэдэг ломбардад аваачиж тавиад авсан мөнгийг нь гадаадууд идчихлээ” гэж хашгирах мода дэлгэрчээ. Аливаа томоохон төслийг хэрэгжүүлж эхлэхэд ихээхэн нөөц бололцоог зайлшгүй дайчлах хэрэгтэй болдог. Энэхүү нөөц бололцоог нэгэнт ганц хүн дангаараа гаргаж чадахгүйд хүрвэл нийтээрээ нийлээд хийхээс өөр аргагүй. Жижиг

зүйлийг ганцаараа эзэмшсэнээс том зүйлийг олуулаа нийлж эзэмших нь улам хавтгай болж бас улам ширүүн өрсөлдөх нь өнөө үед шалгарсан жишээ.

Ингээд сайн тордож чадсан хувийн өмч нийтийн өмч болдог, түүнийг нь хэрэгжүүлэгч нь хөрөнгийн бирж. Тэрхүү хөрөнгийн бирж дээр байгаа нийтийн өмчийг хэн ч эзэмшиж болох бөгөөд засаглалд нь оролцож болно. Алдагдалтай ажиллаад байвал удирдлагыг нь халж ч болно. Хэзээ нэгэн цагт Монголын мал аж ахуйн нэгэн компани (эсвэл малчин) нийтийн компани болж л таараа. Учир нь Монголын мал аж ахуй, Австрали, Шинэ Зеландын мал аж ахуйтай өрсөлдөхөөр тулгарна, тэр үед л битгий “малыг минь ломбардад тавьчихлаа” гэж хэлээсэй билээ.

Дүгнэж хэлэхэд иргэд маань нийтийн эзэмшлийн өмчөө хамгаалах нь зөв. Харин төрд эзэмшүүлж хамгаалуулна гэвэл “чононд хонио маллуулахаар” өгсөнтэй ижил зүйл биз. Монгол Улсын

ДНБ 2012 оны үнээр 14.6 их наяд төгрөг, үүнээс 4.8 их наядыг нь төр гүйцэтгэсэн байдаг бол үлдсэнийг нь хувийн өмчөөр гүйцэлдүүлжээ.

Хувийн салбар 9.8 их наяд төгрөгийн зах зээлийг үүсгэсэн нь шударга өрсөлдөөний талбар, цаашдаа нийтийн өмч болох хэсэг гэдгийг бид ойлгох цаг нь болжээ.

Харин төр нийтээс авсан өмчөө нийтэд нь буцааж өгвөл зохино. Социализм хэмээх журмын нийгмийн үед төр нь зөвхөн хувийн өмчийг хураагаад зогсоогүй бүр нийтийн өмчийг өөрийн болгосон нь гайхалтай. Тэр ч бүү хэл одоо буцааж өгөхгүй амь тавин зууралдаж байгааг нь яана. Та бидний өдөр тутамд, тэр ч байтугай секунд тутам хэрэглэдэг агаар, ус, газар шороог хүртэл төр маань өмчилчихөөд байна. Тэгээд тэр өмчийг нь ашигласан хүн бүр, компани бүрийг төрийн өмч болгоно гэнэ үү. Одоо нийтэд тэр өмчийг буцааж өгөх цаг нь болсон бус уу? ■

Монголын төрийн оролцоо хэрээс хэтэрлээ

Ё.Энхбаяр (философич)

ХХ зууны суутнуудын нэг К.Поппер (1902-1994) “Төрийн оролцоо эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй хэрэгтэй тэр л хэмжээгээр хязгаарлагдах ёстой” гэж хэлсэн байдаг. Энэ хүнийг “нээлттэй нийгэм” хэмээх үзэл санааг үндэслэгч гэдгийг дурьдах нь илүүц биз.

Төрийн оролцоог хамгийн бага түвшинд байлгаж байж л хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан иргэний, нээлттэй нийгэм байгуулдаг тухай тэрээр ийн хэлсэн хэрэг.

Төрийн оролцоо их байвал үргүй зардал ихэсч, эдийн засаг өсөхгүй, өслөө ч иргэндээ наалдахгүй болж, хүний эрх, эрх чөлөө боомилогдож, хүнд суртал газар авч, улмаар авлига цэцэглэдэг нь ёс мэт. Төрийн эрх баригчид өөрсдийн хувийн үзэл бодол, итгэл үнэмшлээ хуулийн дээгүүр тавьж үнэн зөв гэж итгээд иргэдэдээ түүнийгээ

тулган хүлээлгэж эхэлдэг. Ийм нийгмийг “хаалттай нийгэм” гэдэг.

Чухамдаа иргэнийхээ хувийн хүслийг хязгаарлан нийгмийн төлөө гэсэн сэтгэлгээтэй болгож чадсан, төрд ажилладаг хүмүүс нь эрх мэдлээсээ илүүтэй иргэдийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээсэн, нийгмийн үнэт зүйлс төрд ажилладаг хүмүүсийн үзэмжээр биш олон нийтээр үнэлэгддэг, нийгмийн хүсэл зориг эрх мэдэл бүхий хүмүүсийн хувийн үзэл бодлоор биш хууль эрх зүйгээр тодорхойлогддог тийм нийгэм ардчилалын туйлын зорилго, хүн төрөлхтөний мөрөөдөл билээ.

Нийгмийн амьдралд төрийн оролцоо ямар хэмжээнд байна вэ?

Нийгмийн амьдралд төрийн оролцоо ямар хэмжээнд байгааг үнэлдэг хэд хэдэн аргачлал байдаг. Хамгийн энгийн арга бол улсын төсөв нийгмийн нийт баялгийн хэдэн хувь байгаагаар

тодорхойлох явдал юм. Өндөр хөгжсөн орнууд улсын төсвөө дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрүүлдэггүй гэдгийг энд онцольё.

Монгол Улсын 2013 оны батлагдсан төсвөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,088.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 40.2 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 7,444.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 42.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 356.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай байхаар тус тус тооцогдсон байна.

Эндээс Монгол Улсын төрийн оролцоо 42,2 хувь байна гэж үзэж болно. Бид бүхэн 100 төгрөг олоод 42 төгрөгийг нь буцаагаад төрдөө зарцуулж байна гэсэн үг. Энэ бага байна уу?

Хэрвээ та бизнес хийдэг бол 100 төгрөг олоод 42 төгрөгийг нь төрд буцаагаад өгөхгүй л болов уу.

Нөгөө нэг арга бол төрийн нэг албан хаагчид ногдох иргэний тоог тодорхойлох явдал юм. Монгол Улсад 2013 оны нэгдүгээр сарын байдлаар Төрийн албаны зөвлөлөөс гаргасан статистикаар 162769 төрийн албан хаагч байна. 2005 онд төрийн албан хаагчийн тоо 120581 байсан бол 2013 онд даруй 42188-аар нэмэгдсэн байна. Энэ нь 2005 оныхтой харьцуулахад сүүлийн долоон жилд төрийн албан хаагчийн тоо даруй 34,9 хувиар нэмэгдсэн гэсэн үг. Төрийн албан хаагчийн тоо жилээс жилд нэмэгдлээ гээд төрийн албаны чанар хүртээмж 34,9 хувиар нэмэгдсэн үү?

2013 оны зургаадугаар сарын 1-ний байдлаар Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Монгол Улсын хүн ам 2,893,404 байна. Дээрх төрийн албан хаагчийн тоог хүн амьд харьцуулвал 18 хүн тутамд нэг төрийн албан хаагч буюу нийт хүн амын 5,6 хувь нь төрийн албан хаагч байна гэсэн тоо гарч байна. Хүн амын 5,6 хувийг эзэлж буй төрийг нэг жилд тэжээхийн тулд бүх монгол хүний бүтээсэн баялгийн 42,2 хувийг зарцуулж байна гэсэн үг. Энэ бага тоо юу?

Тэрхүү улсын төсвийн 7,444 их наяд төгрөг бүхэлдээ төрийн албаны цалин, урсгал зардалд явахгүй л дээ. Мэдээж зарим хэсэг нь нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн хөрөнгө оруулалтын зардал. Гэхдээ л их тоо санагдана. Төр үнэндээ данхар биш байна гэж үү бидний олж байгаатай харьцуулахад.

Авлига төрийн оролцоотой холбоотой юу?

ХБНГУ-ын иргэн Петер Айгены санаачлагаар 1993 онд байгуулагдсан “Transparency International” хэмээх төрийн бус байгууллагаас жил бүр авлига, хээл хахуулийн олон улсын индексийг гаргадаг.

Монгол Улс 2012 оны авлига, хээл хахуулийн индексээр 176 орноос 36 оноогоор 94 дүгээр байрт орсон байна. Уг нь 100 оноо авсан байх ёстой юм байна л даа. 2011 оны индексээр Монгол Улс 27 оноогоор 120 дугаар байрт байсан билээ. “Бид нэг жилийн дотор чамгүй их ололт олоо” гээд авлигагүй болчихсон мэт хөөрцөглөх хэрэггүй тоо байгаа юм. Хэрвээ та бүхэн энэ байгууллагаас гаргадаг дэлхийн авлигын газрын зургийг харвал Монгол Улс улаан өнгөнөөс салаагүй байгааг харж болно. Финлянд



улс 90 оноогоор нэгдүгээр байрт орж авлигын газрын зураг дээр шар өнгөөр улсаа будуулсан байна лээ. Финляндын төрийн оролцоотой үйл ажиллагааны 90 хувь нь цэвэр бол Монголын төрийн оролцооны 36 хувь нь цэвэр буюу үлдсэн 64 хувь нь авлигатай холбоотой гэсэн үг. Монгол Улс ядаж 40-50 оноотой болж байж дэлхийн улс орнуудын дундаж түвшинд хүрнэ шүү дээ. Дайн байлдаантай Сомали улсын төрийн үйл ажиллагааны 88 хувь нь авлигатай холбоотой гэсэн статистикаараа сүүлийн байрт орсон байсныг дурьдая.

Дээрх индексийн үр дүн Монголд төрийн оролцоо их, төр нь иргэдийнхээ эрх ашгийг хохироосон хэвээр байгааг харуулна. Төрийн оролцоо их байх тусам иргэдийн оролцоо багасч, эрх чөлөө нь хумигдаж энэ хэрээрээ авлига, хээл хахууль буурдаггүй зүй тогтолтой билээ. Төр авлигыг үүсгэдэг болохоос хувийн хэвшилд авлига гэж юу байхав. Авлига их байна гэдэг төрийн оролцоо их байна

гэсэн үг.

Эдийн засагт төрийн оролцоо ямар байна вэ?

АНУ-ын “Хэритэж” сан, “Уоллстрийт” сэтгүүл хамтран 184 улсын эдийн засгийн байдалд үнэлгээ хийж эдийн засгийн эрх чөлөөний индексийг гаргажээ. Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний 2012 оны индекс 61.5 болж, дэлхийн 183 орноос 81 дүгээр байрыг эзэлсэн юм. Өнгөрсөн онд манай улс 91 дүгээр байр эзэлж байв.

Хэдийгээр дэлхий дахин Монголыг эдийн засгийн эрх чөлөөгөө нэмэгдүүлж буй гэж үнэлж буй ч Монголын эдийн засаг сайн сайхан болчихоогүй байна. 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт 12.3 хувьтай гарч, ДНБ-ий хэмжээ 13.9 их наяд төгрөгт, нэг хүнд ногдох ДНБ 1.2 хувиар өсөн 4,8 сая төгрөгт хүрсэн ч инфляцийн жилийн өөрчлөлт 14 хувьтай, улсын төсөв болон гадаад худалдаа алдагдалтай байна.

Инфляцийг бууруулах чиглэлээр



бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжид тэгш очихгүй. Тодорхой салбаруудад төсөл болон зарцуулагдах тул бондын санхүүжилт бизнесийн шударга өрсөлдөөнд хамгийн их аюул учруулж байна. Төсөлд шалгарсан аж ахуйн нэгжүүд асар их хэмжээний санхүүжилт олж ашиг орлогоо нэмэгдүүлэх бол төслийн үйл ажиллагаанд оролцоогүй хэсэг хоосон хоцорно. Бизнесийн ижил нөхцөл, шударга өрсөлдөөн гэж утгаа алдаж байна. Нэг хэсэг нь бондын бага хүүтэй мөнгөөр, нөгөө хэсэг нь арилжааны банкны их хүүтэй мөнгөөр бизнесээ эрхлэх боллоо.

Засгийн газрын бондын санхүүжилт эдийн засагт ерөнхий утгаараа хэрэгтэй ч чухамдаа эдийн засаг дахь төрийн оролцоог 28,3 хувиар нэмэгдүүллээ гэж механикаар бодож болохоор юм. “Зах зээл өөрөө өөрийгөө зохицуулдаг” гэсэн үл үзэгдэх гарын онол Монголын эдийн засагт лав үйлчлэх болоогүй мэт. Төрийн оролцоо буураагүй цагт зах зээл өөрөө өөрийгөө зохицуулна гэж мэдээж байхгүй л дээ.

Хэвлэл мэдээллийн салбарт төрийн оролцоо ямар байна вэ?

1941 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ф.Рузвэлтийн дэмжлэгээр байгуулагдсан “Freedom house” төрийн бус байгууллагаас гаргадаг дэлхийн улс орнуудын хэвлэлийн индексээр Монгол 2013 онд 37 оноогоор хагас эрх чөлөөтэй оронд бичигдсэн байна.

1985 онд үүсгэн байгуулагдсан, Францын Парис хотод төвтэй “Хил хязгааргүй сэтгүүлчид” (Reporters Without Borders) хэмээх төрийн бус байгууллага жил бүрийн хэвлэлийн эрх чөлөөний индексийг мөн гаргадаг. Энэ байгууллагын 2013 оны хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол 179 орноос 29,93 оноогоор 98 дугаар байрт бичигджээ. 2005 оны үзүүлэлтээр Монгол Улс 53 дугаар байрт бичигдэж байжээ.

Эдгээр индексээс Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөө жилээс жилд хумигдаж байгаа гэж ойлгогдож байна. Хэвлэл мэдээллийн салбарт төр сэтгүүлчдийн эрх чөлөөг хязгаарласан хэвээр, хэвлэл мэдээллийн байгууллагыг бие даасан, хараат бус байлгах чиглэлээр анхаарахгүй байгаа гэж дээрх байгууллагууд үнэлж дүгнэсэн хэрэг.

Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлж ирсэн гол

хүчин зүйл бол “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” (1998 он) гэсэн ганц нүүр хууль байх боловч энэ хууль тунхаглал төдий хэвлэл мэдээллийн байгууллагад эрх олгож, үүрэг хүлээлгэсэн тодорхой зүйл байхгүй явдал юм. Мөн Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйл заалтыг үндэслэн сэтгүүлчийг нийтэлсэн зүйлийнх нь төлөө эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, шалгана хэмээн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг айлган сүрдүүлэх, дарамтлах явдал байсаар байна. Энэ нь хэвлэлийн эрх чөлөөнд төр ноцтойгоор халддаг, хэвлэх нийтлэх бодлогыг төрийн мэдэлд байлгах гэсэн сонирхол гэхээс өөр аргагүй.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний шинэ хуулийн төсөл хууль тогтоох байгууллагад хэлэлцэгдэх шатандаа яваа ч батлагдан гараагүй л байна. Магадгүй хэвлэл мэдээллийг чөлөөлөх улс төрийн хүсэл зориг одоогийн Монголын төрд байхгүй ч байж мэднэ. Өөрсдийг нь шүүмжилдэг, хууль бус, ёс зүйгүй үйлдлийг нь илрүүлэн гаргадаг хэвлэл мэдээлэлтэй байснаас үгээр нь байдаг, магтан дуулдаг, захиалга өгч болдог хэвлэлтэй байсан нь төрд хэрэгтэй байж мэдэх.

Ардчилалд бас төрийн оролцоо хэрэгтэй юу?

Их Британийн алдарт “The Economist” сэтгүүл 2006 оноос хойш дэлхийн улс орнуудын ардчилалын түвшинг тодорхойлон индекс гаргаж ирсэн билээ. Монгол улс 2006 онд уг индексээр 56, 2008 онд 58 дугаар байр, 2010 онд 64 дүгээр байр эзлээд байсан бол 2012 оны үзүүлэлтээрээ 167 орноос 6,35 оноогоор 65 дугаар байрт жагссан байна. Ардчиллын хэлбэрийн хувьд Монгол Улс “гажигтай” ардчилсан улс гэдэг ангилалд байна.

Энэ байгууллага сонгуулийн үйл явц, Засгийн газрын оролцоо, улс төрийн оролцоо, улс төрийн соёл, иргэний эрх чөлөөг үндэслэн улс орнуудыг үнэлдэг бөгөөд энэхүү индекс нь Монголын нийгмийн амьдралд улс төр, Засгийн газрын оролцоо үлэмж ихэсч улс төрийн соёл, иргэний эрх, эрх чөлөө хумигдаж байна гэсэн үнэлгээ гэж үзэхээс өөр аргагүй. Иргэний сонгох эрхээ эдэлдэг, ардчилалын дээд хэлбэр болсон сонгуулиа ч хийж чадахаа болиод байгаа шүү дээ.

Засгийн газар, Монгол банк хамтран гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулахаар дөрвөн чиглэлд хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн нь эдийн засаг дахь төрийн оролцоог бүр ихээр нэмэгдүүллээ. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ зах зээлээс биш чухамдаа төр засгаас хамаарахаар боллоо. Яг л социалист үе шиг өргөн хэрэглээний барааны үнийг төрөөс тогтоодог боллоо.

Засгийн газрын бондын 1,5 тэрбум долларын санхүүжилтийн асуудал бас л бизнес дэх төрийн оролцоог үлэмж ихээр нэмж байна. 2013 оны улсын төсөв 7,4 их наяд төгрөг бол энэхүү бондын санхүүжилт 2,1 их наяд төгрөг тул улсын төсвийн 28,3 хувьтай тэнцэх их мөнгө. Бондын мөнгө улсын төсвийн зарлага дээр бичигддэг гэж үзвэл улсын төсвийн алдагдал 2013 онд ямар болох нь ойлгомжтой. Үүнээс илүү эдийн засгийн аюул бол бондын мөнгөний асар их санхүүжилт

Ардчилалын хувьд бид нэг алхам урагш, хоёр алхам ухарч байна. Сүүлийн зургаан жилийн дотор бид урдаа есөн улсыг оруулчихлаа. Энэ бол ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжихгүй байгаа гэсэн үг. Хий хоосон яриа, дүр эсгэсэн ардчилагчид олонтой болчихжээ, Монголын төр.

Монголын “гажигтай” ардчилал, ямар гажиг байгаа тухай олон л хүн ярьдаг. Гэвч Монголын төр сонссон ч сонсоогүй юм шиг дүлий, харсан ч хараагүй юм шиг харалган царай гаргадаг болж.

Ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хуулийн засаглал гэж өглөө оройгүй ярих болсон манай төр хаашаа яваад байна вэ? Төрийн оролцоог хамгийн бага болгох тухай хамгийн их ярьдаг төр л өөрийн эрх мэдлээ хамгийн ихээр нэмэгдүүлдэг юм байна.

Энэ бүхнээс Монголын төрийн оролцоо хэрээс хэтэрчээ гэж дүгнэхээр байна. Бирмийн ардчиллын төлөө тэмцэгч Ан Сан Сү Чигийн “Дүр исгэсэн ардчилал дарангуйллаас илүү хортой. Нийгмийн гажуудлыг засахгүй байх

шалтаг болдог” гэж хэлсэн нь манай төрд илүү тохироод байх шиг.

Иргэн бүхэн өөрийн эрх ашгийн төлөө дуугарч, төрийг шахаж, өөрсдийн оролцоогоо нэмэгдүүлж төрийн оролцоог багасгахгүй бол төр өөрийн эрх мэдлээсээ сайн дураараа татгалзаж оролцоогоо багасгана гэдэг юу л бол. Бүр ч их нэмэгдүүлдэг байна.

Энэ төрийн үйл ажиллагаанд нийгмийн зүгээс тавих хяналтийг чангатгахгүй бол биднийг хөгжил дэвшлийн замд хөтлөх биш арагш чангаах боллоо. ■



Үндсэн хуулийн цэцийн дээр юу байдаг вэ?

Б.Цэцэнбилэг /Хуульч/

Өнөөгийн улс гэрийг, бүр бүх улсыг шударга бусаар жолоодоцгоож байгааг эцсийн бүлэгт олж харлаа. Адаглаад л тэдний жуурмуудын байдлыг засалцах боломжгүй. Ингээд надад жинхэнэ философи магтан дуулахаас өөр юм үлдсэнгүй,

Платон

Би Монгол Улсын иргэн. Үндсэн хуультай, Үндсэн хуульдаа хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгохоор тунхагласан Монгол Улсын иргэн. Үндсэн хууль тийм чухал зүйл мөн үү? гэж хэн нэгэн надаас асуувал би маш чухал зүйл гэж хариулна.

Яагаад гэвэл Үндсэн хууль гэдэг хуулиудын хууль юм. Тэгвэл хууль гэж юу юм бэ гэдэг асуулт урган гарч ирнэ. Хуулийг олон янзаар тодорхойлж болох ч миний хувьд хууль бол юуны өмнө “хууль нь нийгмийн гишүүдийн хоорондын тохиролцоо” гэдэг ойлголт илүү ойрхон тусаж байна. Тийм ч учраас хууль бидний эрхийг хязгаарлаж чадах тийм хүч бүхий хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичиг. Хууль төрийн албадлагын арга хэрэгслээр хэрэгждэг. Тиймээс хүний эрхийг, миний эрхийг тэр хууль эсвэл тэр хуулийг хэрэгжүүлж буй түшмэл зөрчиж болзошгүй учир хуулийн хууль болох Үндсэн хууль байдаг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль бол төр иргэддээ хэрхэн, ямар байдлаар хандах ёстой болохыг тодорхойлсон үндсэн “баримт бичиг”. Тиймээс Үндсэн хууль бол нийгэмд, иргэн бүрд нэн чухал хууль юм. Тэгвэл энэ хууль хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг “манаач” заавал хэрэгтэй болно. Төрийн байгууллага, албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд тэр шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэдгийг нь тогтоож, хүчингүй болгох үүрэг бүхий тийм “манаач” хэрэгтэй. Хэрэв тийм “манаач” байхгүй бол иргэд өөрийн Үндсэн хуульд заасан эрхээ хамгаалж чадахгүйд хүрнэ. Хаант, дарангуйлагч, коммунист гээд олон төрлийн засаглалтай орнуудад ийм хамгаалалт байдаггүйг бид мэднэ.

Ер нь Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай санаа нь төрийн эрх мэдэл хуваарилах онол болон дэлхий дахины анхны үндсэн хуулиудтай шууд холбоотой.

XVIII зууны үед Ш.Монтескье, Ж.Локк нарын сэтгэгчид төрийн эрх мэдлийг хуваарилах онолоо боловсруулж түүний үзэл баримтлалын дагуу 1787 онд АНУ болон Франц, Герман зэрэг орны Үндсэн хуулиуд батлагдан гарсан байдаг.

Монтескьегийн үзлийн дагуу Францын хуульч-эрдэмтэн Б.Констант үйл ажиллагааг Үндсэн хуулийн хяналтын онолыг бий болгон хөгжүүлсэн билээ. Тэрээр төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж хуваасан нь ихээхэн ач холбогдолтой боловч тэдгээрт хөндлөнгийн хяналт зайлшгүй тавигдах ёстой гэж үзсэнээр үндсэн хуулийн хяналтын тухай асуудлыг анх гаргаж ирсэн гэж үздэг юм байна. Ингэснээр аливаа улсын үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавьж түүний хэрэгжих гол баталгаа болох Үндсэн хуулийн шүүх бий болох үндэс тавигджээ.

Монгол Улсын хувьд бол тэр “манаач” нь Үндсэн хуулийн цэц юм. Үндсэн хуулийн цэцийг шүүх мөн эсэхэд одоог хүртэл судлаачид маргадаг. Харин би “манаач” гэж нэрлэж байна. Яагаад гэвэл Үндсэн хуулийн цэц Монгол Улсад Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг “Үндсэн хууль зөрчсөн” гэсэн үндэслэлээр хүчингүй болгох эрхтэй цорын ганц байгууллага. Харин Үндсэн хуулийн “манаач” маань үүргээ хэрхэн биелүүлж байгааг ямар хэмжүүрээр дүгнэж болох вэ?

Үндсэн хуулийн хяналтийг хэрэгжүүлнэ гэдгийг юу гэж ойлговол зохилтой вэ?

Миний хувьд энэ удаа хуулийн нарийн заалт, онолын тухай бичихийг зорьсонгүй. Иргэний, жирийн хуульч хүний хувьд дүгнэлт өгөхийг хүслээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оны долоодугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан бөгөөд байгуулагдсанаас хойш 21 жил болсон байна. Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг учир “Үндсэн

хуулийн цэцийн дээр зөвхөн хөх тэнгэр байдаг” гэх хэллэг гарсан. Үнэхээр Үндсэн хуулийн цэцийн дээр зөвхөн хөх тэнгэр байдаг гэж үү?

Миний хувьд үүнтэй санал нийлэхгүй байна. Үндсэн хуулийн “манаач” болох Үндсэн хуулийн цэц маань миний дээр “бидний дээр хөх тэнгэрээс өөр юу ч байхгүй, төр ч байхгүй, иргэн ч байхгүй” гэх үзлээр үйл ажиллагаа явуулах учиргүй. Иргэдийн эрхийн баталгаа болсон Үндсэн хуулийн “манаач”-ийн дээр иргэдийн эрх ашиг, заяагдмал эрх байх ёстой. “Манаач” Үндсэн хуулиар иргэдэд олгосон, баталгаажуулсан эрхийн эсрэг төрийн аливаа санаархал болгоныг таслан зогсоох тийм байгууллага байх ёстой. Ингэж чадахгүй бол тэр “манаач” байх шаардлага ч байхгүй байх.

Гэтэл одоо “манаач” иргэдийнхээ хуулиар олгогдсон эрх ашгийг хамгаалан ажиллаж чадаж байна уу?

Шударга байгаа эсэхэд үнэлэлт өгөхөд хэцүү. Шударга байна гэж юу гэсэн үг вэ? гэдэгт эрт дээр үеэс л маргалдсаар өнөөдрийг хүрчээ. Тиймээс би дээр дурьдсан ганцхан хэмжүүрээр, ард түмний эрх ашиг, заяагдмал эрхийг хамгаалж чадаж байгаа эсэхэд анхаарал хандуулж байна.

Хууль тогтоох байгууллагаас сүүлийн хэдэн жилд иргэдийн хувийн өмчийн эрхэд халдсан хэд хэдэн хууль батлагдан гарлаа. Заримыг иргэн Үндсэн хууль зөрчсөн, бүүр тодорхой хэлбэл тэдгээр хуулийг баталж гаргасанаар Төр нь иргэдийн өмч өмчлөх эрхийг хамгаалах үүргийг Үндсэн хуулиар хүлээсэн атлаа эсрэгээр нь буюу өмч өмчлөх эрхэнд халдлаа гэж үзээд цэцэд гомдол гаргасан. Гэтэл Үндсэн хуулийн цэц Улсын их хурал хууль батлах эрхтэй учир Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг гаргаж байна.

Асуудлыг ийм өнцөгөөс харж, хандаж, шийдвэрлэх юм бол “манаач” маань нүдээ боогоод сууж байгаатай ялгаагүй. “Манаач” байна уу гэвэл байна. Гэхдээ нүд нь боолттой байвал хэрэггүй шүү дээ.

Мэдээж Улсын их хурал хууль батлах эрхтэй гэдэгтэй хэн ч санал нийлнэ. Үүнтэй санал нийлэхгүй байгаадаа иргэд Үндсэн хуулийн цэцэд хандаж өргөдөл, мэдээлэл гаргаад байгаа юм биш. Гагцхүү тэр хууль Үндсэн хуульд нийцэж байна уу үгүй юу? Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг зөрчиж байна уу, үгүй юу? гэдэгт анхаарлаа хандуулан шийдвэр гаргах учиртай. Миний өмчийг хууль тогтоогч хэзээ ч хамаагүй хууль гаргаад булаагаад авчих боломжтой, тэрийг нь нөгөө “манаач” хараагүй юм шиг байвал би өөрийгөө ардчилсан нийгэмд амьдарч байгаа гэж мэдэрч чадахгүй.

Аливаа маргааныг хуулийн дагуу шийдэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөхөд хэцүү байдаг. Энэ нь хуулийн зүйл заалтыг тодорхойлж байгаа ойлголтуудыг тайлбарлан ойлгохдоо хүмүүс өөр өөр байдагтай холбоотой. Шүүгч, маргаан шийдвэрлэгчид бас ойлголтын зөрүүтэй байдаг учир цагаан дээр хараар бичигдсэн тэр хуулийн зүйл, заалтыг өөр өөрөөр тайлбарлан ойлгож, хэрэглэж, шийдвэрлэдэг. Гол учир нь энэ.

Яг л энэ шийдвэр гаргах торгон зааг дээр “манаач” нар суудаг бөгөөд энэ үед л тэд иргэд, тэдний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавьж шийдвэрээ гаргаж байхыг л би хүсэж байна. Хуулийн заалтыг ойлгож тайлбарлахдаа ч мөн адил.

Хүн төрлөхтний түүхэнд шударга шийдвэрийн сонгодог

жишээ болсон нэгэн түүх байдаг. Мэргэн Саламон хаан дээр хоёр эмэгтэй ирээд нэг хүүхдийг хоёулаа миний хүүхэд гэж маргаад байж гэнэ.

Соломон хаан хүүхдийг хоёр хуваахыг тушаадаг. Үнэн хэрэгтээ хаан хүүхдийг үхлээс хамгаалан өөрийнхөө шаардлагаас татгалзсанд нь хүүхдийг өгөхийг хүссэн бөгөөд яагаад гэвэл тэр эмэгтэй нь хүүхдийг чин сэтгэлээсээ хайрладаг

байх ёстой гэж боджээ.

Эрхэм хүндэт Үндсэн хуулийн “манаач” нар минь. Та бүхэн дээр жирийн нэгэн ард, “ шүдээ хүртэл зэвсэглэсэн” эрх мэдэлтэй албан тушаалтан хоёр очиж маргаанаа шийдвэрлүүлдэг. Энэ үед та шударга байж, таны дээр зөвхөн хөх тэнгэр бус иргэний, иргэдийн ЭРХ АШИГ байдаг юм шүү гэдгийг л хэзээ ч битгий мартаарай. ■

Хүний эрх, эрх чөлөө өчигдөр ба өнөөдөр

Г.Агар-Эрдэнэ /Хуульч/

Хүний эрх чөлөө. Энэ бол өргөн хүрээтэй, ээдрээ төвөгтэй сэдэв юм. Эрх чөлөөг үе үеийн эрдэмтэд, судлаачид өөр өөрсдийн үзэл хандлагаар тайлбарлаж, таниулсаар ирсэн билээ.

Ерөнхий утгаараа хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм. Өнөөдөр хүний эрхийг хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаасаа үл хамааран эдэлбэл зохих боломж, харин эрх чөлөөг тэдгээр боломжуудаа хэрэгжүүлэх талбар гэж ойлгож байна. Тэгвэл эрх чөлөөгүйгээр хүн ямар нэгэн эрх эдэлж, үүрэг хүлээж чадахгүй байх нь.

Хүн бүр төрсөн цагаасаа эхлээд эрх чөлөөтэй, тэгш эрхтэй, мөн салгаж үл болох жам ёсны эрхтэй байх ёстой гэсэн үзэл санаа XVII, XVIII зуунд Америк, Европыг дамнасан хувьсгалын явцад батлагдаж, анхны Үндсэн хуулиудын үндэс болсон түүхтэй. Үүнээс хойш бусад орон өөрийн улсаа ардчилсан улс гэж нотлохын тулд үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсоор иржээ.

Сонгодог сэтгэлгээний үеийн эрх чөлөө

Хувь хүний бие даасан байдал бол эрх чөлөөний үндсийн үндэс юм. Эрх чөлөөний үнэт зүйлсийн талаарх сонгодог ойлголтыг гарган илэрхийлж олноо алдаршсан онолч Жон Стюарт Милль “Эрх чөлөө гэдэг бол хүн бүр

бусдын оролцоогүйгээр хийх зүйлээ сонгох боломж мөн. Хүн бүр бусад хүний эрх чөлөөнд хугалдан оролцохгүй л бол өөрийн санаснаар амьдралаа тохинуулах эрхтэй” гэсэн байдаг.

Түүхийн ихэнх цаг хугацаанд төр нь иргэдийнхээ сайн сайхан оршихуй, хүмүүнлэг нийгмийг цогцлуулахын тулд оршин тогтнодог гэж үзсээр, түүний төлөө тэмцсээр ирсэн билээ. Хөгжлийн эхэн үед эрх чөлөөг зөвхөн хаад ноёд, эрхэм дээдсийн эдлэх ёстой тусгай эрх гэж ойлгож байлаа. Жишээлбэл, хүчирхэг хаант төрийг хөхиүлэн дэмжигч, хааны эрх мэдэл бол тэнгэрийн эрх мэдэл юм хэмээн тайлбарлаж, энэхүү эрх мэдлийн эх үндсийг хүний өвөг эцэг Адам, Эвагаас үүсэлтэй хэмээн сурталчилдаг байсан Английн улс төрийн онолч Роберт Филмер “Хаант засаг бол нэг ёсондоо эцгийн эрхэт ёстой адил юм. Улсын ард иргэд бол хааны хүүхдүүд бөгөөд эдгээр хүүхдүүд дуулгавартай, бас нэг хэсэг нь сахилгагүй байх нь мэдээж.

Харин эрх чөлөө бол өрх гэрийн өмч хөрөнгө юм. Тэрхүү айлын өрхийн тэргүүн буюу хаан нь өмч хөрөнгөөсөө үр хүүхдүүддээ хувь хүртээх эсэх нь түүний эрх юм” гэсэн байдаг. Түүнчлэн тухайн цаг үед амьдарч, үзэл санаагаа хөгжүүлж байсан сэтгэгч Томас Хоббс мөн адил төрийн эрх мэдэл хэдий чинээ их байна, төдий чинээ иргэдийн эрх, эрх чөлөө их байна, түүнээс хамаарч иргэд

эрх чөлөөтэй байх эсэх нь шийдэгдэнэ гэсэн үзлээ сурталчилж байв. Төрийг дөвийлгөж, иргэдээ хоёрдугаарт тавьж байсан энэ цаг үеийг нар дэлхийг тойрдог гэж мухайрлан ойлгож байсан “бүдүүлэг” үетэй жишиж болох юм.

Харин эрх чөлөөний үзэл санаанд асар том хувьсгал хийж, эрх чөлөө бол хүнээс салшгүй зүйл гэсэн ойлголтыг бий болгосон гавьяатан бол Жон Локк юм. Тэрээр “Хуулийн зорилго бол эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлахад оршдоггүй, харин ч түүнийг хамгаалж, өргөжүүлэх явдал мөн” гэж үзсэнээрээ төрийн эрх мэдэл нь хувь хүний эрх чөлөөг хангахад оршдог болохоос бус түүний учир шалтгаан, уг үндэс нь биш юм гэсэн ойлголтыг гаргаж ирсэн билээ. Ийнхүү эрх чөлөө болон төрийн хоорондын харилцааны шийдвэрлэгч нөхцөл шалтгааныг эрс ялгаатай, сөргүүлэн авч үзсэнээрээ Жон Локк ард түмний дунд ихэд алдаршиж, басхүү төрийн зүгээс ихээхэн шүүмжлэлтэй тулгарч байлаа. Гэвч түүний үзэл санаа хүчээ авч, төрийн үүрэг нь хувь хүмүүсийн эрх чөлөөг хангах явдал мөн хэмээх үзэл санаа газар сайгүй түгэн тархсан байдаг.

Тэгвэл хувийн ашиг сонирхол, нийтийн үйл хэргийн нарийн холбоо, уялдааг эрх чөлөөтэй холбон тайлбарлаж, эрх чөлөөний философийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан сэтгэгч Георг Фридрих Гегель чөлөөт хүсэл зориг

гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. “Хүн ёс суртахууны хувьд бие даасан байдлаа олж, өөрөө өөрийгөө чөлөөтэй удирдаж, эрх зүйд захирагдаж чаддаг болсон цагт тэр хүн чөлөөт хүсэл зоригтой буюу жинхэнэ эрх чөлөөтэйд тооцогдоно” гэж үзсэнээрээ тэрээр хувь хүн юу хүсч байгаагаа, юунд тэмүүлэх, зорих ёстойгоо зөвхөн энэ нийгэмд л мэдэх, тодорхойлох боломжтой болохыг ойлгуулахыг эрмэлзжээ. Энэ бол эрх чөлөөний үнэт зүйлсийн хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн цаг үе бөгөөд уламжлалт ойлголтоосоо дахин нэг шатаар урагшилсан явдал байлаа.

Өдгөө эрх чөлөө гэх энэ ойлголт орчин цагийн ардчилсан улсуудын оршин тогтнохуйн үндэс, нийгмийн ёс суртахууны үнэт зүйлс болон нэгэнт хэлбэржжээ.

Мэдээллийн эрин зуун дахь эрх чөлөө

Хүний эрх, эрх чөлөө цаг ямагт хувьсан өөрчлөгдөж, шинэ эрхүүдээр баяжиж, нэмэгдэж байдаг бөгөөд энэ нь өнөөдөр шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэржилт, даяарчлалын хүчин зүйлсээс хамаарч байна. Өдгөө улс бүрийн үндсэн хуульд бичигдсэн хүний эрхүүд нь хүний эрх чөлөөний үзэл санааны хөгжлийн үр дүн юм.

Эрх чөлөө жинхэнэ утгаараа зөвхөн ардчилсан нийгэмд л оршин тогтнож чадахыг бүгд мэддэг болсон. Хүний эрх чөлөө нь хүнээс салшгүй зүйл, төрийн хувьд хувь хүний эрх чөлөөг хангах үүрэгтэй, хүн бүр ардчилсан нийгэмд өөрийн эрх чөлөөгөө эдэлж, зорилгоо тодорхойлж болохыг бүгд ухамсарлаж буй хэдий ч өнөө цагт өрнөж буй эрчимтэй өөрчлөлт, шинэчлэлүүд нь эрх чөлөөний талаарх сонгодог ойлголтыг цаг үеэ даган улам бүр боловсронгуй болгох ёстойг сануулсаар байна. Үүний нэг нь мэдээлэлжсэн эрин буюу XXI зуун дахь эрх чөлөөний асуудал юм. Мэдлэг хүний эрх мэдэл буюу эрх чөлөөг тодорхойлдог цаг үе ирж, хаалга тогшиж байна.

Эртний Грекийн гүн ухаантан Зенон “Эрх чөлөө гэдэг бол ухаантан мэргэдийн л олж авдаг тэр нөхцөл юм. Бусад хүнд эрх чөлөө хүртээлгүй” гэсэн байдаг. Тухайн үед Афины иргэд “Та юунд ийм үг хэлнэ вэ” хэмээн түүнийг шүүмжилж, буруушааж байв. Тэгвэл Зенон “Хүн эрх чөлөөгөө эрдэм

Америкийн номлогч, эрдэмтэн Уильям Эллери Чэннинг “Эрдэм мэдлэг бол эрх чөлөөний ноён нуруу”

мэдлэг, боловсролгүйгээр бүрэн дүүрэн эдэлж чадах билүү. Би тийм гэж бодохгүй байна. Хэрэв Афины иргэд эрдэм мэдлэгт шунан тэмүүлж, өндөр боловсрол эзэмшиж чадах аваас хүссэн хүсээгүй эрх чөлөө гарт тань баригдана” хэмээн сануулж байсан нь өнөөдөр үнэ цэнэтэй ажээ. Фридрих Хаек “Ардчилсан нийгмийн нэг сайн тал бол мэдлэгийн өрсөлдөөн юм” гэсэн байдаг. Мэдлэг нь хүн бүрийн оюун санааг дамжин түгэн тархаж байдаг бөгөөд эрх чөлөөтэй нэгэн адил түгээмэл зүйл байх учиртай.

Энд хамгийн чухал зүйл эрх чөлөө, эрдэм мэдлэг хоёрын харилцан уялдаа холбооны асуудал юм. Эрх чөлөө нийгэм дэх аливаа үнэт зүйлсийн үндэс болдог учраас хамгийн үнэ цэнэтэй зүйл.


Өөрөөр хэлбэл, хүн өөрөө өөрийнхөө эзэн нь байж, сонгосон замаараа амьдрах боломж нь эрх чөлөө юм. Тэгвэл мэдлэг мөн адил хувь хүнийг чухам хэн бэ гэдгийг тодорхойлж, нийгэмд эзлэх түүний байр суурь, ирээдүйг тодорхойлж байна. “Хүн юуны тулд мэдлэгт тэмүүлэх ёстой юм бэ?” гэсэн асуултад “Эрх чөлөөтэй байхын тулд” гэсэн хариулт л онож очих бизээ. Товчхондоо, эрх чөлөөгөө мэдэрье гэвэл мэдлэг, мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа хэн бүхэн мэдлэггүй байх эрхгүй юм. Италийн соён гэгээрүүлэгч, сэтгэгч Чезаре Беккариа “Гэмт хэрэг ба ял шийтгэлийн тухай” хэмээх бүтээлдээ “... эрх чөлөөг эрдэм мэдлэгийн хамт түгээн дэлгэрүүл. Соёл гэгээрэлтэй муу үйл урвуу, харин сайн үйл шууд хамааралтай байдаг. Бусдыг залилан мэхлэгчид ямагт хүмүүсийн бүдүүлэг харанхуйг далимдуулдаг бөгөөд ухаарч гэгээрсэн хүмүүс тэднийг илчилж орхидог юм. Ард олон гэгээрлийн үр шимийг хүртэхээрээ үг дуугүй хүлцэн дагахаас татгалзаж, эрх мэдэлтэнд шүтэхийг болиод оронд нь хуулийг өргөмжилж, түүний хүч нөлөө хөдлөшгүй болон тогтдог” гэжээ. “Мэдлэг, боловсрол эрх чөлөөг буутай цэргээс илүү манадаг” гэсэн үгийн утга учир энэ буюу.

Өнөө цагт хүний эрхийн салбарт л гэхэд мэдээлэл авах, хөгжих, шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх гэх мэт шинэ тутам бий болсон эрхүүд улам бүр ач холбогдолтойд тооцогдох болжээ. Энэ зууныг шинэ технологи, мэдээллийн асар том урсгалын эрин зуун хэмээн тодорхойлж байна. Тиймээс Америкийн номлогч, эрдэмтэн Уильям Эллери Чэннинг “Эрдэм мэдлэг бол эрх чөлөөний ноён нуруу” гэж хэлснийг энд дахин сануулахад буруудахгүй бизээ.

Хүний эрх чөлөө. Энэ бол өргөн хүрээтэй, ээдрээ төвөгтэй сэдэв юм. Эрх чөлөө нь хүнд төрөлхөөс заяагдсан зүйл агаад мөн чанараараа хүн бүр өөрийн амьдралаа өөрийн хүссэнээр авч явах, ийнхүү амьдрахдаа бусдын амьдралыг үгүйсгэхгүй, түүнд нь саад бэрхшээл учруулахгүй байхыг хэлдэг. Тэгвэл мэдээллийн эрин зуунд хүн бүр бусад хүний эрх чөлөөнд хутгалдахгүй, өөрийн дураар, хэрхэн амьдрахаа шийдэх эрхтэй байхын тулд мэдлэгтэй байх шаардлага зайлшгүй тавигдаж байна.■



ТАНЫ ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИТГЭЛТ ЗӨВЛӨХ



Бид 2012 оноос Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) болон АНУ-ын Securities Exchange Commission (“SEC”)-ын зохицуулалтаар олон улсын хөрөнгийн зах зээл дээр үнэт заасны арилжаа эрхлэх, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээг харилцагчиддаа амжилттай үзүүлж ирлээ.

Хэрвээ Та

- Олон улсын хөрөнгийн зах зээлд өөрийн хөрөнгийг удирдах ,
- Хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбогдоорой.

MONGOLIAN ECONOMY

MONGOLIAN ECONOMY
Mongolia's Economy and Business Magazine
May, 2013, №09 (043)
"Don't expect others to ask to dance"
Partners Linked Through History
www.mongolianeconomy.mn



Гүнзгий мэд

Утас: 70115476, 70115477, 94092904, 94092905
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn

“ТЭНҮҮН АМЬДРАЛ”

тэтгэврийн хуримтлалын даатгал



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ

- Өнөөдөр хийж бүтээх ид насандаа яваа Танд тэтгэвэр гэдэг үг хэтэрхий хол тэртээх 20, 30 жилийн дараах асуудал шиг санагдаж байна уу?
- Өнөөдөр өөрийн тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэхэд хэтэрхий эрт гэж Та бодож байна уу?
- Улсаас олгох тэтгэврийн хэмжээ таны амьдралд хүрэлцэх үү?

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД ХЭН ДААТГУУЛЖ БОЛОХ ВЭ?

- Нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэд
- Нийгмийн даатгалын тэтгэвэр нь ирээдүйн амьдралд хүрэлцэхгүй гэж үзэж байгаа хүмүүс

ДААТГАЛЫН ХАМГААЛАЛ

Таныг тэтгэврийн хуримтлал үүсгэх хугацаанд дараах даатгалын хамгаалалт үйлчилнэ.

- Та тэтгэврийн хуримтлал үүсгэх хугацаандаа гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд Таны цаашид сар бүр төлөх байсан даатгалын хураамжийг гэрээний хугацаа дуусах хүртэл даатгалын компаниас хариуцаж төлнө.
- Та тэтгэврийн хуримтлал үүсгэх хугацаандаа гэнэтийн ослын улмаас амь насаа алдвал Таны нэр дээр үүссэн тэтгэврийн хуримтлалыг 2 дахин нэмэгдүүлж Таны гэр бүлд олгоно.